



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 09-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-7
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	8-71

1.Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл	8-10
2.Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, үргэлжилнэ/	10-47
3.“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоол	47-71

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
10 дугаар сарын 09-ний өдөр /Пүрэв гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 78 гишүүн хүрэлцэн ирж, 61.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 03 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: С.Зулпхар;

Чөлөөтэй: С.Амарсайхан, Ц.Мөнхтуяа;

Эмнэлгийн чөлөөтэй: Ч.Анар, Ц.Баатархүү, Б.Бат-Эрдэнэ, Ж.Бат-Эрдэнэ, Х.Болормаа, С.Замира, М.Сарнай;

Тасалсан: Б.Батбаатар, Х.Баттулга, С.Ганбаатар, Л.Гантөмөр, Х.Ганхуяг, Б.Жавхлан, С.Лүндэг, Ц.Туваан;

Хоцорсон: Т.Аубакир-04 минут, Д.Батлут-16 минут, Ж.Батсуурь-07 минут, Н.Батсүмбэрэл-1 цаг 54 минут, Б.Батцэцэг-48 минут, Э.Болормаа-23 минут, Г.Ганбаатар-54 минут, П.Ганзориг-01 минут, Ц.Даваасүрэн-09 минут, Т.Доржханд-21 минут, Б.Жаргалан-2 цаг 20 минут, Л.Мөнхбаясгалан-02 минут, П.Мөнхтулга-04 минут, Н.Номтойбаяр-14 минут, Г.Очирбат-08 минут, Б.Пунсалмаа-21 минут, Д.Рэгдэл-04 минут, Б.Түвшин-16 минут, А.Ундраа-16 минут, Н.Учрал-08 минут, Г.Уянгахишиг-2 цаг 55 минут, О.Цогтгэрэл-02 минут, Б.Чойжилсүрэн-10 минут, Л.Энх-Амгалан-2 цаг 55 минут, Б.Энхбаяр-2 цаг 01 минут, Ж.Энхбаяр-2 цаг 00 минут.

Нэг.Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал нар байлцав.

Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудал санал хураалтаар үргэлжлэв.

Х.Булгантуяа: 1.Байнгын хорооны саналаар Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 32

Бүгд: 89

64.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

Х.Булгантуяа: 1.Байнгын хорооны саналаар Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55

Татгалзсан: 34

Бүгд: 89

61.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

2.Байнгын хорооны саналаар Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 32

Бүгд: 89

64.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

3.Баяжуулсан хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59

Татгалзсан: 31

Бүгд: 90

65.6 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

4.Байнгын хорооны саналаар Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60

Татгалзсан: 30

Бүгд: 90

66.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

5.Байнгын хорооны саналаар Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 33

Бүгд: 90

63.3 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

6.Байнгын хорооны саналаар Зөрчлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 33

Бүгд: 90

63.3 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

7.Байнгын хорооны саналаар Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58

Татгалзсан: 32

Бүгд: 90

64.4 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

8.Байнгын хорооны саналаар Органик бүтээгдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59

Татгалзсан: 31

Бүгд: 90

65.6 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

9.Байнгын хорооны саналаар Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 33

Бүгд: 90

63.3 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

10.Байнгын хорооны саналаар Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59

Татгалзсан: 31

Бүгд: 90

65.6 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

11.Байнгын хорооны саналаар Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59

Татгалзсан: 31

Бүгд: 90

65.6 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

12.Байнгын хорооны саналаар Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58

Татгалзсан: 33

Бүгд: 91

63.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 18 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, үргэлжилнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Л.Гангэрэл, Ж.Дэлгэрсайхан, Н.Ууганбаатар, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Х.Сүрэнхорол, Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Анар, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлогын газрын дарга Т.Баясгалан, Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнхтөр, Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, мөн газрын Эдийн засгийн эрх чөлөө, өрсөлдөх чадварын судалгааны хэлтсийн дарга Ц.Мөнхдэлгэр, Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга П.Чандмань, Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга Б.Төгөлдөр, Ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн дарга Б.Мөнх-Эрдэнэ, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга Ш.Бат-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан нар байлцав.

Төслийн хоёр дахь хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодоос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал танилцуулав.

Байнгын хороодын санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар, С.Эрдэнэболд, Б.Мөнхсоёл, Ж.Батжаргал, Ж.Ганбаатар, Л.Соронзонболд, Ц.Мөнхбат, Ч.Номин, Ж.Галбадрах, Л.Мөнхбаясгалан, П.Мөнхтулга, Б.Түвшин, Ө.Шижир, О.Саранчулуун нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Боловсролын сайд П.Наранбаяр, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./12:28/

Уг асуудлыг 12 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монголбанк 2025.09.30-ны өдөр ирүүлсэн/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, мөн банкны Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваа, Хууль, эрх зүйн газрын захирал Д.Аюуш, Судалгаа, статистикийн газрын захирал Д.Даваасүх, Санхүүгийн зах зээлийн газрын захирал А.Энхжин, Төлбөр тооцооны газрын захирал Э.Анар, Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газрын Эрсдэлийн үнэлгээний хэлтсийн захирал Г.Борхүү нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн тайланг Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу нар танилцуулав.

Үдээс өмнөх хуралдаан 2 цаг 55 минут үргэлжилж, 12 цаг 58 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 02 минутад эхлэв.

Тайлан болон шийдвэрийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, Р.Сэддорж, А.Ариунзаяа, Л.Соронзонболд, С.Цэнгүүн, М.Мандхай, Ж.Энхбаяр нарын тавьсан асуултад Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Э.Батшугар, Л.Соронзонболд, Г.Очирбат нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./14:52/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Бусад: Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн гишүүд ширээн дээрээ “Урсгал зардлаа бууруул, цалин тэтгэврээ нэмье”, “Эрх баригчид баян, иргэд ядуу байна”, “Засгийн газар авлигатай бодитой тэмц”, “Ахмадуудын тэтгэврийн доод хэмжээг 1.5 сая төгрөг болгох бүрэн боломжтой”, “Г.Занданшатарын эзэнгүйдсэн төсвийг буцаа”, “Д.Амарбаясгалан УИХ-ыг удирдах ёс суртахууны эрхгүй” гэсэн лоозонгуудыг тавьсан байв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Чуулганы хуралдааны хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 3 цаг 45 минут үргэлжилж, 126 гишүүнээс 108 гишүүн хүрэлцэн ирж, 85.7 хувийн ирцтэйгээр 14 цаг 52 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 10 дугаар сарын 09-ний өдөр,
Пүрэв гараг Төрийн ордон “Их хуралдай” танхим 10 цаг 03 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. өнөөдөр ирц 61.9 хувьтайгаар 2025 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сарын 9-ний өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанаар дараах 3 асуудлыг хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Хоёрдугаарт, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулна.

Гуравдугаарт, Төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ ээ.

Эхний асуудалдаа оръё. [Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.](#)

Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан байгаа.

Байнгын хорооны саналаар Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна аа.

Улсын Их Хурлын гишүүд чуулганы танхимдаа орж ирж санал хураалтдаа оролцоорой. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Өглөөний ирцийн санал хураалт явуулъя.

Гишүүд хуруугаа уншуулж санал хураалтад бэлтгээрэй. Ирцийн санал хураалт. 43 байна.

Одоо Байнгын хорооны саналаар Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэхийг дэмжих эсэх санал хураалт явуулна.

Түрүүн ирцийн санал хураалт явууллаа. Ингээд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

Улсын Их Хурлын гишүүдийн 64 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

Гишүүдийн 61.8 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт. Гишүүдийн 64 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

Баяжуулсан хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

Гишүүдийн 65.6 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Ерөнхий боловсролын сургуулийн Хоол үйлдвэрлэл үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураая.

Санал хураалт.

Гишүүдийн 66.7 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

Гишүүдийн 63.3 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Зөрчлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

Гишүүдийн 63.3 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Нялх балчир хүүхдийн хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

64.4 хувиар санал дэмжигдлээ.

Органик бүтээгдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

Гишүүдийн 65.6 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Органик бүтээгдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор аан энэ хураачихсан.

Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

63.3 хувь дэмжиж санал дэмжигдлээ.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

65.6 хувиар санал дэмжигдлээ.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

65.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ургамлын эрүүл мэнд, ургамлын ургамал хамгааллын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

63.7 хувиар санал дэмжигдлээ.

Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо болон холбогдох бусад Байнгын хороонд шилжүүллээ.

10.18 цаг

Дараагийн асуудалдаа оръё. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаас гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Батжаргалын Заяабал танилцуулна аа. Индэрт урья.

Б.Заяабал: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 9 дүгээр сарын 15, 17, 18-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хийж, 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороо, бусад байнгын хороодод шилжүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2-т заасны дагуу Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд 2025 оны 9 дүгээр сарын 29, 30-ны өдөр, 10 дугаар сарын 1-ний өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулж, санал, дүгнэлт гарган Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаанд танилцуулсан болно оо.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хийх үед хуралдаанд оролцсон Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж санал гараагүй байна.

Хууль зүйн байнгын хороо, Төрийн байгуулалтын байнгын хороо, Өргөдлийн байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хэлэлцэх үед хуралдаанд оролцсон гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй бөгөөд ХЗБХ-ны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг төрийн албан хаагчдын орон тоог 9 хувиар бууруулах бодлогын хэрэгжилт болон төсвийн урсгал зардлыг бууруулснаар хууль шүүхийн байгууллагуудын үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлөх талаар, Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Саранчулуун Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийг төсөлд тусгах боломжтой эсэх, Өргөдлийн болон Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Мөнхтуяа, Эрдэнэбат нар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдлийн тэнцвэржүүлсэн орлого зарлагын хэмжээг нэмэгдүүлж инфляцын түвшинтэй уялдуулан багш, эмч, нарын цалин, ахмад настны тэтгэврийг нэмэгдүүлэх боломжтой эсэх, 2026 оныг Боловсролыг дэмжих жил болгон зарласантай холбогдуулан явуулах бодлого үйл ажиллагааны талаар болон Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлд төсвийн урсгал зардлыг бууруулж ДНБ-ий 24 хувиас хэтрүүлэхгүй байхаар заасныг өөрчилж нэмэгдүүлэн тогтоох боломжтой эсэх талаар асуулт асууж хариулт авсан байна аа.

Хуулийн төслийг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Мөнхтуяа Боловсролын салбарын багш, ажилтны цалин хөлс, нийгмийн баталгааг дээшлүүлэх зорилгоор Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд дэх нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ 2026 онд 31 их наяд 600 тэрбум төгрөг гэснийг 490 тэрбум төгрөгөөр, нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээг 2026 онд 32 их наяд 980 тэрбум гэснийг 480 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлж үүнтэй уялдуулан холбогдох эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд болон харгалзах ДНБ-д

эзлэх хувь хэмжээнд өөрчлөлт оруулах гэсэн зарчмын зөрөөтэй санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй байна.

Улсын Их Хурлын Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн хамтарсан хуралдаанаараа дээрх хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын хуралдааны чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39, 64 дүгээр зүйлд заасныг баримтлан явуулж тараах санал дүгнэлтийг гарган та бүхэнд танилцуулж байна аа.

Хуулийн төслийг Байнгын хороодын хамтарсан хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ганбаатар Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төсвийн төсөл нь алдагдалгүй төсөв батлах бодлогын зорилтоосоо ухарсан, Төсвийн тухай хуульд нийцээгүй, дунд болон богино хугацааны төсвийн төлөвлөгөөнд үндэслээгүй, нийгмийн хүлээлт шаардлагад нийцээгүй, дагалдах тооцоо судалгаа хангалтгүй байгаа зэрэг байгаа тул Засгийн газарт буцааж сайжруулах нь зүйтэй гэж, Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар төсвийн хүрээний мэдэгдэл төсвийн төслийг хэлэлцэж байхад Засгийн газрын гишүүд Байнгын хорооны хуралдаанд бүрэн оролцох ёстой гэсэн саналуудыг хэлж, Улсын Их Хурлын гишүүн Ч.Номин Засгийн газраас боловсруулж байгаа Татварын багц хуулиудын өөрчлөлтөд Сангийн яамны тооцоолсноор улсын төсөвт 4 их наяд төгрөгийн нөлөө үзүүлэхээр байна гэсэн Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Булгантуяа 5 жилийн төлөвлөгөөний төслийг Засгийн газар 10 дугаар сарын 30-аас өмнө Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулиар зохицуулсныг сануулж төсвийн төслийг жил бүрийн 9 дүгээр сарын 1-нд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хуулийн өөрчлөлт хэрэгжиж, жил гаруйн хугацаа өнгөрөөд байхад эдгээр цаглаврын зөрчлийг арилгахтай холбоотойгоор авсан арга хэмжээний талаар асуулт асууж, хариулт авлаа.

Хамтарсан хуралдаанаар хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй бөгөөд Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулахад тус Байнгын хорооны дэмжээгүй саналыг хамтарсан хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаас гаргасан санал, дүгнэлт зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Х.Булгантуяа: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Ням-Осорын Учрал Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд, Лхагважавын Гангэрэл Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Жамсрандоржийн Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн,

Нинжбатын Ууганбаатар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Идэшийн Батхүү Эдийн засаг хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Төмөрийн Баясгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга, Батболдын Мөнхтөр Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан технологийн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Даринчулууны Эрдэнэтуяа Эдийн засаг, хөгжлийн яамны Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга, Ганболдын Золбоо Сангийн яамны Санхүү төсвийн судалгааны газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Отгондэмбэрэлийн Мягмардорж Эдийн засаг хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Цасчихэрийн Мөнхдэлгэр Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Эдийн засгийн эрх чөлөө, өрсөлдөх чадварын судалгааны хэлтсийн дарга, Пүрэвдоржийн Чандмань Эдийн засаг, хөгжлийн яамны Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга, Батжаргалын Төгөлдөр Эдийн засаг хөгжлийн яамны хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга, Батхишигийн Мөнх-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн дарга, Лувсанвандангийн Ичинноров Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга, Пүрэвдоржийн Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Шаравын Бат-Эрдэнэ Сангийн яамны Санхүүгийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга гэсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэй байна аа.

Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаас гаргасан санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү?

Номин гишүүнээр нийтдээ 9 гишүүн, 14 гишүүнээр тасаллаа. 15 гишүүнээр тасаллаа.

Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар.

Да.Цогтбаатар: Өглөөний мэнд хүргэе.

Төсвийн хүрээ төсөв бид нар жил болгон 2024 оноос хойш 30 гаруй их наяд төгрөгийн асуудлыг л 126 гишүүн рүү оруулж ирээд л тал болгоноос нь ярьдаг боллоо. Энэ дээр эхнээсээ баримталж байгаа миний ганцхан зарчим байгаа юм. Авлигалынхаа асуудлыг л бид нар яриад сурчих юм бол бид нарын энэ 30 их наяд гэж яриад байгаа энэ тоо маань хамгийн багадаа 3 дахин ихсэх боломжтой. Энэ асуудал дээрээ ерөөсөө хариулт хэлж байгаа хүн нэг ч байхгүй. Үндэсний аудитын газраас би 2024 оны Засгийн газрын санхүүгийн тайланд хийсэн үйл ажиллагааны санхүүгийнх нь тайлан дээрээс 12 их наядын алдаа дутагдал гарсан. Яг энэнтэй холбогдуулаад аудитын, аудитор өөрөө хэнд нь ямар санал зөвлөмж хүргүүлсэн юм бэ? Төсвийн ерөнхийлөн захирагчид нь ямар санал, дүгнэлт хүргүүлж, ямар хариуцлага тооцъё гэж санал гаргасан юм бэ? Хуулийн байгууллагад хэдийг нь шилжүүлж, ямар асуудал тооцуулж, хариуцлага тооцуулъя гэж санал хүргүүлсэн юм бэ гэдэг асуултыг асуусан. Одоо болтол ерөөсөө асуултын хариулт байхгүй.

Шинээр томилогдсон байгаа тэр аудитын орлогч нь ажил руугаа ерөөсөө ороогүй байна. Бид нар энэчээ нэг ингээд л ухаантай царайлаад л хуралдсан болох юм. Яг ажил явахгүй байна, Булгантуяа дарга аа. Энэ дээр эсвэл энэ Улсын Их Хурлын Тамгын газар ирж асуултад хариулж байгаа хүмүүс чинь нэг жоохон хариуцлагатайгаар үнэн мэдээллийг одоо энэ Улсын Их Хурлаас гарч байгаа аливаа шийдвэрийг хараад сууж байгаа хэн бүхэнд өгмөөр байна. 30 ч бай, 3 ч бай бид нар их наядын асуудал ярих болгонд хариуцлагын асуудал авлигын асуудал ерөөсөө яригдахгүй орхигдуулаад байгааг энэ дээр нэг тэмдэглэж авч байгаад хариултуудыг авмаар байна.

Яг та хурал даргалаад сууж байсан. Би санаж байна. Надад бичгээр ирүүлчихсэн гэдэг ганцхан юм ярьчихаад аудит суучихсан. Яг энэ хамтарсан Байнгын хорооны хуралд суухад асуусан хариулт байхгүй. Бичгээр ирүүлнэ л гээд байгаа юм. Одоо бид нар надад ирүүлж яах гээд байгаа юм бэ? Энэ иргэддээ хэлэхгүй юм уу? Бид нар татварын мөнгийг нь хурааж авах болохоороо 26 их наядыг нь орлогын албан татвар, НӨАТ, нийгмийн даатгал гэж хурааж авчхаад буцаад тайлагна. Хэнд ямар хулгай хийгээд байгаа юм хариуцлага тооцоод байгаа юм тэрийгээ яриадах гэхээр нэг ч хариулт алга байна шүү дээ. Би дахиад асуумаар байна. Аудитаас хэн хариулах юм?

Х.Булгантуяа: Аудитаас аудитаас ажлын хэсэгт хүн байгаа билүү. Хэрвээ одоо араас нь бичгээр явуулна гэсэн бол энэ хугацаанд аль хэдийн мэдээллийг та бүхэн маань Улсын Их Хурлын гишүүдэд албан бичгээр хүргүүлчхээч. Би Цогтбаатар гишүүн тэгж байсан чуулган дээр нэгдсэн чуулган дээр Байнгын хороон дээр асууж байсан. Одоо хүртэл мэдээлэл нь ирээгүй байгаа юм байна. Үндэсний аудитын газраас Наранцогт дарга хүн дуудъя нэмж. Дараа нь энэ асуудал дээр нөхөөд хариулна шүү. Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэболд.

С.Эрдэнэболд: Одоо төсөв, төсвийн хүрээтэй холбоотой асуудал маш чухал асуудал. Өмнө нь эртээр анх удаа парламентын асуулгын цаг гээд Ерөнхий сайд мэтгэлцээн хийсэн. Тэгээд энэ саяын өнгөрсөн өдрүүдэд болсон төсвийн Байнгын хороодын зүй тогтлыг харахад ихэнх гишүүдийн зүгээс асуулт асууж байгаа, санал хэлж байгаа зүйл нь болохлоор нөгөө эрэмбийн асуудлыг л яриад байгаа юм. Өөрөөр хэлбэл энэ хөрөнгө оруулалтын эрэмбэ түүнийг төсөөлөхдөө яах юм, нөгөө хэмжих нэгж нь ямар байх юм гэсэн асуулт яриад байгаа юм. Удаа дараа ярьж байгаа Лувсанжамц гишүүн ярьж байгаа. Миний хувьд гэх юм бол үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай нийцсэн эсэх асуудлаар үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс энэ шалгуур үзүүлэлт тогтоох юм уу, парламент тогтоох юм уу гээд удаа дараа ярьж байгаа.

Тэгээд энэ асуудал ерөөсөө ингээд шийдэгдэхгүй зүгээр хоосон яриа болоод л өнөөдрийг хүрчихлээ. Саяын энэ Даваагийн Цогтбаатар гишүүний яриад байгаа зөв шүү дээ. Авлигатай тэмцэх асуудал Трансперенси интернэйшналис Монгол Улсад 3 янзын зөвлөмж өгдөг. Монголд авлигыг бууруулахын тулд ийм 3 зөвлөмж хэрэгтэй байна аа. Улс төрийг энэ шүүх эрх мэдлийн шийдвэр гаргалтаас хол байлгаач ээ, мөнгөний нөлөөллөөс хол байлгаач ээ. ТӨК-удыг цомхотгооч гээд нэг тодорхой зүйлүүд хэлдэг. Тэр яг ингээд зорилго гоё ч гэсэн түүнийг хэрэгжүүлэх механизм нь аягүй тодорхойгүй байсаар байгаад байгаа юм. Тэгээд төсвийн хүрээн дээрээ ач холбогдол бага өгчихөөр төсөв нь бол тэр нэг философи буюу тэр концепц нь бол дахиад л нөгөө асуудал гараад ирж байгаа юм. Одоо энэ Цэнгүүн гишүүн эд нарыг баллаад л тийм компанит ажил явуулаад байна. Мушгин

гуйвуулаад байдаг гол агуулга нь болохлоор энэ төсвийг үр ашигтай яг тэр зорилтот зүйлдээ зарцуулаач ээ гэдэг л агуулгыг хэлээд байгаа шүү дээ.

Тэгээд харамсалтай нь өнөөдөр Монгол Улсын Төрийн ордонд бол нууц товчоон дээр гардаг шиг зүйл болж байна. Одтой тэнгэр орчилдож олон улс байлдаж, орондоо унтах завгүй олзлолдон булаалдаж байна гэж хэлдэгтэй ижилхэн зүйл болж байна аа. Тэгээд эрх баригч намын гишүүд маань ээлж дараалан гарч ирж мэдэгдэл хийж байгаа нь улс орны хөгжил дэвшил гэхээс илүүтэйгээр намын даргын асуудлаа Төрийн ордонд авчраад институт хоорондын хямралын хэмжээнд хүргэлээ.

Тэгээд маргалдагч сэргөлдөгч талууд энэ дээр жоохон ухаантай байгаач, улс орноо бодооч, зарчим байвал түүн дээрээ мэтгэлцээч. Та бүхний явуулж байгаа энэ тоос хөдөлгөсөн шороо бужигнуулсан үйл явдал чинь Монгол төрийн бодлого гацаад явахгүй байна шүү дээ. Энэ дээрээ бодмоор байна. Тэгээд ер нь бол асуугаад байх юм алга. Гол нь бол одоо энэ их ухаантай мэргэн түргэн зүйл бид нар ярилцаад тэр нь бодит ажил болохгүй байгаад байна. Учрал сайдаа энэ нөгөө шалгуур үзүүлэлт гээд л ярьсан. Ярьсан юм чинь ерөөсөө энэ юунд чинь орж ирэхгүй байгаад байна шүү дээ ажилд чинь орж ирэхгүй байгаад байна шүү дээ энэ дээр яах юм. Та энэ дээр ер нь нэг хариулчихсан нь зөв байх. Ямар бодолтой байгаад байгаа юм.

Х.Булгантуяа: Учрал сайд хариулъя.

Г.Учрал: Бид төсвийн хүрээ, төсвийн төсөөллийн хуулийг хэлэлцэж байгаа. Тэгэхээр энэ төсвийн хүрээг тусад нь хэлэлцээд энэ төсвийн хүрээнд нийцүүлж төсвийг төлөвлөдөг болсон энэ хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын хууль, Төсвийн тогтвортой байдлын хуулийн хүрээнд энэ төсвийг хэлэлцдэг болсон нь бол маш сайн жишиг. Энэ ч утгаараа бол Хөгжлийн бодлогын хуульд зааснаар 5 жилийн үндсэн чиглэлийг батлаад 5 жилийн чиглэлтэй нийцсэн 4 жилийн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр батлагдаад 5 жилийн чиглэлтэйгээ уялдуулж улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг Их Хурлаар хэлэлцэж баталдаг.

Ингээд улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцүүлээд төсвөө өргөн мэдүүлдэг. Ингээд жилийн төлөвлөгөөнд улсын төсөв нийцсэн байна уу эсэх дээр Засгийн газар ч гэсэн одоо Эдийн засаг хөгжлийн яамнаас зөвшөөрөл өгөөд Их Хуралд өргөн барьдаг. Тэгэхээр энэ бол өөрөө Монгол төрийн бодлогыг тогтвортой байлгах гэсэн бол гол зорилт.

Тэгэхээр энэ жилийн хувьд зүгээр анх удаа яг миний хувьд ажил аваад анх удаа энэ 5 жилийн үндсэн чиглэлийг боловсруулах ийм үүрэг оногдсон. Тэгээд Монгол Улсын Ерөнхий сайд бол энэ шинэ итгэл шинэтгэл гэсэн энэ бодлогоо үргэлжлүүлэе. Монгол төрийн бодлого бол тогтвортой байх ёстой. Оюун-Эрдэнийн Засгийн газрын үед санаачилж тухайн үед энэ хурдтай хөгжлийн төлөөх зориг гэсэн 4 жилийн хөтөлбөр батлагдсан. Энэ 4 жилийн хөтөлбөр тогтвортой үргэлжлэх ёстой. Тэрнээс биш Ерөнхий сайд солигдлоо гээд Их Хурлын батлагдсан хөтөлбөр өөрчлөгдөнө гэж байхгүй. Та бүхний баталсан 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрт нийцсэн бидний баталсан Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг үргэлжлүүлээд бид нар хэлэлцээд явж байгаа юм.

Тийм учраас зүгээр Засгийн газрын хувьд бол хуулиар хуулийнхаа дагуу яг цаг хугацаандаа ажлаа төлөвлөөд төсвийн хүрээгээ 9 сарын 1-ний өмнө мэдүүлсэн. Ингээд төсвөө өргөн мэдүүлсэн. Мөн 5 жилийн үндсэн чиглэлийг ирэх 7 хоногийн Засгийн газрын хурлаар оруулах гэж байна. 10 дугаар сарын 31-ээс өмнө Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. Ингээд сар хэлэлцээд бид нар батлах ёстой. 2026 оны 1 сарын 1-нд өмнөх 5 жилийн чиглэл дуусгавар болж байгаа. Тэгэхээр ирэх 5 жилийн чиглэл батлагдана. Энэ дээр гол зүгээр онцлог нь юу юм бэ гэхээр яг Эрдэнэболд гишүүний хэлж байгаагаар 5 жилийн үндсэн чиглэлийг бол индикаторуудыг нь маш тодорхой болгосон. Жишээ нь хүний хөгжлийн түвшинг 0.7 оноотой байсныг 0.85-д хүргэнэ гэдэг шууд зорилт.

Зөв засаглалын хүрээнд зөв засаглалын үзүүлэлт буюу ДНБ-ий засаглалын үзүүлэлтийн дундаж эрэмбийг дээшлүүлнэ. Төрийн үйлчилгээг цахимжуулах нь цахим засаглалын хөгжлийн индексээр 0.8 -тай байгаа бол үүнийг 0.9-д хүргэнэ гээд ингээд шуу индексүүдийгээ тавиад явж байгаа гэсэн үг. Дэлхийн банкны засаглалын үзүүлэлт авлигын индексийн эрэмбийг 50 байраар урагшлуулна. 2030 онд 88-д хүргэнэ гээд ийм хэмжигдэхүйц индексүүдийг тавьсан. Тэгэхээр 5 жилийн үндсэн чиглэл бол нийт тэргүүлэх 14 индексийг урагшлуулна.

Бид нар Засгийн газар дээр энэ 14 индексийг бууруулахын тулд жишээ нь авлигын индексийг бид 2030 онд 88-д хүргэе гэвэл ХЗДХЯ үүнд хэдэн нэгж хувиар ямар үүрэг оролцоотой байх вэ гэдгийг нь хэмжиж тавьж байгаа юм. Тэр Ки Пи Ай-г үнэлнэ. Ингээд дараа нь үнэлгээгээ хийгээд та бүхэнд тайлагнахдаа энэ зорилтод хүрсэн хүрээгүй гэдгээр нь хэмжээд ингээд хариуцлагын асуудлыг яригдаад явах учраас анх удаа ингэж хэмжиж индикаторуудыг.

Х.Булгантуяа: Учрал сайд гүйцэд хариулья.

Н.Учрал: Тэгээд бид яг энэ удаа яг индикаторуудыг хэмжиж болохуйц байдлаар тавьснаараа онцлогтой. Тэгэхээр ирэх жил Байнгын хороон дээр нөгөө тайлан тавиад, тайлагнахад бол энэ авлигын индексээр 88 байранд орсон уу ороогүй юу гэдгийг л жишээ нь 2030 онд хүргэхэд орсон уу ороогүй юу л хэмжинэ. Эдийн засгийн эрх чөлөөний индексээр дэлхийн улсуудын эхний 60-д орно. 5 жилийн дотор гэдэг бол бидний зорилт, 60-д орохын тулд ирэх жил 3 байраар урагшлах ёстой. 3 байраар урагшлахын тулд ХЗДХЯ Байгалийн нөөцийн ил тод байдлын хуулийг барих ёстой. Яагаад гэвэл авлигын төсөөллийн индексийг урагшлуулахад ийм ийм ажлуудыг хий гээд цаанаасаа бид нарт шаардлага тавьж байгаа учраас. Ингээд салбарын яамдууд тухайн индекст ямар хувь нэмрээ оруулсан бэ гэдгээр нь үнэлээд үнэлээд явна. Салбарын яам дотроо ч гэсэн нөгөө ажилтан албан хаагчдынхаа үнэлэхдээ хүртэл ки пи ай-ыг нь тавиад гүйцэтгэлийг нь үнэлээд явна. Тэр шат шатдаа хариуцлагатай болно оо. Тэр 5 жилийн чиглэл хэмжигдэхүйц байна гэдгийг хэлье.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Жамбалын Ганбаатар.

Ж.Ганбаатар: Баярлалаа. Хэд хэдэн тоо асууя.

Нэгдүгээрт тэр ДНБ-ий өсөлтийг 5 сард оруулж ирснээсээ яагаад бууруулчихсан юм бэ? Эдийн засгийн хөгжлийн яам. Харин нөхцөл байдлыг чинь харахаар харин өсөх ёстой юм биш үү? Юуг үндэслээд бууруулсан бэ гэдгийг асууя.

Хоёрдугаарт тэр орлого 31 их наяд 600 тэрбум гэж байгаа. Энэ орлого тал чинь Учрал сайдаа 90 сая тонн нүүрс та төлөвлөсөн байх.

Тэгээд Сангийн яам зөвшөөрсөн байлгүй дээ тиймээ? Эс үгүй бол Сангийн яам зөвшөөрөөд та баталсан юм уу? Арай тэгж болохгүй байлгүй дээ. Тэгэхлээр 90 сая тонн нүүрс гаргаж чадах юм уу? Ахиад төсвөө тодотгохгүй юм байгаа биз дээ? 90 сая тонн нүүрс, 20 тонн алт чадах уу? Наад алтны чинь гүйцэтгэлээ мэдэж байгаа юу? Эдийн засаг, хөгжлийн яамныхан. Алтны гүйцэтгэл чинь бараг зургаахан тонн юм биш үү? Зүгээр надад байгаа мэдээлэл шүү. Сүүлийн үед ер нь бид нарт их сонин мэдээлэл өгдөг болчихоод байгаа шүү дээ. Тэгээд энэ сайд нар байхгүй ганцхан Учрал сайд. Төсвийн хүрээний мэдэгдэл гэдэг чинь төсвөөсөө бараг том байх ёстой шүү дээ. Ахиад мэдэгдэл хийгээгүй юм байгаа биз дээ? Тэнд нэг хүмүүс хэлээд байна шүү дээ. Нам дээрээ очиж юмаа шийд онигоо байна гээд. Тэгээд нас намбатай Улсын Их Хуралд олон жил суусан хүмүүс хүртэл дарвиад л гүйгээд байх юм. Дагаж гүйгээд л. Уул нь хэлж залруулаад ойлгуулаад ингээд хүмүүст элэг доог болохгүйхэн шиг явах ёстой доо.

Сэдэв рүүгээ буцаад оръё. Алив 90 сая тонн нүүрс гаргаж чадах юм уу, 20 тонн алт шатах юм уу? Би зэсийн өсөлтийг бол хүлээн зөвшөөрч байна аа. Үнийг нь яриад яах вэ? Би энэ 31 их наяд 600 гэдэг тоон дээрээс чинь асуусан шүү Учрал сайдаа. Тэр ДНБ-ий өсөлт буучихсан байгаа гээд харж байгаа байх. Энэ яагаад буулгасан юм, таны хариултаас өсөх ёстой юм биш үү? Ямар үндэслэл цаана нь байгаа юм. Тэр хэрэглээний үнийн индекс ер нь яагаад долоохон хувь гээд тооцоод байдаг юм бэ? Эдийн засгийн хөгжлийн яамныхан нэг хариулж өгөөч. Бодит байдал дээр чинь ийм биш маш удаж байгаа шүү дээ. Одоо энэ багш нар, эмч нар, ахмадууд тэтгэвэр хүрэхгүй байна гэдэг чинь ерөөсөө л хэрэглээний үнийн индексийн өсөлт. Тэгээд бид нар болохлоор 6 хувьтай, 7 хувьтай гээд яриад их удаж байна аа. Учрал сайд энэ дээр нэг дорвитойхон шиг өөрчлөлт гаргаад наад нэг аргачлалыг нь өөрчлөөд нэг хүнд нэг бодитой тоо үзүүлбэл болдоггүй юм уу? Тэр 7 хувь гээд хэнд ч байхгүй тоо.

Х.Булгантуяа: Эхлээд Учрал сайд хариулах уу? Учрал сайдын микрофон за.

Н.Учрал: Ганбаатар гишүүний асуултад хариулъя аа.

Тэгээд яах вэ бид өмнө нь батлагдсан Төсвийн хүрээний мэдэгдлийн хүрээнд төсвөө төлөвлөх гэхээр хэт их өөдрөгөөр төсөөлсөн байсан. Тэгээд маш бага цаг хугацаанд нүүрсний үнэ дэлхийн зах зээл дээр унасан. Тэгээд ер нь ДНБ-ий өсөлтийг бол яг өмнө нь батлагдсан Их Хурлаар батлагдсан төсвийн хүрээн дээр бол 6 хувь гэж үзсэн байсан. Тэгэхэд бол 2025 оны эхний хагаст бол нүүрс олборлолтын хэмжээ үнэ бол төсөөллөөс их доогуур гарсан. Тэгээд уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх чиглэлд тээврийн өртгийг бууруулсантай холбогдуулан энэ тээвэр ложистикийн салбар бол огцом бол агшсан.

Тэгэхээр 2026 онд өмнө нь 4 дүгээр сард төсвийн хүрээний мэдэгдлийн тооцоонд бол нэг 80 доллароор тооцож байсан ч энэ дэлхийн зах зээл дэх түүхий үнийн хөдөлгөөн, энэ Хятадын эдийн засгийн олон улсын шинжээчдийн дүгнэлт тэр блүүмбергийн терминал дээр нь тэр 14, 15 байгууллага үнийг нь харьцуулаад ингээд үзэхэд бол цаашдаа энэ 80 доллар байхгүй гэдэг нь тодорхой.

Тийм учраас энэ удаа төсвийг төлөвлөхдөө бол хэт их өөдрөгөөр төсөөлөхийг хичээгээгүй. Тийм ч учраас таны яг хэлж байгаагаар нөгөө Сангийн яам нь төлөвлөөд зарлагаа нэмчхээч, орлогоо нэмчхээч эсвэл GDP-ээ өсгөчихье тэгээд багтаачихъя гэдэг ийм байдлаар явах утгагүй юм билээ. Тийм учраас би бас нөгөө Эдийн засаг, хөгжлийн сайдын хувиар энэ тоон дээрээ хатуу байя гэж зорьсон. Тийм ч учраас төсвийн тусгай шаардлагуудыгаа барьчихлаа, орлого зарлагыг нь аль алиныг нь бууруулчихлаа. Ингээд урсгалаа бас нэг 24 хувьдаа барьчихлаа. Нэрлэсэн ДНБ тэнцвэржүүлсэн орлогынхоо харьцааг нэлээн их өндөр энэ чинь бараг 37 хүрчхээд байсныг 30 руу буулгачихлаа, үе шаттай бууруулъя гээд ингээд тоон дээрээ хатуу байсан.

Тэрийг би Ганбаатар гишүүнд хариуцлагатай хэлье. Зүгээр энэ ДНБ-ий төсөөлөл бол өмнө нь батлагдсанаар 105.5 байсан шүү дээ. Тэгээд түүнийг нь бол 102.4 болгож бол ингэж өөрчилсөн. Тэгээд эдийн засгийн өсөлтөд бол энэ ХАА-н салбарын өсөлтийг илүүтэй нэмэгдүүлж тооцож 5.7 буюу өмнөхөөсөө зургаагаасаа 5.7 болгож бууруулаад ХАА-н салбар дээр хийгдэх ажлууд үүн дээр бол өсөлтийг нэмэгдүүлж тооцох юм байна гэдэг үүднээс бол 5.7-оор ингэж тооцож оруулж ирсэн. Зүгээр нүүрсний экспорт бол 2023 онд бол нэг 69 сая тонн байсан юм байна лээ. 2024 онд бол 83 сая тонн хүрч байсан. Яг өнөөдрийн байдлаар бол нэг 63, 64 сая тоннд хүрчхээд байна.

Тэгэхээр ирэх жил ер нь ажлыг шахаж явахгүй бол болохгүй л гэж. Үнээ өндрөөр тавьж ингэж дэлхийн зах зээл дээр нүүрс яах бол гэж суухын оронд тоо хэмжээгээ 90 сая хүргэх боломж байна л гэдэг ийм зорилготойгоор бид нар ажлаа шахаж байгаа. 2026 оны 90 сая тонн нүүрсний 40 сая тонн нүүрс бол нэг гэрээгээр баталгаажчихсан байгаа. Баталгаажна гэж тооцож байгаа. Тэгээд яах вэ бид нар нөгөө гэрээнүүдийг бүгдийг нь цахимжуулаад нөгөө Хүрлээ сайдын үед нэг хийж авсан ажил. Тэр бол их сайн ажил.

Тийм учраас энийг 40 сая тонн гэрээгээр нь цахимжуулаад ингээд баталгаажсан учраас энэ хийгдэнэ. Мөн бол сая бид нар энэ нөгөө хил гааль дээр үүсээд байгаа асуудлууд дээр нэлээн асуудлуудыг шийдсэн. Нөгөө нэг дол 7, 8 буудаг суудаг нэг олон километр очерлодог дараалал. Тэгээд Өвөр Монголын өөртөө засах.

Х.Булгантуяа: Учрал сайд гүйцэд хариулъя.

Н.Учрал: Тэгээд ажил аваад ӨМӨЗО-д очиж уулзалт хийсэн. Тэгээд тухайн үед бол бид нар тэр хил гааль, боомтын захиргаа энэ хоорондын мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлсэн. Нөгөө манифест гэж ярьдаг энэ мэдээллүүдийг хоорондоо бид нар солилцож байгаа. Энэ хүрээндээ сая ганц мод Гашуун сухайт дээр очоод ажиллахад нөгөө олон километр очер дараалал үүсгэдэг машинууд юутай ч ингээд цахимжуулаад шийтгэчихлээ. Тэгээд хуучин бол ингээд л нэг падаан бичүүлээд л гар хөлийн үсэг зуруулаад л, дардас дараад л буудаг байсан бол 6-аас бараг 8 буудаг байсан. Энэ буудаг суудаг нь больчихлоо. Ямар ч байсан гацаагүй ингээд машин тэргүүд гараад явж байна. Ер нь ложистик талдаа нэлээд их анхаарч ажиллаж байгаа. Тэгээд энэ сая Тавантолгой дээр ч гэсэн тэр бүрэн төлөөлөгчийн баг ажиллаад экспорт бас 1.7 дахин нэмэгдлээ гээд ингээд арга хэмжээнүүд хийгдэж байгаа. Тийм учраас нэг 90 сая тоннд хүргэнэ л гэж зорино.

Х.Булгантуяа: Ганбаатар. Гишүүн нэмж тодруулна.

Ж.Ганбаатар: Учрал сайдад баярлалаа. Тэгэхдээ Учрал сайдаа юу шүү Эдийн засгийн хөгжлийн яам бол уул нь орлогыг ингээд илүү олох төлөө явах ёстой байхгүй юу. Түүнээс биш шахна гэхлээр чинь нэг Сангийн яам шиг болчхоод байна шүү дээ. Сангийн яам чинь 90 саяыг төлөвлөөд тэгээд баахан зардал гаргаад ингээд л баахан хүмүүст таалагдахыг хүсэж байна шүү дээ. Та уул нь ингээд танай яамны тэр залуучууд сонсож байгаа бол ингээд бага төлөвлөөд, ихийг олоод тэр илүү олсон мөнгөөрөө улс орны дотоод чухал асуудлыг шийдэх ёстой байхгүй юу. Тэгэхгүй бол энэ дотор орж ирээд ингээд талыг нь нэг тараад. Эдийн засгийн хөгжлийн яам бол би анх байгуулагдсан цагаас нь хойш хэлсэн юм. Наадах чинь 90 сая биш, энэ чинь 70 сая, 80 сая гэж тооцоод илүү гарвал тэр илүү орлого чинь Монгол Улсын үнэхээр маш чухал орлого шүү дээ. Тэгээд тэр 7 хувь дээр хариулахгүй байна хэрэглээний үнийн индекс хариулахгүй байна. Тэр алтыг байна шүү дээ 20 тонн гэдэг бол худлаа шүү эдийн засгийн хөгжлийн яам. Наадах чинь бэлгэдлийн чанартай 10 жил, 20 жил тавигдаж ирсэн тоо шүү. 10 болгож өөрчлөөрэй наадхаа.

Х.Булгантуяа: Учрал сайд нэмж хариулъя.

Н.Учрал: Ганбаатар гишүүн би дэмжиж байгаа. Та байнга Эдийн засаг, хөгжлийн яаманд илүү эрх мэдэл, илүү нөгөө шахаж ажиллах бололцоог бүрдүүлэх ёстой гэж хэлдэг байсан. 33.5 их наядын орлого төлөвлөөд 33.5-аар зарна гэдэг ийм төсвийн хүрээ байсан юм. Тэгэхээр нь төсвийн тогтвортой байдлын хуулийн дагуу орлогыг бол 31.6 их наяд хүртэл буулгаад зарлагыг бол бас одоо 33.5 их наядаас нь адилхан буулгах ёстой гэдэг байдлаар бол бид нар хандсан. Тийм учраас 32 их наяд 980 гээд тэр орлого зарлагыг нь аль алиныг нь бууруулсан. Гэхдээ бол энэ тийм хэт өөдрөг бол төсөөлөл биш тийм гэж үзэж байгаа. Энэ 31.6 их наядаас илүү орлого олох бололцоо бүрэн байгаа.

Тийм учраас таны хэлээд байгаа хуримтлалыг үүсгэх ёстой. Бид нар ер нь хуримтлал үүсгэж чадаагүй олсныхоо хэрээр зарсаар л ирж л дээ. Манай ажлын хэсэг нэмээд хариулчихъя.

Х.Булгантуяа: 4 номерын микрофоноос хэрэглээний үнийн тухай нэмж хариулах уу? Ажлын хэсгээс. Эдийн засаг, хөгжлийн яамны ТНБД Батхүү дарга.

И.Батхүү: Ганбаатар гишүүний асуултад нэмэлтээр хариулъя.

Эдийн засаг, хөгжлийн яамнаас энэ тооцооллыг гаргахдаа инфляцыг, дундаж инфляцыг 2026 онд 7 хувь гэж тооцоолсон. Энэ нь Монголбанкны зорилтот интервалын түвшин дотроо байгаа.

Хоёрдугаарт нь инфляцын тоо нь энэ зорилтот үзүүлэлт нь хүлээлтээс үүдсэн зах зээл дэх хөдөлгөөнд нөлөөлдөг учраас бид нар энэ зорилтот тоогоороо 7 хувьд барина гэсэн зорилт тавьж байгаа. Инфляцын одоогийн байдлаар 8.8 хувьтай гарсны дөрөв аравны хэдэн хувь нь эрэлтийн гаралтай инфляц байгаа. Монголбанкнаас явуулж байгаа мөнгөний бодлого холбогдох зохистой бодлогын арга хэмжээнүүдийг нөлөөлөөд шууд үр дүнд нь гардаг. 4 орчим нь нийлүүлэлтийн гаралтай инфляц. Энэ инфляцыг бууруулах чиглэлээр Засгийн газрын зүгээс авч хэрэгжүүлж байгаа хүнсний хувьсгал, цагаан алт, атар-4 гэх мэтчилэн ХАА-н

салбарын төслүүдийг амжилттай явуулах энэ хил гаалийн импортын тээврийн тээвэр логистикийн асуудлуудыг зохистой.

Х.Булгантуяа: Ганбаатар гишүүн нэмж тодруулна.

Ж.Ганбаатар: Учрал сайд би зүгээр нэг зүйл олзуурхаж байгаа. Тэр 70 доллар тиймээ. Тэр их яах вэ тэрүүгээрээ илүү орлого олж магадгүй. Зүгээр би 90 сая тоннд хүрэхгүй гэдгийг мэдэж байна. Энэ жил үү, ирэх жилийг ярьж байна л даа. Тийм тэгэхлээр наад 70 доллароо бол харин бага тооцсон байна лээ. Сайн байна гэсэн үг. Тэр алтаа засаарай. Нэгхэн минут учраас наад алт чинь худлаа шүү. Алтыг их төлөвлөхлөөр байгаль орчин руугаа их дайрдаг болчихдог юм шүү. Тэгээд нөгөө төлөвлөгөөндөө хүрэхийн тулд хачин хачин юм гаргаад тэгээд хамаа замбараагүй хөтөлбөр гэж хачин хачин юм болдог шүү. Тэгээд наад хэрэглээний үнийн индксийг Учрал сайд зассан нь дээр. Тэр сагсаа өөрчилсөн нь дээр. 8 хувь гэдэг чинь бодит амьдрал дээр байхгүй байхад ингээд л худлаа. Тэгэхээр наад нэг тэр сагсны бараа мараагаа өөрчлөөд журмаа өөрчлоод тэгээд ингээд бодитой болгох хэрэгтэй шүү дээ. Энийг олон жил ярьж байна шүү дээ. Тэгээд л нэг хариулсан болоод. Хүрээний мэдэгдэл дотор ярилаа шүү.

Х.Булгантуяа: Ганбаатар гишүүн нэмж үг хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Баатаржавын Мөнхсоёл.

Б.Мөнхсоёл: Өглөөний мэнд хүргэе.

Тэгэхээр би энэ сая Заяабал гишүүний уншсан Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хурал дээр уг нь хэлсэн юм энэ протоколд ороогүй байна. Тэгэхээр давтаж ахиж хэлье гэж бодлоо. Багш эмч, нарын цалинг өсгөх тухай энэ асуудлыг олон жил ярьж ирсэн хүний хувьд хэлэхэд. Тухайн Төсвийн байнгын хороон дээр цалинг өсгөх боломжтой гэдгээ хэлсэн. Тэгээд ер нь 10-аас 15 хувиар багш нарын цалинг нэмэх нь гэж ойлгож байгаа шүү. Энийг протоколд үлдээчихье гэж бодож байна аа.

Хоёрдугаарт нь энэ Лувсанжамц гишүүний ахалсан 185 дугаар захирамжаар үүссэн үнэлгээ мониторингийн ажлын хэсэгт би орж ажиллаж байгаа гишүүдийн нэг ээ. Энэнтэй холбогдуулаад энэ төсөв боловсруулах үйл явцад саналаа өгсөн. Мөн дараагийн 3 дугаар хэлэлцүүлгээс өмнө өгөх гэж байгаа нэг санал юу вэ гэхээр яг тодорхой саналууд байгаа. Би жишээлбэл энэ ажлын хэсэг дотроо Гэр бүл, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яаманд зориулсан зорилт шалгуур үзүүлэлтийг тодорхой болгох саналуудаа өгсөн. ХААЯ дээр өгсөн байгаа. Тухайлбал тухайлбал яагаад энэ асуудал дахин дахин янз бүрээр олон гишүүдээс хөндөгдөөд байгаа вэ гэхээр тодорхой болж өгөхгүйд л учир байгаа юм. Тодорхой болохгүй болохоор дараа нь манай Лувсанжамцын гишүүний алдартай үг ч гарчихсан байна лээ шүү дээ. Бид нарын монгол ардын суурь үг. Нөгөө хэмжиж чадахгүй бол яаж дүгнэж чадах вэ л гэдэг чинь тэр. Өөрөөр хэлэх юм бол зорилгоо зөв тавихгүй болохоор энэ эргээд нөгөө үнэлгээн дээр 3 янзын үнэлгээ гараад бид нар баахан маргалдаагүй юу? Тэгэхгүйн тулд төсвөө мэдээж оновчтой үр өгөөжтэй зарцуулахын тулд мөн нөгөө талдаа энэ суурь түвшнээ зорих гэж байгаа зорилт шалгуур үзүүлэлтүүдээ зорих гэж байгаа түвшнээ маш ойлгомжтой тодорхой байлгая гээд. Жишээлбэл ЖДҮ-лэлийг дэмжих сангаас авсан аж ахуй нэгжүүд зээл авсан. Тэрний үр дүнг жишээлбэл тооцохдоо орлого юм уу ашгийнх нь өсөлтийг оруулъя. Тэгэхгүй болохоор өгөөж нь харагдахгүй байна тиймээ.

Хоёрдугаарт жишээлбэл юун дээр мартчихлаа тэрүүхэн хоооронд. Жишээлбэл маш олон асуудлууд байгаа юм. Нэгийг нь л хөндье дөө.

Газар тариалангийн асуудал дээр жишээлбэл өмнө үйлдвэрлэж байсан тэр зорилтот хэмжээгээ бууруулчихсан байгаа. Шалгуур үзүүлэлт дээрээ. Зорилтот түвшнээ. Тэгэхээр энэ дээр яагаад бууруулсан шалтгаан байхгүй байгаа юм. Нийгмийн даатгалын сан дээр жишээлбэл иргэдийн нийгмийн даатгалын талаарх ойлголтыг нэмэгдүүлнэ гэхийн оронд нийгмийн даатгалд хамрагдах хамрагдсан иргэдийн тоог нэмэгдүүлнэ ч гэдэг юм уу.

Х.Булгантуяа: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Яах вэ бид нөгөө төсвийн хүрээ хэлэлцэж байгаа. Тэгээд энэ 9 тооны хүрээнд макро тоонуудыг гаргаад энэ тоонд хүргэхэд аль яам ямар нэгж хувиар хувь нэмрээ оруулж ямар ажлуудыг хийх вэ гэдгийг зүгээр Тэргүүн Шадар сайдын хувиар би Засгийн газар дээр танилцуулаад үнэхээр бид нар эдийн засгийн өсөлтийг 5.7 -д хүргэе гэж зорьж байвал жишээ нь алт зэсийн агуулга нэмэгдэж байгаа дээр бид нар ийм тооцоо гаргасан учраас Аж үйлдвэрийн сайд 2.1 хувь нь нэгж хувийн хувь нэмрээ оруулах ёстой. Зам тээврийн салбарт ложистикийн асуудлыг шийдэхийн тулд ийм арга хэмжээнүүдийг хийснээрээ тэдэн хүн нэгж хувийн хувь нэмрээ оруулах ёстой. ГЕГ хэдэн нэгж хувийн хувь нэмэр оруулах ёстой юм. Үүнийг хийхийн тулд Сангийн сайд ямар ажил хийх юм бэ гэдгээр төсвийн хүрээний мэдэгдэл тооцоо тавьсан. Макро тоонууд дээр хүрэх ажлаа шахаж явдаг зорилгоор энэ хөгжлийн бодлогын хууль батлагдсан.

Тэгээд улсын жилийн төлөвлөгөө яг манай Мөнхсоёл гишүүний хэлж байгаа их зөв л дөө. Ингээд ийм зорилтот түвшнүүд тавиад байдаг тэгээд яг үнэндээ тэр чинь ингээд хэмжиж болохгүй байна гэдэг чинь асуудал байна гээд хэмжиж болохгүй зорилт тавиагүй учраас дараа нь хэмжиж байгаа хүндээ ч утгагүй, дүгнэж байгаа хүндээ ч утгагүй болчихоод байгаа юм.

Тэгээд нөгөө хавсралтаар нэг арга хэмжээ хийсэн нь эсвэл нэг ажил төлөвлөсөн нь нэг форум хийсэн нь илтгэл тавьсныгаа аваачаад ингээд хангалттай хангалттай гээд үнэлчихдэг. Тэгээд ямар ч бодит үнэн байхгүй. Тэгэхээр энэ жилийн 5 чиглэлийг та бүхний хамтарсан ажлын хэсгийнхэнтэй би уулзахдаа саналуудыг чинь сонссон. 10 дугаар сарын 31-ээс өмнө өргөн мэдүүлнэ. Энэ жилийн 5 жилийн чиглэл бол нэг зүйлээрээ би бахархалтай байгаа. ШУА бүрэн бүрэлдэхүүнээр оролцсон эрдэмтэн судлаачдыг оролцуулсан. Их Хурлын гишүүдийг оролцуулсан. Дээрээс нь үүн дээр дандаа индексүүдийг тавьсан, дандаа индикаторуудыг тавьсан.

Ерөөсөө боловсролын салбарт тэр хүүхдүүдийн тэр ЭЕШ-ын дундаж оноо тэдэн хувьд ахиулна гэдэг л зорилт байх ёстой. Ахиулахын тулд уншлагын дундаж хэмжээ тэр сургууль тэдэд хүргэнэ л гэдэг зорилт. Тэрэнд хүргэхийн тулд хэдэн удаа давтлага хийнэ үү, хэдэн удаа багш нараа сургана уу тэнд хэдэн арга хэмжээ хийнэ вэ гэвэл тэдний асуудал байхгүй юу. Үр дүнд хүрсэн үү үгүй юу гэдгээр нь л хэмжинэ.

Тийм учраас бид нар тэргүүн ээлжид 14 индекс тавьчихаж байгаа юм. Хүний хөгжлийн индекс, эдийн засгийн эрх чөлөөний индекс, тэгээд инновацын индекс гээд ингээд индексүүд. Энэ индекс 5 жилдээ дараа тэдэд хүрнэ ээ. Эдийн засгийн эрх чөлөөний индекс эхний 60-д орно оо. Ирэх жил 3 байр. Түүний дараа жил 5 байр.

Тэрний дараа жил яагаад 5 байр урагшлах гэж байгаа юм бэ гэвэл Эдийн засгийн эрх чөлөөний хууль, Хөрөнгө оруулалтын хууль батлагдана. Түүний дараа жил 10 байраар урагшилна гэж зорьж байгаа. Яагаад гэвэл түүнийг дагасан журмуудыг гаргаад хувийн хэвшилд орон зай бий болгоно ч гэдэг юм уу ингэж хэмжиж 5 жилийн чиглэлийг энэ удаа оруулъя гэж хичээсэн. 8 бүлэгтэй, тэгээд 14-ийн индексээ урдаа тавьчихсан. Тэгээд салбар болгон өөр өөрсдийнхөө индикаторуудтай. Бид нар индикаторуудаа өгнө. Эргээд хэмжинэ, тэгээд тайлангаа тавина. Хүрсэн хүрээгүй тэр үр дүнд очсон очоогүй. Очоогүй бол хангалтгүй очсон бол хангалттай гэдэг ийм л хэлбэр ээ.

Тэгэхээр одоо энэ бид нар сая Засгийн газар байгуулаад 100 л хонож байна тиймээ. Энэ хугацаанд энэ төсвийн хүрээний энэ макро тоонуудыг хатуу барья л гэж төсвийн сахилга батыг барья л гэж зорьсон. Ирэх жилээс нэг эрүүлжүүлж явахгүй бол олсныхоо хэл хэрээр зардаг энэ байдал чинь л өнөөдөр ийм байдалд хүргэчихээд байна шүү дээ.

Тийм учраас мөчлөг сөрсөн бодлого хэрэгжүүлнэ гээд одоо хэлэх гэхээр нөгөө хуримтлагдаж байх нөгөө эдийн засаг тэлж байх үедээ хуримтлуулж чадаагүй байгаа хүмүүс чинь одоо мөчлөг сөрнө гэхээр утгагүй сонсогдоод байгаа байхгүй юу.

Х.Булгантуяа: Мөнхсоёл гишүүн нэмж тодруулна.

Б.Мөнхсоёл: Санаагаа багцлаад товчлоод ганцхан өгүүлбэр хэлчихье. Асуулт байхгүй үг болгоод. Гол хэлэх гээд байгаа санаа нь юу вэ гэхээр бид нар өнгөрсөн хойно нь нэргэж олон жил явчихлаа.

Хоёрдугаарт нь ерөөсөө энэ яагаад шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин энэ тэр гэж яриад байгаа вэ гэхээр 100 сая төгрөг зарах уу, 10 тэрбум төгрөг зарах уу гэдэг чинь үүнээсээ хамаараад байгаад л учир байгаа юм. Малын жишээлбэл ашиг шимийг нэмэгдүүлнэ гэххээд хэрхэн яаж гэдэг нь байхгүй малынхаа тоон дээр анхаарах юм уу эсвэл эрчимжүүлсэн МАА-г хөгжүүлэх гээд байгаа юм уу гэдэг зэрэг нь байхгүй учраас тодруулаад байгаа юм шүү. Тэгээд үнэлгээ мониторингийн ажлын хэсэг энэ дээр салбар салбараа хувааж маш нарийн ажилласан. Энийг бас шууд аваад ашиглах боломжтой гэдгийг хэлье. Түрүүн ганцхан юмнаас иргэд маань гишүүд төдийгүй иргэд маань ойлгох байх. Юу вэ гэхээр нийгмийн даатгалын ач холбогдлыг ойлгуулж яах юм. Ойлгуулж чадаад нийгмийн даатгалд хамрагдуулалтыг л нэмэгдүүлэх ёстой биз дээ. Энэ тоо өсөх ёстой гэх мэт ийм маш энгийн юм шиг мөртөө.

Х.Булгантуяа: Мөнхсоёл гишүүн чухал санал хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. Энэ улс орны эдийн засаг нийгмийн хөгжлийг хангах бодлого үйл ажиллагааныхаа үр дүнгээр эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдээ зохистой уялдуулж нэг энэ түвшинд очих юм гэдэг хүрээ төсөөлөл л дөө энэ уг нь. Тэгэхээр би Засгийн газрыг өөрсдөдөө тов тодорхой зорилт тавиад ер нь энэ улс орны эдийн засгийг нэг үндсэн үзүүлэлтүүдийг нь ийм түвшинд байлгахад өнөөдрийн түвшнээс бид нарын зориод байгаа тэр ахиц дэвшлүүд гарах юм гэдэг байдлаар оруулж ирж байгаа юм байна. Энийг нь бид нар энэ улсад гэрийн даалгавар болгоод батлаад өгчих ёстой гэж би

ингэж ойлгож байгаа. Харин энийгээ хангах тал дээр онцгой анхаарал хандуулж ажиллах ёстой шүү гэдэг ийм зүйл байгаа.

Гэхдээ төсвийн хүрээний мэдэгдэл дотор анхаармаар юм гарч ирсэн. Өчигдөр Төсвийн байнгын хороо, Гадаад бодлого аюулгүй байдлын байнгын хороон дээр АХБ-ны зээлийн санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг ярих явцад гадаадын зээлийн ашиглалт 2026 онд бидний хүссэн хэмжээнд тавигдаж чадаагүй гэдэг юм яригдсан. Төсвийн алдагдлын 1 их наяд 380 тэрбум бол үндсэндээ гадаадын зээл ашиглалт үүгээр дамжиж өнөө яриад байгаа хэдэн том бүтээн байгуулалтын ажил урагшлах юм гэж ингэж тооцсон чинь Газрын тос боловсруулах үйлдвэр маань 2027 оны эхний хагаст багтаж ашиглалтад орно гэсэн ийм төлөвлөгөөтэй явж байгаа.

Гэтэл одоо наад тэрбум 380 дотор авагдсан зээл ашиглалт нь болохоор зэрэг тэрийгээ хангаж чадахааргүй байгаа гэдгийг Сангийн яам өчигдөр ярина лээ. Тийм учраас энэ эдийн засгийн үзүүлэлтүүдийг хооронд нь уялдуулж хүрээ хязгаарыг нь баталж байгаа энэ баримт бичиг дотроо бодитой ашиглах ёстой, цаана нь хийгдэх ёстой бодит бүтээн байгуулалтуудаа дэмжихээр зохицуулалтаа хийх бололцоо байхгүй юу.

Өчигдөр Сангийн сайд Сангийн яамны Хөрөнгө оруулалтын газраас ярьсан зүйл дээр улаан цайм л тийм юм ярьсан шүү дээ. Бараг 2028 оноос нааш энэ үйлдвэр ашиглалтад орохгүй юм байна гэдэг юм ярина лээ шүү дээ. Яг ийм зээл ашиглалтын байдлаар нь. Тэгэхээр бид ийм байдлаар асуудалд хандамгүй байна аа. Үнэхээрийн бодит тооцоо, судалгаануудаа нарийсгаж үзээд, тэр том үйлдвэрийг ядаж нэг хэдүүлээ энэ гадаад нөхцөл байдал чинь өдрөөс өдөрт, таашгүйгээр, таамаглашгүйгээр өөрчлөгдөөд байгаа энэ цагт үндэснийхээ аюулгүй байдлыг хангах үүднээс нэг ч гэсэн зүйлээ босгож ирэх өнөө олон тулгуурт эдийн засгийн тухай асуудалд чинь нэмэр болоход хэрэгтэй зүйл юм биш үү? Энийгээ хийе гээд бүгд нийтээрээ зоривол яасан юм. Тэгээд одоо тэр төсвийн алдагдал тодорхой хэмжээнд тэр төсөл арга хэмжээн дээр авч ашиглагдах.

Х.Булгантуяа: Учрал сайд Батжаргал гишүүний асуултад хариулъя.

Н.Учрал: Батжаргал гишүүн их чухал асуудлыг хөндөж байна аа. Үнэхээр нөхцөл байдал яг л ийм байгаа. Ирэх жил гадаад зээлийн ашиглалт 1.9 их наяд орчим юм байна. Тэгээд нөгөө алдагдалтай төсөв оруулж ирлээ гээд ингээд зарим гишүүд маань шүүмжлээд байгаа юм. Тэгээд үнэхээр зовлон байгаа юм. Ер нь энэ гадаад зээл буюу эх үүсвэр нь тодорхой байгаа. Нэгэнт Их Хурлаар батлагдаад соёрхоод баталчихсан зээлээ ирэх жил ялангуяа хүний хөгжлийг дэмжсэн төсөл хөтөлбөрүүддээ ашиглахгүй байхын арга байхгүй шүү дээ. Гэхдээ бид нар нөгөө тэнцвэржүүлсэн орлогоо бол хамгийн бодитой төлөвлөсөн. Энэ чинь нөгөө суурь тэнцэл эерэг гарах ёстой шүү дээ. Тэр суурь тэнцэл эерэг гарч байгаа.

Тэгээд нөгөө тодорхой алдагдал чинь эх үүсвэр нь гадаад зээл гээд тодорхой байгаа. Тэгэхээр тэнд бол суурь тэнцэл эерэг гарах энэ тусгай шаардлагаа биелүүлнэ гэдэг бол бид нар алдагдлаараа цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж тавиад байгаа огт ойлголт биш байхгүй юу. Ирэх жил 1.9 их наядын гадаадын зээл тусламжаар ашиглалт байгаад байхад бид нар 1.4 орчим их наядын эх үүсвэр нь тодорхой тэр алдагдал дээр энэ бараг статистик алдагдал байхгүй юу. Тэрнээс биш энэ чинь эх үүсвэр нь тодорхой, тэгэхдээ суурь тэнцэл эерэг гарчхаж байгаа юм.

Тэгээд энэ заавал Засгийн газрын бонд үнэт цаас гаргаж энэ алдагдлыг санхүүжүүлэх гээд байгаа юм бол байхгүй.

Тэгэхээр ер нь энэ төсвийн сахилга бат хариуцлагыг нэмэгдүүлье гээд орлого зарлагаа аль алиныг нь бууруулчихсан. Урсгалаа 24-дөө барьчихсан. Тэгээд хэт их өөдрөг төсөөлөөгүй, экспортын бүтээгдэхүүний үнийг яг л одоо олон улсын тэр байгууллагуудын үнэтэй харьцуулж байгаад яг бодит үнээр аргачлалаар тооцчихсон. Ер нь нэлээн ийм сахилга баттай төсвийн хүрээ гэж хэлэх хэрэгтэй. Манай энэ төрийн албан хаагч нар сайн ажилладаг юм байна. Ингээд энэ ажлын төлөө зүтгэсэн. Даанч тэгээд энэ улс орон даяар нөгөө улс төржилтдөө төөрөөд бид чинь тэгээд төсвийн хүрээ манатай л болж байх шиг байна. Гэхдээ хэн ч зүгээр цаашаа энэ ажлыг үргэлжлүүлээд энэ чинь хийнэ шүү дээ. Ирэх жилүүдэд ирэх он жилүүдэд. Энэ төсвийн сахилга бат хариуцлагыг л барих хэрэгтэй шүү. Тэрнээс биш эдийн засаг тэлж байх үедээ хуримтлуулж чадаагүй хор гайг өнөөдөр амсаж байгаа шүү.

Тэгээд Сангийн яамтайгаа Эдийн засгийн яам нь нийлээд та нар нэг зарлагаа нэмчхээч, GDP –ээ өсгөчхөөч тэгээд цалин нэмчихье гээд ийм байдлаар явсаар байгаад өнөөдрийг хүрчихжээ. Энэ олон жилд 20, 30 жилд. Тэгэхээр энэ удаа нэг ийм сахилга батаа бариад нэг удаа нэг ийм сахилга баттай байчихвал ирэх жилээс энэ төсөв чинь өөрөө бодлого нь ойлгомжтой болох байхгүй юу. Тийм учраас л энэ мөчлөг сөрсөн бодлого бол тодорхой хэмжээнд энэ төсөв дээр энэ алдагдлыг янз бүрийн эх үүсвэргүйгээр биш тодорхой алданги төлөвлөснөөрөө хувийн хэвшлээ дэмжиж байна. Дээрээс нь хуулиудыг зэрэгцүүлж байгаа. Одоо энэ татварын багц хууль, дээрээс нь энэ Эдийн засгийн эрх чөлөөний хууль ирэх 7 хоногт засгаар танилцуулна. Хөрөнгө оруулалтын хууль, зөвшөөрөл, мэдэгдлийн хууль. Энэ бүх хуулиуд боловсруулагдаад дууссан. Энэ хуулиуд гарч байж өөрөө жинхэнэ мөчлөг сөрсөн бодлого хэрэгжинэ. Тэрнээс биш зөвхөн төсөвтэй холбоотой биш байхгүй юу. Эрх зүйн шинэчлэл зэрэг явж байж хэрэгжинэ дээ. Олон жил хүлээгдсэн энэ хуулиудыг легал инфо дээр тавьсан. Энэ хуулиудыг зэрэг батлаад явах юм бол ирэх жил бол ер нь энэ хувийн хэвшилд байгаа ажлын байрыг хадгална гэдэгтээ итгэл дүүрэн байгаа юм аа.

Тийм учраас энэ орлогыг нэмэх, зарлагыг нэмэгдүүлэх ийм хий хоосон зүйлүүд огт ярихгүйгээр энэ сахилга батыг би бариад өгөөч л гэж гишүүдээсээ хүсмээр байна.

Х.Булгантуяа: Батжаргал гишүүн нэмж тодруулна.

Ж.Батжаргал: Тэгээд бүүр их тодорхой ярья. Төсвийн хүрээнд төсвийн төсөөллийг дэмжье. Гэхдээ хэдүүлээ нэг ганц үйлдвэр байгуулаадахъя. Угаасаа энэ үйлдвэрийг байгуулах гээд зээл авъя гээд тохирчихсон. Түрүү талаас нь бид 30 орчим хувийг нь ашиглачихсан. Одоо үндсэндээ үлдэгдэл ашиглаж чадаагүй байгаа зээлийнхээ хэмжээн дээр бид 0.15 хувийн бараг шимтгэл төлөөд явж байгаа улс байхгүй юу. Тэгэхээр энийг больё л доо. 2027 оны эхний хагаст нь багтааж энэ үйлдвэрийг ашиглалтад оруулъя.

Тэгэхээр 2026 он дээр наад авах гээд байгаа 1.7 тэрбум долларын зээлээс чинь би нэг 500 гарныг нь ашиглачихсан болов уу гэж бодоод байгаа юм. Одоо бараг 1.2 тэрбумын ашиглалт орж ирэх ёстой. Энэнээс 2026 онд хэдийг нь авч ашиглаж байж наад үйлдвэр чинь 2027 онд ашиглалтад орох юм бэ? Тэрийгээ бодитой болго,

төсвийн алдагдлаа бодитойгоор нь тавья. Одоо тэгээд Их Хуралд нэг ийм юм батлаад өгчихсөн, энэ хязгаарт багтаад би.

Х.Булгантуяа: Учрал сайд нэмж хариулъя.

Н.Учрал: Тийм. Нэгэнт Их Хурлаар батлагдчихсан зээлийн хэлэлцээрүүд байгаа шүү дээ, хэрэгжиж байгаа. Тэгэхээр ашиглах л хэрэгтэй, ашиглах хэрэгтэй. Эх үүсвэр тодорхой. Тэгэхээр бид нар бол нэг энэ алдагдлыг мэдээж нэмэгдүүлэх бололцоо Их Хуралд байгаа. Бид Засгийн газрын зүгээс бол орлого зарлагаа аль алиныг нь бууруулаад ингээд алдагдал тодорхой үүсгээд ингээд өргөн мэдүүлсэн. Тэгээд ер нь гадаад зээл өөрөө төсөв дээр зарлага талдаа л бичигддэг учраас энэ зарлага нэмэгдчих гээд байгаа юм л даа.

Яагаад гэхээр бид нарын баталсан нөгөө Төсвийн тогтвортой байдлын хуулиар орлого, зарлагыг нэгэн зэрэг бууруулж байгаа тохиолдолд төсвийн хүрээний мэдэгдлийг өргөн мэдүүлж болно оо гэдэг нэг ийм заалт бид нар хавар баталсан шүү дээ. Тэгэхээр 32 их наяд 980 буюу цаана нь нэг 600 тэрбум төгрөгийн л асуудал байхгүй юу.

Х.Булгантуяа: Батжаргал гишүүн нэмж тодруулна.

Ж.Батжаргал: Төсвийн хүрээг ингээд баталчхаж болж байгаа юм. Дэмжихэж болж байгаа юм. Хамгийн гол нь наад алдагдлынхаа тоог зөв болгомоор байгаад байгаа юм зардал хоёроо. Яагаад энийг би яриад байгаа юм гэхээр зэрэг үнэхээрийн хэрэгтэй юм хийнэ гээд л юм аваад л ашиглачихсан юм бол худлаа дутуу ашиглалт явуулаад он цаг алдаад байх шаардлагагүй ээ. Шаардлагатай цаг хугацаанд нь бүрэн аваад ашиглачихъя аа.

Тийм учраас энэ төсвийн хүрээ төсөв 2-ыг ярьж байх үед бодитой мэдээллээ өгөөдхөөч. 2026 онд яг хэдийг аваад ашиглачихвал бид гүйцэтгэлээ гаргаж чадах юм гэдэг юмаа л өгөөдөх. Тэгвэл одоо энэн дээр Их Хурлын гишүүд ажлын хэсэг дээрээ ярьж байгаад энэ асуудлыг шийдмээр байна. Тэгэхгүй одоо ингээд нэг дутуу алдсан могой шиг улс оронд бас тийм хохиролтой хий, хураамж юмнууд төлсөн нэг ийм байдлаар асуудалд яваад баймгүй байна л даа.

Х.Булгантуяа: Учрал сайд нэмж хариулъя.

Н.Учрал: Батжаргал гишүүн аймгийн дарга байсан хүн тэгээд төрийн ажил мэддэг хүн асуудалд өөр хандаж байгаа юм. Тэгэхэд зарим хүмүүс болохоор бараг алдагдал оруулж ирлээ, төсвөө буцаах хэрэгтэй гээд ингээд. Тэгээд цаг хугацааны хайчинд байдаг. Дээрээс нь Үндсэн хуулиар алдагдал зарлагыг аль алиныг нь нэмэгдүүлж болохгүй гэдэг заалт дотор бид нар орчихсон хэлэлцэж эхэлж байна шүү дээ.

Тэгэхээр үүн дээр мэдээж ажлын хэсэг гаргаад төсвийг дотор нь зохицуулалт хийх нөгөө төслүүдийн ашиглалтын эрэмбүүд дээр нэг ажиллах бололцоо байгаа байх гэж бодож байна. Тэгэхээр энэ гадаад зээлийн ашиглалтууд Сангийн сайдын багц дээр байдаг. Тэр Сангийн яамнаас энэ гадаад зээлийн ашиглалтын талаар нэг мэдээлэл өгөөд Их Хурлын ажлын хэсэг дээр төсөв дотроо нэг зохицуулалт хийх ямар боломж бололцоо гарцууд байна гэдгээ нэг хэлээдхээч.

Х.Булгантуяа: 4 номерын микрофоноос Сангийн яам. Гадаад зээлийн ашиглалт тэр чигээрээ Сангийн сайдын багц дээр байгаа тэрэн дотор зохицуулалт хийж болох уу? 4 номер.

М.Санжаадорж: Сангийн яам, Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж гишүүний асуултад хариулъя, нэмэлт мэдээлэл өгье өө.

Газрын тосон дээр бол санхүүжилтийн хүсэлт нь 7 их наядын хүсэлт ирчихсэн байгаа. Зөвхөн ирэх жилийн хувьд 3 их наяд гэхихсэн байгаа. Тэгээд яг гишүүний хэлж байгаатай санал нэг байна. Хэрэвзээ алдагдлаа нэмээд нийт зарлагаа нэмэх юм бол 2 их наяд хүртэл алдагдлыг нэмэх бол хуулийн хэмжээ байгаа. Гэхдээ бид нар энэ жилийн алдагдлыг нэмж бол болохгүй гэдэг тийм байр суурьтайгаар л оруулж ирсэн. Энэ алдагдлын хэмжээ маань өөрөө мөнгөний нийлүүлэлттэй холбоотой байгаа. Тэгэхлээр инфляцын энэ тооцоо маань өөрөө энэ 9 үзүүлэлтээр ороод ирчихсэн байгаа. Энэ үзүүлэлтүүд хөндөгдөх эрсдэл байна л гэдэг зүйл дээр хэлэх байна. Тэрнээс биш төслийг дуусах дээр тантай санал нэг байна аа. Баярлалаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Лхагвасүрэнгийн Соронзонболд.

Л.Соронзонболд: Бүгдэд нь өглөөний мэнд хүргэе ээ. Батжаргал гишүүнтэй ер нь санал нэг байгаа. Тэгэхээр энэ 2028 оны төсөөлөл дээр Засгийн газрын өрийн хэмжээ 59.5 их наяд төгрөг болж 7.7 их наяд төгрөг нэмэгдүүлэхээр тооцчихсон байгаад байгаа. Тэгэхээр энэ дээр асуулт байгаад байгаа нь болохоор энэ 7.7 их наяд төгрөг чинь өнөөдөр бидний Монгол Улсын Засгийн газрын байгуулсан зээлийн гэрээнүүдийнхээ хүрээнд зээлийн ашиглалтаа нэмж бий болгох гээд байна уу, эсвэл шинээр зээлийн гэрээ байгуулж энэ өрийг авах гээд байна уу гэдэг 1 дүгээр асуулт байгаад байгаа юм.

Хоёрдугаар асуулт маань би өмнө нь тодруулаад асууж байсан юм. Энэ 2028 онд яагаад гэнэт ингээд 2027 оноосоо 7.7 их наяд төгрөг ингээд өсөхөөр тооцоолоод байгаа юм бэ? Энд ямар нэгэн төслийн шинээр төслүүд дуусах гээд байгаа юм уу? Тийм учраас мөнгө хэрэгтэй болоод байгаа юм уу? Энэ дээрээ нэг ийм ийм тодорхой тайлбар өгөөч?

Х.Булгантуяа: 4 номерын микрофон дээрээс Сангийн яам хариулъя. 3 номерын микрофон дээрээс.

Л.Гантогтох: Сангийн яамны өрийн удирдлагын хэлтсийн дарга Гантогтох гишүүний асуултад хариулъя. Төсвийн хүрээний мэдэгдэл дээр бол ДНБ-ий харьцуулсан өрийн харьцааг бол 2026 онд 50 хувь, 2027 болон 2028 онд 45 хувьтай байхаар тооцсон байгаа. Энэ бол яг төсвийн хүрээний мэдэгдэл дээр тавьсан энэ өрийн хязгаар бол ирэх 3 жилд тавигдах өрийн дээд хязгаар гэж ингэж ойлгож болно. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар өрийн хязгаарыг 60 хувь гэж тооцсон байдаг. Мөн Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиас гадна энэ төсвийн хүрээний мэдэгдлээр ирэх 3 жилийн Засгийн газрын өрийн хязгаарыг ингэж тогтоож байгаа.

Тэгэхээр энэ бол 50, 45, 45 хувь гэдэг бол ер нь яг дээд талын өрийн хязгаар. Төсвийн хүрээний мэдэгдлийн хамт явж байгаа төсвийн төсөөллөөр бол Засгийн газрын өрийн дунд хугацааны төсөөллөөр 2026 онд Засгийн газрын өр 44.9 их наяд

буюу ДНБ-ий 43.8 хувьтай, 2027 онд 48.1 их наяд буюу ДНБ-ий 42.2 хувьтай, 2028 онд 40.4 хувьтай тэнцэхээр ийм дунд хугацааны төсөөлөл бол байгаа. Тэгэхээр энэ 45 хувь гэдэг бол дээд талын хүрээ, хязгаар гэдэг энэ ойлголт. Ингэж ойлгож болно. Энэ 45 хувь болон 40.4 хувийн төсөөллийг бол одоогийн гэрээ байгуулсан. Энэ Засгийн газрын гадаад зээлийн хүрээнд ашиглалт гараад ийм түвшинд хүрэхээр тооцсон байгаа.

Х.Булгантуяа: Соронзонболд гишүүн нэмж тодруулна.

Д.Соронзонболд: Засгийн газрын өрийн дээд хязгаар гээд 59.5 их наяд төгрөг болгож байгаа чинь өөрөө эргүүлээд 2028 оныхоо төсвийнхөө орлого зарлага дээрээ тодорхой хэмжээгээр зээл чинь ашиглагдана л гэж тооцож л тавьж байгаа гэж би ойлгоод байгаа шүү дээ. Тийм учраас ингэж асуугаад байгаа байхгүй юу. Тэгэхээр ер нь 2028 оны төсөөллөөрөө одоо байгуулчихсан байгаа зээлийн гэрээн дээр шинээр нэмэлт зээл гэрээ байгуулахгүй гэж тооцсон юм байна гэж ойлголоо. Зүгээр 2028 онд зээлийн ашиглалтаа нэмэгдүүлэх нь гэхээр яг ямар том төслүүд дээрээ энэ мөнгийг ашиглалтаа нэмнэ гэж харж байгаа юм бэ гэдэг асуулт яваад байгаа байхгүй юу. 2028 онд төсөөлөл дээр байна шүү дээ.

Х.Булгантуяа: 4 номерын микрофон.

Ж.Дэлгэржаргал: Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Дэлгэржаргал. Гадаад зээл, тусламжийн ашиглалт дээр 1.9. Энэ нь нийтдээ гэрээ хэлэлцээрээр байгуулагдсан амлалтын дүнгийн үлдэгдэл нь 13.6 их наяд байгаа. 13.6 их наядаас бид нар ирэх жил зээл дээрээ 1.5 их наядыг ашиглана. Энэ багц дотроо хамгийн өндөр дүн бол газрын тос боловсруулах үйлдвэр. Нийтдээ амлалтын дүн 6 их наядаас одоо бид нар ашиглагдаагүй үлдэгдэл 4.9 их наяд байгаа. Тэгээд ирэх оны 1.5 дотроо газрын тос дээр ашиглах хуваарилалтын хувьд бид нар 210 тэрбум төгрөгийг хуваарилсан. Яг хэрэгжүүлэгч байгууллагаас ирүүлсэн санал бол ирэх жил 1.7 их наядыг ашиглах саналтай байгаа. Тэгэхээр бид нар яг энэ 1.5-ын дүнгээр гэвэл ганцхан газрын тос дээр ашиглалтаа гаргах ийм тооцоолол байгаа.

Энэ үйлдвэр өөрөө хэлэлцээрийн дүнгээр 2028 онд ашиглалтад орох хугацаатай.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Цагаанхүүгийн Мөнхбат.

Ц.Мөнхбат: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе ээ. 2026 оны төсвийн хүрээний асуудлуудыг ярилцаж байгаа. Энэ үед асуухгүй өнгөрч болохгүй ганц нэг юунууд байна? Зарим гишүүд зарим нэгийг нь асуучихлаа. Тэгээд 1 ийм юм байгаа юм л даа. Зарим бусад Засгийн газар алдагдалгүй өмнөх Засгийн газар жишээ нь алдагдалгүй төсөв батлах ёстой. Ер нь бид нар нэг ийм зарчим дээрээ хойшдоо ингээд явах ёстой гэхихээд энэ удаагийнх болохоор бид нар болохгүй байна. Алдагдалтай батлахгүй бол болохгүй байна гээд нөгөө нэг бодлогын зарчмынхаа юмнуудаасаа ухраад ингээд яваад байгаа чинь зөв юм уу гэдэг нэг зүйлийг зориуд асуумаар байна.

Хоёрдугаарт нь АН-ын бүлэг бол энэ удаагийн төсвийг буцаах ёстой. Алдагдалгүй болгох ёстой. Одоо энэ гадаа өдөр болгон жагсаал цуглаан хийгээд байгаа энэ ахмадууд энэ багш, эмч нарын цалин хөлс, тэтгэвэр тэтгэмжийг тодорхой

хугацаагаар нэмэгдүүлэх ёстой. Үүндээ энэ төсвөө буцааж аваад тэр асуудлуудаа суулгаад ингээд эргээд оруулж ирэх ийм боломж байна гээд.

Зарчмын асуудал тавьсан. Тэгээд энэ дээр ерөөсөө ямар нэгэн хариу өгөхгүй ингээд л хэлэлцүүлгүүд яваад л байна л даа. Энэ дээр одоо ямар бодолтой ямар байр суурьтай байна вэ гэдгийг асуумаар байна. Төсөв захирагч нарын л төсвийн зардал нэмэгдээд байгаа шүү дээ. Бодитойгоор сүүлийн хэдэн жил төсвийн хэмжээ ямар их хэмжээгээр нэмэгдэж байна, ямар их хэмжээгээр томорч байна. Бодитойгоор яг одоо юу үлдээд юу үлдэж хоцроод ямар хөгжил дэвшилд хүрээд байна гэдэг чинь харагдахгүй байна гээд л хүмүүс бухимдаад байгаа шүү дээ.

Тэгэхээр зэрэг энэн дээр ямар байр суурьтай байна гэдэг ийм зүйлийг асуумаар байгаа юм.

Гуравдугаарт нь түрүүн тэр хэллээ. Энэ ганц үйлдвэр барих гээд олон жил боллоо гээд. Тэгээд сая дахиад би нэг нөгөө өнцгөөс нь асуучихъя гэж бодлоо. Тэр газрын тосны үйлдвэр. Бид нар зээлээ авчхаад зарцуулж чадахгүй байгаа байж 2028 онд орох уу? Энэ юу чинь. Бид нар бол ингээд л яриад л байна. Тэгээд л 2026 онд ч орох байлуу. Одоо 28 болчихсон явж байгаа. 2028 онд болохоор зэрэг энэ дахиад болсонгүй гээд. Ингээд зогсож байх уу? Хүү төлөөд байдаг. Тэгсэн хэрнээ зээлээ зарцуулж чадахгүй байгаа юм. Энэ дээр ямар бодлогын шийдвэртэй алхам хийх вэ гэдэг зүйлийг нэг нэмж тодруулъя.

Х.Булгантуяа: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Эдийн засаг хөгжлийн яам макро эдийн засгийг цаашдаа хэрхэн тогтворжуулах вэ гэдэг л энэ бодлогыг барьж байгаа. Тийм л ажил хийдэг. Тэгээд энэ нэг макро 9 тоогоо гаргаж өгөөд энэ хүрээнд Төсвийн тогтвортой байдлын хууль болоод бусад хуулиудыг чанд бариад төсвөө төлүүлнэ шүү гэж Сангийн яам нь тийм юм гаргаж өгч байгаа нэг хязгаар. Энэ зарлагын хязгаар, орлогын хэмжээ, доод хэмжээ, зарлагын дээд хэмжээ энэ дотор багтаана гээд. Тэгэхээр яах вэ алдагдалгүй оруулж ирж болно болохгүй юм бол энд байхгүй. Гэхдээ бүр л нөхцөл байдал хүндэрнэ.

Жишээ нь орлого хийсвэрээр нэмэх, тэгээд магадгүй тийм байдал руу л хөдөлнө тэгээд алдагдалгүй болгоно гэвэл зарлага улам л буурна. Ингээд эхлэхээр нөгөө зардлын нийт хэмжээ урсгал дотроо зохицуулалт хийхэд бэрхшээлтэй болж эхэлж байгаа юм. Тэгээд ер нь өөрөө энэ төсвийг тодорхой алдагдал үүсгэнэ, төсвийн тэнцлийг ашигтай байлгах уу, алдагдалтай байлгах уу бол өөрөө эдийн засгаа тогтворжуулахын тулд хэрэглэдэг бодлогын ийм тохируулга. Энэ бодлогын тохируулгыг бид нар ач холбогдолгүй, шаардлагагүй эргээд ажлын байр бүтээдэггүй, шинэ технологи, агууламж нэмэгдүүлдэггүй ийм зүйлд зарцуулсаар байгаад өнөөдөр энэ үгнээс айдаг болчихсон. Зөв л дөө энэ чинь Их Хурлын гишүүд ингэж шүүмжлэхээс арга байхгүй. Яагаад гэвэл алдагдлыг өөрөө эдийн засгийг тогтворжуулах бодлого гэж ерөөсөө харж байгаагүй л байхгүй юу. Тэгээд 1 хийсвэр орлого төлөвлөдөг. Тэгээд зарлага нэмдэг. Тэгээд алдагдал хийгээд өгөхөөрөө нөгөөдхөөрөө шаардлагагүй баахан юм санхүүжүүлдэг. Тэгэхээр энэ дээр хариуцлагатай ханд гэж ингэж гишүүд шүүмжилж байгаа нь маш эрүүл шүүмж шүү дээ. Зүгээр энэ удаа бол ямар асуудал үүссэн бэ гэхээр эх үүсвэр тодорхойгүй алдагдал огт тавиагүй.

Тийм учраас суурь тэнцэл эерэг гараад байгаа юм. Нөгөө нийт орлого талаасаа нөгөө гадаад зээлээ хасаад суурь тэнцэл эерэг гараад. Энэ би их сайн яг нөгөө тусгай шаардлагаа барьсан. Дээрээс нь нөгөө татвар төлөгчийн мөнгийг үр ашигтай зарцуулах, дээрээс нь хэдийгээр алдагдал үүсгэж байгаа ч гэсэн түүнийгээ энэ эх үүсвэр тодорхойгүй хий хоосон бонд үнэт цаас гаргаж түүнийг санхүүжүүлдэг ийм хэлбэрээр алдагдал үүсгэх асуудал ерөөсөө биш байхгүй юу. Энэ бол зүгээр л эх үүсвэр тодорхой Их Хурлаар батлагдсан гэрээнүүдийн хэрэгжилтийг хангуулъя л гэж.

Яах вэ энэ алдагдлыг хасчихвал нэг ийм асуудал үүснэ. Бид нар олон жил зээлжих зэрэглэлээ нэмэгдүүлсэн. Зээлжих зэрэглэлийг хадгалж үлдэхэд энэ гадаадын зээл тусламжууд хэрэгцээтэй байгаа. Ингэж байж гаднын хөрөнгө оруулалтууд яригдана.

Хоёрт бид нар төсвөөс хөрөнгө оруулалтын ажил тойрог болгон тавьж чадахгүй байна шүү дээ. Тэгэхээр нөгөө хувийн хэвшил ажиллах орон зай байхгүй. Тийм учраас энэ тодорхой алдагдал өөрөө юу вэ гэхээр хувийн хэвшлээ дэмжиж байгаа ийм бодлого.

Дээрээс нь ер нь бол өөрөө энэ төлбөрийн тэнцэлд ч гэсэн эерэг нөлөө үзүүлнэ. Энэ утгаараа бол яг тодорхой алдагдал үүсгэх нь эдийн засгийн бодлогынхоо хувьд макро бодлогынхоо хувьд зөв юм л гэж харсан. Тэрнээс биш ингээд алдагдалгүй оруулж ирээд явчих бол амархан. Зүгээр яг ингэж 1.4 их наядыг тавилаа гээд гадаад зээлээ бүрэн ашиглахад ч боломжгүй л байгаа л даа нөхцөл байдал бол. Гэхдээ бид нар бас дахиад нөгөө орлого зарлагыг нэгэн зэрэг бууруулбал гээд өмнөх батлагдсан 33.5 их наяд, 32 их наяд 980 гэсэн зарлага байгаа. Энийг нэмэх угаасаа нөгөө хязгаараа давна.

Тийм учраас хамгийн дээд хамгийн боломжтой хувилбар л гэж ингэж оруулж ирсэн.

Х.Булгантуяа: Сангийн яамнаас нэмж 4 номерын микрофон.

Ж.Дэлгэржаргал: Мөнхбат гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Дэлгэржаргал. Гадаад зээл тусламжийн төслүүд Улсын Их Хурлаар хэлэлцээрүүд нь батлагдсан хэрэгжилт нь явж байгаа төслүүд байгаа. Нийт зээлийн хэлэлцээрийн одоо яг ашиглагдаагүй үлдэгдэл 13.6 их наяд байгаа. 13.6 их наядаас 2025 онд мөн адил 1.9-өөс 1.5 нь зээлийн ашиглалт 417 нь тусламж. Ирэх онд яг энэ түвшнээр буюу 1.9 их наяд байгаа. Тэгэхээр бид нар 13.6-аасаа 1.5-ыг ашиглах л ийм хуваарь ер нь тавигдаж байгаа. Зээлийн гэрээний хугацааг харах юм бол яг энэ ам ашиглагдаагүй үлдэгдэл 13.6-ын 4.9 нь өөрөө газрын тос боловсруулах үйлдвэрийн ашиглагдаагүй үлдэгдэл байгаа.

Тэгэхээр дуусах хугацааны хувьд бол 2028 он гэхэд бид нар үлдсэн 3 жилийн хугацаанд энэ 4.9 их наядыг ашиглах ийм хугацаатай. Хамгийн цаад талын төсөл гэхэд 2030 онд Эрдэнэбүрэнгийн УЦС энэ жил эхэлсэн.

Х.Булгантуяа: 4 номерын микрофон нэмж хариулъя.

Ж.Дэлгэржаргал: 860 тэрбум байгаа. Тэгэхээр ер нь ихэнх төслүүд буюу 13.6 их наядыг бид нар хамгийн цаад талын хугацаа гэхэд 2030 он гэхэд ашиглаад

төслүүдээ дуусгаад дууссан байх ийм шаардлагатай. Нийт ирэх оны төсөвтөө 85 төсөл явж байгаа. Эдгээрийн 50 хувь нь зам тээвэр, эрчим хүч, дэд бүтцийн салбарын төслүүд байгаа.

Х.Булгантуяа: Мөнхбат гишүүн нэмж тодруулъя.

Ц.Мөнхбат: Тэгээд манай газрын тосны үйлдвэр маань 28 байж байгаад бараг 30 ч болж магадгүй тэр л болоод л нэг ингээд бөөрөнхийлөөд л орхичихлоо. Яах вэ тэр тэгээд явах байх бодвол. Энэ өчигдөр манай Засгийн газрын тэргүүн энэ багш нарын төлөөлөлтэй уулзах шиг болсон. Багш нарын цалинг үе шаттайгаар нэмэгдүүлнэ гээд хэлээд л гаргах шиг болсон л доо. 2028 онд бараг 3 сая 500-д хүргэх гээд байгаа ч юм шиг. 2026 онд хэд ч болгох юм. Тэгээд энэ чинь энэ төсвийн хүрээндээ орох юм уу, ордог юм уу, ер нь яадаг юм? Эсвэл нэг аргалаад гаргадаж байгаа нь энэ юм уу.

Дараа нь тэр эмч нарыг яах юм. Өнөөдөр, маргааш эмч нар жагсах гээд байгаа юм гэсэн. Ингээд тус тусад нь хүлээж авч уулзаад тэгээд 1 гал намжаад гаргаад байх юм уу? Нэгдсэн байдлаар энэ төсвийн хүрээн дотроо ингээд бага багаар ингээд шингээгээд оруулаад ингээд явах юм уу. Энэ Сангийн яамтайгаа энийгээ та нар Засгийн газрын танхим дээрээ юу гэж ярьдаг юм бэ гэдэг энэ зүйлийг тодруулах гэж байгаа юм.

Х.Булгантуяа: Учрал сайд нэмж хариулъя.

Н.Учрал: Бидний баталсан улсын жилийн төлөвлөгөөн дээр урсгал зардлын хэмжээ нөгөө 24 хувь GDP-ийн 24 хувь байна гээд баталсан. Тэгээд энэ хүрээндээ бол урсгалаа төлөвлөж оруулж ирсэн гэхдээ үүнийг үе шаттай бууруулна. Ер нь цаашдаа 24-ийг дахиад. Ингэснээрээ зах зээл дэх төрийн оролцоог бууруулж байгаа гэсэн үг. Ер нь урсгалаа бид нар багасгаад байгаа. Тэгэхээр ер нь бол жил болгон нөгөө ингээд багш эмчийн цалин нэмэх нэрээр нөгөө урсгалаа ингээд өсгөөд хувийн хэвшил бүүр орон зайгүй болгоод хаячихдаг байсан.

Тэгэхээр одоо багш, эмчийн цалинг нэмье гэвэл энэ урсгал зардлынхаа 24 хувь дотор нь 2 дахь хэлэлцүүлгийн дараа бас дахиад цалин нэмэгдүүлэх, тэтгэвэр нэмэгдүүлэх орон зайгаа дахиад яриад явж болох байх. Эдийн засаг хөгжлийн яам энэ төсвийн хүрээ бид хэлэлцэж байгаа үеэр бол нийт хязгаарын тоогоо л өгөөд байгаа. Тэгэхээр ажлын хэсэг дээр энэ асуудлыг ярина. Ерөнхий сайд тодорхой чиглэл өгсөн.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Номин.

Ч.Номин: Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Миний хувьд бол төсвийн хүрээ төсвийг хүлээж аваад хэлэлцээд засаад залруулаад явах ёстой гэсэн байр суурьтай байгаа. Эдийн засаг хөгжлийн сайдаас 2 асуулт байна.

Нэгдүгээрт та түрүүн бас Ганбаатар гишүүнтэй санал нийлж байх шиг байна. 90 сая тонн ер нь нүүрс экспортлох боломж бодит хэмжээнд хүрэх нь хүндрэлтэй болов уу гэдэг дээр. Яг өнөөдрийн байдлаар манай Монгол Улс 8 сарын байдлаар 58 сая тонныг экспортолчихсон. Энэ ингээд энэ онд нэмэгдээд нэмэгдээд дараагийн 3 сард мэдээж энэ эрчимжсэн саруудад нэмэгдээд ч гэсэн 85 сая тонндоо хүрэхгүй.

Тэгээд бид 90 сая тонныг өөрсдөө хэчнээн хүчин чадлаа нэмэгдүүлээд гаргая гэсэн ч гэсэн Хятад тал маань худалдаж авахгүй болчихвол яах вэ.

Засгийн газар хоорондын хэлэлцээрээ хүртэл бид нар улс төржүүлээд өнөөдөр нөхцөл байдлыг хүндрүүлж байна. Хятад талын нүүрсээ худалдаж авахгүй болчихвол яах вэ? Орлого бүрдэхгүй нөхцөл үүсвэл та бүхэнд ямар төлөвлөгөө байгаа вэ гэдэг ийм асуулт байна.

Хоёрдугаарт би өчигдөр Байнгын хороон дээр асуусан асуултаа дахиад асууя. Төсвийн хүрээний мэдэгдэл гэдэг бол төсвийн бодлого оо төсвийн бодлого төсөв цаашлаад орж ирэх гэж байгаа жишээ нь татварын реформууд чинь хоорондоо уялдах ёстой болов уу гэж бодож байгаа. Гэтэл энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс өгсөн дүгнэлт дээр Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд орж байгаа өөрчлөлтөөс шалтгаалаад 2027 оноос нөлөөлөх нөлөөлөл нь 4 их наяд төгрөгийн нөлөөлөлтэй байна гэж орж ирсэн. Гэтэл яг өнөөдөр орж ирж байгаа төсвийн хүрээний мэдэгдэл дээр энэ нөлөөллөө оруулж ирээгүй байна аа.

Тэгээд бид бүхэн энийг ингэж оруулахгүйгээр явахаар нэг бол та бүхэн татвараа энэ реформоо хийхгүй гэж үзэж байгаа юм уу, эсвэл энэ татварын реформоо хийнэ, хийсэн ч дахиад дараа жил бүгдээрээ төсвийн хүрээнийхээ мэдэгдлийг хэлэлцээд сууж байя гэдэг ийм байр суурьтай байгаа юм уу. Яагаад энэ 3 бодлогоо хооронд нь уялдуулахгүй байгаа юм бэ. Татварын бодлого чинь эдийн засгаа дэмжих, хувийн хэвшлээ дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ гэж авч явж байгаа. Гэтэл төсвийн бодлого чинь болохоор яг энэ бодлогоо оруулж ирээгүй орж ирж байна Учрал сайд аа.

Тэгэхээр 2027 онд татварын реформ хийгдэнэ гэж үзэх юм уу үгүй юм уу гэдэг дээр та албан ёсоор хариулт хэлмээр байна. Яагаад вэ гэхээр энэ ААН хувийн хэвшлүүд бол үнэхээр хүлээлттэй байна. Өнөөдөр 16 мянган ААН татварт дансаа хаалгачихсан үнэхээр бизнес эрхэлж байгаа хүмүүс хүндрэлтэй байна. Тэгэхээр хийнэ, үгүй гэдгээ тодорхой болгож өгөх ёстой байгаа. Хэрвээ хийнэ гэж байгаа бол татварын бодлого төсвийн бодлого 2 чинь уялдах ёстой.

Х.Булгантуяа: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Би тэр татвараас эхлээд хариулъя.

Төсвийн хүрээ энэ төсвийн бодлого бол өөрөө хязгаарыг тогтоож өгч байгаа гээд би хэлсэн. Тэгэхээр яаж энэ Татварын багц хууль, татварын реформ хийгдэх орон зайг бий болгосон юм бэ гэвэл төсвийн тэнцвэржүүлсэн орлого нэрлэсэн ДНБ-ий харьцааг бид нар дандаа өндөр байлгаж ирсэн. 2023 онд 33 хувь, 2024 онд 37 хувь нэмэгдсэн шүү дээ бүүр. Энэ чинь ямар ч орон зайгүй бий болгож байна шүү дээ. Нэг ёсондоо татвараар орлого бүрдүүлж байна гэсэн үг шүү дээ гол орлогоо.

Тэгэхээр бид нар энэ орон зайг 2026 онд 30.9 хувь болгож оруулж ирсэн болгоно оо гэж. Ингээд 2027, 2028 он гэхэд энэ 28 хувь хүртэл бууруулна. Энэ ёсондоо юу вэ гэхээр тэр тэнцвэржүүлсэн орлого нь нөгөө нэрлэсэн ДНБ-тэйгээ харьцах харьцааны хувь нь 28 хүртэл буурна гэдэг энд орон зай байхгүй юу. Нэг ёсондоо төр өөрөө татвараар орлого бүрдүүлэх нь гол асуудал биш болно оо гэсэн үг. Энэ орон зайг бий болгож байж татварын реформ хийгдэнэ гэхээс биш өөр яаж

энэ чинь орон зай бий болгох юм. Энэ хүрээндээ бид нар энэ орон зайгаа төсвийн бодлогоороо оруулж ирсэн. Одоо татварын багц хууль, татварын реформ хийгдэнэ ээ.

Татварын реформ бол нэг удаагийн төсвөөр хийгдээд өнгөрөх асуудал огт биш тэр ойлгомжтой. Тэгээд бид нарын 1 дүгээр алхам ямар ч байсан энэ тэр хот харьцааг нь орлого GDP 2-ын харьцааг 28 хүртэл бууруулъя. Ирэх жил 30.9 болгоё одоо 37 байгааг. Тэгээд төрийн оролцоог бууруулъя гэж байгаа юм. Ингээд багц хууль гэхээр бараг 4 хуульд өөрчлөлт орох юм бараг 4 хууль дээр. 4 хууль дээр өөрчлөлт орно. 2026-аас 2029 онд татварын реформуудыг шат дараатайгаар хийнэ ээ. Ингээд 4 их наядын төсөвт ачаалал авч байгаа гэдгээ бол Сангийн сайд хэлсэн.

Та бүхэн энэ легал инфо дээр энэ татварын багц хуультай танилцаж байгаа байх. Бид нар төсөв эхний санал хураалтаар дэмжигдээд ажлын хэсэгт шилжсэний дараа Татварын хуулийг өргөн мэдүүлнэ ээ. Яагаад гэхээр Татварын реформ хийгдэх энэ 4 хууль өөрөө төсөв дагуулаад нэмэлт, өөрчлөлт маягаар явж болохгүй байхгүй юу. Энэ нөгөө цогц реформын шинжтэй асуудал учраас.

Тийм учраас бид одоо төсвийн эхний санал хураалт дуусаад Татварын багц хуулийг өргөн мэдүүлнэ. Төрийн оролцоог бууруулах хувийн хэвшлийн орон зайг бий болгох ийм төсвийн бодлого гэж хэлснийхээ зэрэгцүүлээд бид нар Эдийн засгийн эрх чөлөөний хуулийн анхдагч хууль, Хөрөнгө оруулалтын хууль, Зөвшөөрөл мэдэгдлийн хууль гээд 120 хуулийн өөрчлөлтийг өргөн мэдүүлэх гээд легал инфо дээр тавьчихсан байгаа. Ингээд энэ хуулиуд зэрэг батлагдаж байж энэ татварын ч бай дээрээс нь энэ төсвийн өөрөө энэ удаагийн төсвийн бодлого чинь төрийн оролцоог бууруулъя хувийн хэвшилд орон зайг бий болгоё оо гэдэгтэйгээ нэгдэж цаашаа явна гэсэн үг.

Тэр зөвхөн ингээд нэг төсөв дагуулаад нэмэлт, өөрчлөлт хэлбэрээр ерөөсөө хийгдэхгүй. Тэгэхээр энэ 100 хоногт бид нар нэг эдийн засгийн эрх чөлөө хувийн хэвшлийн бизнесийн үйл ажиллагаанд саад тотгор болж байгаа 120 хуулийн өөрчлөлтийг боловсруулж дууслаа л даа. Одоо хиймэл оюун дээр хайлт хийхээр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 370 хуулийг чинь бараг 150, 160 зөрчилтэй болоод байгаа байхгүй юу. Тэгэхээр ингээд оруулж ирсэн. Тэгээд ингээд хамтдаа хийгдээд явна. Тэгээд үр дүнд хүрнэ ээ. Тэр нүүрс дээр нэг юу хэлье, санал хэлье.

Одоогийн байдлаар нүүрсний биет тоо хэмжээ.

Х.Булгантуяа: Нэмж нэг минут өгье.

Н.Учрал: Одоогийн байдлаар нэг 63 сая тоннд хүрчхээд байна. Тэгээд ер нь энэ ондоо багтаагаад зорилтдоо хүрнэ ээ. Ирэх жил бол нэг 90 сая тонн байна гэдгийг бол ингээд төсөөлж байгаа. Тэгээд нэгэнт би түрүүн хэлсэн. Нөгөө биржээр ч бай, ер нь цахимаар энэ гэрээнүүд бүртгэгддэг болчихсон. 40 сая тонны гэрээг шууд бүртгэлжүүлээд энэ жил явж байгаа юм байна лээ. Үүн шиг 90 сая тонн хүргэх бүрэн бололцоо байгаа. Сая өнгөрсөн сард чинь нүүрсний экспорт түүхэн дээд хэмжээндээ хүрлээ л дээ. Авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд үр дүнтэй байна. Экспортын ажлын хэсэг ажиллаж байна. БНХАУ, ӨМӨЗО-той хэд хэдэн удаагийн уулзалтуудыг хийлээ. Төрийн зүгээс одоо энэ гацаа саад болоод байгаа асуудлуудыг дэмжиж байна, экспорт ложистикой дэмжиж байна. Тэгээд ер нь бид

чадна, орлогоо нэмэгдүүлнэ, хүргэнэ гээд байхад сайн байна хичээгээрэй л гэвэл уг нь зүгээр шүү дээ.

Х.Булгантуяа: Номин гишүүн нэмж тодруулна.

Ч.Номин: Эдийн засгийн хөгжлийн сайд мэдээж бид нар дэмжиж байгаа мэдээж болоосой гэж хүсэж байгаа. Гэхдээ бид бүхэн болохгүй зүйлээ төлөвлөж явах ёстой учраас асуусан юм шүү. Би Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс асуулт байна. Сая Эдийн засаг, хөгжлийн сайд орон зайгаа төсөвлөсөн, бодлогодоо оруулсан гээд хэлчихлээ. Гэтэл та бүхний өгсөн тайлан дээр болохоор Засгийн газраас боловсруулсан олон нийтийн санал авч байгаа хууль нь энэ хуультай нийцэхгүй байна. Дахиад дээрээс нь төсвийн тэнцлийн тусгай шаардлагуудыг хангахгүй байна гэсэн ийм тайлан өгч өгсөн. Тэгэхээр энэ 2 аль нь бодитой мэдээлэл вэ? Энэ дээр та бүхэн мэдээлэл хийж өгөөч ээ.

Х.Булгантуяа: 3 номерын микрофоноос.

Н.Ууганбаатар: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Ууганбаатар Номин гишүүний асуултад хариулъя. Татварын багц хуулийн татварын шинэчлэлтэй холбоотой зүйлийг бол энэ төсвийн хүрээний мэдэгдэлд хангалттай тусгаагүй байж болзошгүй байна гэдэг ийм дүгнэлт бол манай дүгнэлт дотор байгаа. Бид энэ удаад бас өнгөрснийг биш ирээдүйг харсан дүгнэлтийг оруулж ирэх ийм бодлого баримталсан. Тухайлбал өргөн баригдсан байгаа төсвийн хүрээний мэдэгдэл дээр 2027 оны төсвийн төсөөлөл, төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ бол 33.7 их наядаар байгаа 2027 онд. Тэгээд энэ бол ДНБ-ийхээ 29.3 хувь гэж хэлж байгаа боловч ДНБ маань өөрөө 105, 106, 107, 108 их наяд хүрэх үү үгүй юу гэдэг асуудал бол эргэлзээ дагуулаад байгаа юм. 102.5 бол жоохон өндөр болов уу гэсэн бид нар төсөөлөлтэй байгаа. Тэгээд дээрээс нь ерөнхийдөө 100 орчим байх болов уу гэсэн бодит төсөөлөл байгаа.

100 дээр хэрвээ орлого тал дээр нь 3-аас 4.

Х.Булгантуяа: 3 номерын микрофон гүйцэд хариулъя.

Н.Ууганбаяр: Орлого тал дээр нь 3-аас 4 орчим их наядын дутагдал үүсэхээр байгаа бол энэ юу гэсэн үг вэ гэхээр ДНБ-д төсвийн орлогын эзлэх хувь бол энд бичсэн 29.3 хувь бол байж болохооргүй энэнээс илүү бага байхаар харагдаж байгаа. Орлогын түвшин маань өөрөө 33.7 бол хүрэхээргүй ийм дүр зураг харагдаж байгаа.

Х.Булгантуяа: Номин гишүүн нэмж тодруулна.

Ч.Номин: Би тодруулахгүй үг хэлье ээ.

Ийм учраас бидний хувьд бол ДНБ ингээд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс гарч байгаа дүгнэлт дээр ингээд бид нар ДНБ-ээ төсөвлөсөндөө хүрэхгүй байж магадгүй дээрээс нь эрсдэлтэй байна гэж байгаа учраас бид бүхэн энэ дээрээ анхаарч хэрвээ эдгээр тоон үзүүлэлтүүд хүрэхгүй бол яах вэ гэдэг төлөвлөгөөгөө хийж засаж, энэ төсвийг сайжруулах төсвийн хүрээний мэдэгдлийг сайжруулах хэрэгтэй гэсэн дүгнэлттэй байгаа.

Х.Булгантуяа: Номин гишүүн үг хэллээ.

Улсын Их Хурлын гишүүн Жанчивын Галбадрах.

Ж.Галбадрах: Өглөөний мэндийг хүргэе та бүхэндээ.

Бид төсвийн хүрээний мэдэгдэл төсвийн талаар маш нухацтай ярьж засах зүйл оруулах ёстой. Тэгээд сая Учрал сайд хэлж байна л даа. Улс төржилтдөө төөрөөд бид нар явж байна гэж. Үнэхээр харамсалтай байна. Тэгээд энэ төсөв бол хүний хөгжлийг дэмжих төсөв, мега төсөл гэсэн ийм нэртэйгээр төсөв маань орж ирсэн. Тэгэхдээ бодлого байгаа. Тэгэхдээ төсвийн хүрээний мэдэгдэл бол бодлогын илэрхийлэл байх ёстой. Тэгээд энэ үнэхээр хангалтгүй туссан гэдгийг Байнгын хороон дээр ч хэлж байгаа, чуулган дээр ч өмнө нь хэлж байсан. Тэгэхээр хүний хөгжлийн бодлогынхон энэ асуудлуудыг бид нар тэр талаа барьж оруулах хэрэгтэй. Энэ дээр төсөв бол ард түмний татвар. Тэгээд үнэхээр ард түмэнд хэрэгтэй ийм амьдралыг нь дээшлүүлэх ийм төсөл болж чадав уу гэвэл болоогүй байна аа. Бид нар энэ дээр л уг нь нухацтай тал талаасаа яримаар байна. Тэгээд ард түмэн ерөөсөө хүсээд байгаа юм чанартай боловсрол баталгаатай эмнэлгийн үйлчилгээ л хүсэж байгаа. Тэгээд энэ чиглэл рүүгээ үнэхээр явж байна уу гэвэл энэ төсөл маань болоогүй. Үнэхээр би бол 2 асуудлын хүрээнд л асуугаад байгаа.

Яагаад гэвэл чанартай боловсрол олж авч чадахгүй. 30 гаруй хувь нь хүүхдүүд ялангуяа төрийн өмчийн сургуулийн 30 гаруй хувь буюу 230-аад мянган хүүхэд бол тэр даац хэтэрсэн хүртээмжгүй байдлаас болоод чанартай боловсрол олж авч чадахгүй байгаа. Тэгээд энэ асуудлыг шийдээч ээ. Энэ асуудлыг шийдэхийн тулд тооцоолол бид нар хийсэн. Тэгээд тэр тооцоолол маань өнөөдөр ерөөсөө энэ төсөвтөө тусаагүй ээ. Одоо тэгэхээр 41 төсөв арга хэмжээг АХБ-аар оруулна гэсэн. Тэгэхээр одоо бид нар энэ дотор нийслэлд ялангуяа тэр ачаалал нь маш хэт хэтэрчихсэн байгаа энэ төслүүд арга хэмжээг нэмэх талаар Лука гишүүн бид нар ийм тооцоолол хийгээд явж байгаа. Энийг тусгах боломж байгаа юу гэдгийг Сангийн яам, Боловсролын яамнаас асууя. Нөгөө талаас сая Мөнхбат гишүүн асууж байна.

Өчигдөр цалин нэмнэ гэдэг асуудал яригдсан. Тэгээд цалингийн эх үүсвэрээ хаанаас яаж гаргах гэж байгаа вэ? Бид нар цалинг 2 сая болгоход 2.9 сая болоход 2 дахин нэмэхэд 570 тэрбумаас 1.6 их наяд хэрэгтэй гэдэг тооцооллыг Сангийн яам Боловсролын яаманд өмнө нь гаргаж өгсөн. Тэгээд энэ дагуу энэ 1.8 сая эсвэл 2.5 сая болгоно гэж байна. Энэ үнэхээр тийм баталгаатай тийм эх үүсвэрүүдийг хаанаас олох вэ. Төрийн өмчийн компаниудын дээр ямар барих орлогыг нь яг бодитоор болгох, алдагдалтай байгаа компаниудыг татан буулгах зарлага тэнд гарч байгаа зарлагуудыг багасгах гэсэн ийм бодлогууд яригдаж байгаа. Тэгээд энэ хэрэгжих боломж нь хэр байгаа вэ гэдэг талаар Сангийн яам, Эдийн засгийн яамнаас асууя.

Х.Булгантуяа: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Яах вэ дараа нь мэдээж төсөв хэлэлцэх үеэр илүү дэлгэрэнгүй ярих байх. Одоо бол мэдээж нөгөө төсвийн хүрээ хэлэлцэж байгаа. Тэгээд ер нь боловсролыг дэмжих чанартай боловсролд төсөв мөнгө тусгагдаж тэгээд түүнийгээ мэдээж цаашлаад сургууль барилаа гэхэд хэн багшлах вэ гэдгийг нь бид нар тооцож төлөвлөж чадаагүй. Тэгээд л өнөөдрийг хүрчхээд л байна. Тэгээд мэдээж энэ чинь жил ирэх тус тутам барилга байшингийнх нь үнэ хөлс нь нэмэгдээд зарим нь дуусаж өгдөггүй. Тэгээд сургууль барилаа гэхэд нөгөө багш нар нь цалин бага учраас ажилд авахад бэрхшээлтэй байгаад байдаг. Тэгээд нөгөө төсвийн хүрээн дээрээ урсгалаа

нэмэгдүүлье гэхээр тэтгэвэр тэтгэмж хүүхдийн мөнгө гээд ингээд нэг хэдэн зардлаа шийдчихээд нэмэлт зардал шийдье гэхээр болж өгдөггүй. Тэгээд нэг хааяа сонгууль дөхөхөөр 10 хувь нэмчхээд болох байх гээд орхичихдог.

Нэг ёсны ийм бодлогогүй л яваад л ирчихсэний л гай л даа. Магадгүй багш нарын цалинг 10 хувь, эмч нарынхаа цалинг 10 хувь нэмээд ч өөрчлөлт гарахааргүй л байна шүү дээ. 10 хувь нэмэлт нэмээд амьдралд нь тийм нэмэр үзүүлж чадах уу гээд. Тэгэхээр энийг бол бид нар их өргөн агуулгаар нь харах ёстой юм байна.

Тийм учраас төсвөө эхлээд эрүүлжүүлж авах бодлого руу оръё оо л гэж хичээсэн. Сахилга баттай хариуцлагатай. Яг үнэндээ нөгөө төсөв өөрөө бодлоготой. Тэгээд ингээд яг ийм цаг үед мөчлөг сөрсөн төрийн оролцоог багасгасан хувийн хэвшил илүү ажиллах орон зайг тэлсэн. Хувийн хэвшлийн ажлын байрыг хадгалж үлдэхгүй бол хувийн хэвшил ч гэсэн нөгөө яг адилхан энэ эдийн засгийн агшилтыг дагаад савчихвал энэ хувийн хэвшилд байгаа ажлын байруудыг цаашдаа яах вэ? Тэгээд энэ чинь ядуурал улам нэмэгдэнэ. Ингээд эхэлнэ. Тийм учраас бид нар байгаа ажлын байруудыг хэрхэн, яаж хадгалж үлдэх вэ гэдэг ийм сонголт руу орсон.

Тийм учраас энэ удаа бол ийм төсвийн сахилга батыг л нэмэгдүүлэх зорилготой оруулж ирсэн энэ төсвийн хүрээг. Тэгээд ер нь яг энэ татварын реформ ч гэсэн их зөв хийгдэж эхэлж байгаа. Жишээ нь тэр нэрлэсэн ДНБ тэнцвэржүүлсэн орлогын харьцааг ингэж бууруулж орон зайг бий болгочхоод араас нь Татварын хуулийг үе шаттай явуулбал энэ амилна. Тэрнээс биш сонгууль дөхлөө гээд л энэ нийгэмд таалагдах юм байна. Энэ заалтыг өөрчилчихье гэж ингэж явсаар байгаад одоо чинь нөгөө бие даасан хуулиар зохицуулдаг олон хуультай учраас төр өөрөө цалин хөлсний нэгдсэн бодлого алга болчихоод байна шүү дээ. Бие даасан хууль болгоноор янз бүрийн юм чөлөөлж, хөнгөлж, нэмэгдүүлж хасаж явсаар байгаад. Тэгээд нөгөө Сангийн яам төсөв төлөвлөх гэхээрээ нөгөө олон хуулиа давж чаддаггүй. Тэгээд ийм л болчихсон. Тэгээд нөгөөдөх хуулиудыг нь өөрчлөөд нэг бодлого ингээд хэрэгжүүлээд явъя гэхээр нөгөөдхийг нь барьж орох гэхээр дараагийн сонгуулиа бодоод 2, 3 постоос айсан хүмүүс тал талд тийрээд ингээд явахаа больчихлоо л доо.

Тэгээд нөгөө яг ийм нөгөө цаг хугацааны хайчинд байгаад байдаг. Засгийн газар ингээд цаг хугацаандаа ажлаа хийгээд явъя гэхээр өөдөөс нь наад төсвөө буцаагаад ав гэх юм. Эсвэл засгийн газраа огцруул гэх юм. Тэгээд ингээд нөгөө ер нь нэлээн л тийм төвөгтэй байдалд байна. Тэгэхдээ мэдээж хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж байгаа. Бид нар төрийн ажил нэг ч хоног гацаж болохгүй ажил хэвийн үргэлжилж байгаа. Багш, эмч нар дээр ч гэсэн Ерөнхий сайд өөрөө уулзсан. Тэгээд өөрөө зарчмын саналуудаа хэлсэн. Салбартаа бол бид нар цалин хөлсний тогтолцоог томоор хараад ингээд явна аа. Их Хурал дээр ажлын хэсэг дээр ч гэсэн энэ саналуудыг нь тусгаад цалин хөлс нэмэгдүүлэх дээр явна анхаарна. Гэхдээ зөвхөн нэг 10 хувь, 20 хувь нэмээд нэмэр болохгүй нь ээ.

Тийм учраас багшийн хуулиа хэрэгжүүлээд нөгөө гүйцэтгэлийн үнэлгээ индикаторуудаа зөв тавиад явъя гээд Боловсролын яамтай ч гэсэн яриад явж байгаа. Энийг бол бид нар том агуулгаар нь харж бүтэн цогцоор нь шийдэхийн төлөө Засгийн газар ажиллаж байгаа.

Х.Булгантуяа: Наранбаяр сайд нэмж хариулъя.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр энэ багш нарын цалингийн асуудал өнөөдөр үнэхээрийн хурц тавигдаж байгаа. Түрүүн Учрал сайд хэлж байна. Энэ хуримтлагдсан энэ асуудлыг шийдэхийн тулд бид цалингийн бүтэцтэй нь уялдуулж цалингийн бүтэц, цалин нэмэгдүүлэх энэ асуудлыг хооронд нь уялдуулж хамтад нь авч явах ёстой гэсэн байр суурь дээр өчигдөр хүрсэн гэдгийг хэлье. Миний бие энэ уулзалтын дараа Ерөнхий сайдтай өчигдөр бол жагсагчдын төлөөллийг суулт хийж байгаа үйлдвэрчний эвлэлийн удирдлагуудын төлөөллийг уулзуулсан. Сангийн сайд байлцаж энэ ярилцсан яриан дээр нэлээн ажил хэрэгч яриа болсон. Энэ талаараа би өөрөө мэдээлэл хийсэн учраас энд товчилъё. 108 сургууль, 95 цэцэрлэгийн энэ байршлын тухайд сургуулийн тухайд гэхэд бол бид АХБ-нд эхний ээлжид Улаанбаатарынхаа ачаалал ихтэй байгаа сургуулиудыг оруулсан. Жишээлэх юм бол БГД дээр нийтдээ 15 сургууль 108-аас орсон бол үүнээс 2-ыг нь эхний ээлжид Азийн хөгжлийн банк.

Х.Булгантуяа: Наранбаяр сайд гүйцэд хариулъя.

П.Наранбаяр: АХБ-ны жагсаалтад мөн одоо БЗД-т 25 сургууль шаардлагатай гэснээс 4 сургуулийг, СХД-т 14 сургууль шаардлагатай байгаа. Үүнээс 4 сургуулийг СБД-т 6 сургуулиас 3-ыг, Хан-Уул дүүрэгт 18 сургуулиас 4 сургуулийг тус тус барихаар оруулсан. Ер нь ээлжийн коэффициент нь өндөр байгаа нь энэ нөгөө нийслэл дээр байгаа. Тэгээд бүлэг дүүргэлт хамгийн өндөр байгаа нь нийслэл дээр байгаа. Хүн ам нэмэгдсээр байгаа ийм нөхцөлд нийслэл дээрээ энэ хүн амын нягтралыг дагасан энэ сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх энэ асуудлыг бол юун түрүүн шийдвэрлэх ёстой учраас энэхүү жагсаалтыг бас тантай ярилцаж мөн газар зүйн ухаалаг системийг ашиглаж Сангийн яамтайгаа ярилцаж энэхүү хөрөнгө оруулалтыг бол эхний ээлжид шийдээд байгаа.

Ер нь ерөнхий хэлэлцээр явсны дараа бол тусгай хэлэлцээрүүд явна. Энэ дээрээ бас нарийвчилж тогтоох ийм шаардлага байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

Х.Булгантуяа: Галбадрах гишүүн нэмээд тодруулчих. Тэгээд хариулт явчихъя тэгэх үү? Тэгэхгүй бол. Галбадрах гишүүн нэмж тодруулна.

Ж.Галбадрах: Эрэмбийн тухай асуудлыг л яриад байгаа юм. Сая Наранбаяр сайд хэллээ. Тэгээд бид нарын хувьд бол үнэхээр нийслэл дээр үнэхээр байна. Хөдөө орон нутаг руугаа сургуулиа тавья. Нийслэл дээр нэг ийм 1 17 сургууль тавья гэж байсныг бид нар бол энийг 20, 23, 24 хүргэе ээ. Яагаад гэвэл өнөөдөр хүүхэд мэдээж хот руу төвлөрөөд байгаа тэр асуудал байгаа. Тэгэхдээ энийг бид нар өнөөдөр төвлөрлийг нь сааруулахын тулд хөдөө орон нутаг руугаа тавья гэхээсээ илүү өнөөдөр хүүхдийн эрх ашиг нь хохироод байгаа чанартай боловсрол олж авч чадахгүй байгаа энэ тал руугаа бид нар оруулж ирье гээд бүүр 3, 4 дахин даац нь хэтэрчихсэн сургуулиудыг л нэг номерт нь ингээд эрэмбэлээд гаргаад өгчихсөн байгаад байгаа юм. 108 сургууль маань. Тэгвэл энэ дарааллаар нь ингээд явах тал дээр тэгээд энэ чинь АХБ-аас орж ирж байгаа бид нар тэр бэлтгэлийг нь хангуулах энэ тал дээр нь тэр газрыг нь чөлөөлөх асуудал дээр нийслэлтэйгээ нэлээн ярьчихсан байгаа.

Х.Булгантуяа: Сангийн яам хариулъя. Сургууль цэцэрлэг, улсын төсвийн хөрөнгө оруулалтын эрэмбэлэл.

Ж.Дэлгэржаргал: Галбадрах гишүүний асуултад хариулъя. Сангийн яаманд Дэлгэржаргал.

Тэгэхээр Боловсролын яамтай хамтраад яг энэ жил хийсэн их өгөгдөл дээр гаргасан судалгаагаар бол 108 сургууль, 2028 оныг дуустал бид нар барьж байж яг ээлжийн коэффициентын 2 ээлжид барих юм байна аа улсын хэмжээнд. Цэцэрлэгийн хувьд 95 байгаа. 108 сургуулийн 84 нь Улаанбаатар хотод, 84-ийн 26 нь зөвхөн БЗД-т ч юм уу ийм хэрэгцээ байгаа.

Тэгэхээр улсын төсвийн хөрөнгө оруулалт дээр тусгасан төслүүдийн хувьд бол бид нар яг энэ эрэмбийг баримталсан. АХБ-ны хэлэлцээр дээр байгаа 41 төслийн 17 нь Улаанбаатарт, 15 нь орон нутагт. Орон нутагт сонгосон эрэмбийг Боловсролын яам ашиглалтын шаардлага хангахгүй нурааж барих шаардлагатай барилгуудыг сонгосон гэж ойлгосон. Тэгэхээр энэ 108 сургууль бол зөвхөн шинээр байрлах цаана нь ашиглалтын шаардлага хангахгүй нураагаад дахиад шинээр барих сургуулийн хэрэгцээ 26 байгаа. Тэгэхээр энэ 2-аасаа эрэмбэлж энэ 15-ыг.

Х.Булгантуяа: 4 номерын микрофон нэмж хариулъя. Гүйцэд хариулах уу? Болчихсон уу? Галбадрах гишүүн нэмж тодруулна.

Ж.Галбадрах: Би төгсгөлд нь үг хэлчихье ээ. Өнөөдөр бид нар ингээд байшин барилга тоног төхөөрөмж, ширээ сандал, тэгээд багшийн цалин яриад л ингээд суугаад байдаг. Тэгэхээр ийм байдалтай байхад улс хөгжихгүй байна л даа бид нар. Тэгэхдээ энэ бол суурь үндсэн юмыгаа хийхгүй бол бас цаашаа асуудал яригдахгүй байна. Бид нар өнөөдөр боловсролд хийх шинэчлэл, хөтөлбөрийн шинэчлэл, технологийн шинэчлэл энийг бас ярих хэрэгтэй байна. Багшийн хөгжлийг ярих хэрэгтэй байна. Хүүхдүүдийн дунд гарч байгаа энэ хүмүүжил төлөвшил хандлагын асуудлыг яримаар байна.

Өнөөдөр хүний санаанд оромгүй олон асуудлууд хүүхдүүд өсвөр залуучуудын хооронд явж байна. Үе тунгийн дээрэлхэлт бүүр газар авсан байна. Энэ бүгдийг ярих хэрэгтэй байна. Сургуулийн менежментийг ярих хэрэгтэй байна. Ингэж байж бид нар боловсролын чанарын тухай ярих хэрэгтэй. Тэгээд энэ талын асуудлууд төсөв дээр цааш цаашдаа ингээд суугаад явах ёстой. Бид нар энэ хөгжүүлэх энэ асуудлууд дээрээ анхаарах шаардлагатай байна гэдгийг хэлье.

Х.Булгантуяа: Галбадрах гишүүн үг хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан.

Л.Мөнхбаясгалан: Энэ Засгийн газраас одоо юугаа ч асуух вэ дээ. Асууна тэгээд л худлаа хариулна. Хоёрхон сайд танхимд байна. Бусад нь бодвол кнопоо тоолж яваа. Энэ Их Хуралд ажил хийе гэсэн сэтгэлтэй залуу, цэвэр тийм хүмүүс их орж ирсэн. Тэр хүмүүсийг өнөөдөр 1, 1-ээр нь гударч чирээд л миний талд кноп өгөөч ингээд гээд л явж байгаа. 2025 оны 6 сарын 29-ний өдөр энэ танхимд яг нэг иймэрхүү байдалтай 2026 оны Монгол Улсыг хөгжүүлэх төлөвлөгөөг бид нар баталсан байхгүй юу. Сайдууд байгаагүй. Бас л нэг Засгийн газар нь огцроод нөгөө Засгийн газар нь тавигдаад дахиад кнопоо тоолоод л гүйлдэж явсан. Би энэ Засгийн газрын эс үйлдэхүйг нээрээ үзэн ядаж байна аа. Юм мэдэж байгаа мөртөө хийдэггүй эс үйлдэхүй.

Одоо манай говийн бүсэд Дорноговь, Өмнөговь, Дундговьд ундны усан дээр эрдэмтэд шинжилгээ хийсэн. Хүн 44 сумын 300 гаруй ус худаг дээр хийсэн. Хүн ууж болохгүй гэж гарсан. Бүүр ийм байгаа шүү дээ. Хөхүүл эхчүүд, жирэмсэн эхчүүд, өсвөр насны хүүхдүүд унданд хэрэглэж болохгүй гээд. Ийм дүгнэлт гарчхаад байхад өнөөдөр энэ дээр ямар ч арга хэмжээ байхгүй, ямар ч бодлого байхгүй энэ Засгийн газарт. Энэ чинь эс үйлдэхүй. Говийнхныг үх гэж байгаа юм уу. Говьд зөвхөн уул уурхай байдаггүй. Тэнд хүүхдүүд, хүсэл мөрөөдөлтэйгөө өсөж торнидог, эхчүүд хүүхдээ төрүүлдэг. Хүмүүс амьдардаг, мал амьтан ургамал байдаг байхгүй юу. Гэтэл усны төлөө юу ч хийдэггүй. Очоод гуйгаад ярихаар өө тэгэлгүй яах вэ дээ говийн усаа хийлгүй яах вэ л гэдэг. Дандаа худлаа ярьдаг. Ус өнөөдөр говийн асуудал биш болсон.

Өнөөдөр Монгол Улсын асуудал болсон.

Дээрээс нь та нар багш нар цалин хүрдэггүй гэдгийг мэдэхийн дээдээр мэддэг, ямар ч бодлого байхгүй. Эмч нар өнөөдөр гадаа жагсаж байгаа. Эмч нарыг мэддэг л гэдэг. Ямар ч ажил хийгээгүй, хуруугаа ч хөдөлгөөгүй.

Дээрээс нь та нар малчдад хөдөө орон нутагт явахаараа нэг их худлаа бэлэн амладаг. Өнөөдөр малчдын амьдралыг сайжруулах малын гаралтай түүхий эдийг үнэд оруулах ямар ч бодлого байхгүй. Дээр нь малчид малаа маллаад эх орондоо тайван сайхан амьдарч чадахаа байсан. Ийм эс үйлдэхүй хийчхээд өнөөдөр энд худлаа яриад суугаад байх хэрэг байхгүй ээ. Энд ингээд яамдын ТНБД нараас доошоо ингээд хүмүүс ажил хийдэг хүмүүс ирчихсэн ингээд бид нарын хөлд чирэгдэж байгаа байхгүй юу. Хэдэн өдөр энэ хүмүүс явав аа. Нэг сайд гарч ирээд л нэг худлаа юм ярьдаг. Буцаад л нөгөө юм нь задардаг буцаад л явдаг. Энэ хүмүүс чинь бүр ажил хийх ч сонирхолгүй болсон.

Дээрээс нь зөвхөн цалинг нь тавьдаг. Ямар ч ажил хийе гэсэн мөнгийг нь өгдөггүй. Тэгээд төрийн албан хаагчид амьгүй байна эд нарыг цомхотгоно гэж яриад цомхотгоод эхэлсэн. Үгүй цалинг нь л өгнө. Өөр юм хийлгэх боломжийг нь тавьж өгөхгүй байгаа юм чинь ямар төрийн албан хаагч өнөөдөр ажил хийх юм. Өнөөдөр энэ танхимд дахиад л арван хэдэн гишүүн сууж байгаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Мөнхбаясгалан үг хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Пүрэвбаатарын Мөнхтулга.

П.Мөнхтулга: Хоёрхон сайд байна. Тэгээд байхгүй хүнээс юм асуултай нь биш дээ. Байгаа 2-оос нь л асууя. Тэтгэвэр, цалин нэмэх гээд эх үүсвэр олдохгүй байна гэж байгаа юм. Эх үүсвэр олох олон арга замуудыг манай АН-ын гишүүд хэвлэлээр ч нэг индрээс ч нэг бүгдээрэнгээр нь хэлж байгаа. Тэгэхээр энэ төсөв хэлэлцэх үеэр төсвийн хүрэн дээрээ өнөөдөр бид нар хэлэлцэж байгаа үедээ олуулаа энийг маш анхааралтай сонсмоор байна.

Жишээ хэлье төрийн албан хаагчдыг зүлэг тайрч байгаа юм шиг 9 хувь гээд бүгдийг нь тайраад хаячхаж байгаа юм. Тийм модон шийдвэр гаргаж байгаа. Энд чинь хүн дутагдаж байгаа салбар гэж байгаа, хүн илүүдэж байгаа дарга нар илүүдэж байгаа салбар гэж байгаа. Энэн дээрээ анализ хийдэггүй юм уу. 2016 онд Монгол Улс 170 мянган төрийн албан хаагчтай байсан байна. 2024 онд 226865 болж өссөн байна. Тэгтэл И Монголиа дээр 1268 төрийн үйлчилгээ цахимжсан байна. Ингээд

хүний оролцоо багасаад төрийн үйлчилгээ нь 1268 төрийн үйлчилгээ цахимжчихаад байхад төрийн албан хаагчийн тоо ингээд хэд дахин өсөөд байгаа юм.

Тэгэхээр энэ дээр анализ хийдэггүй юм уу? Тэгэнгүүтээ дараагийн Засгийн газар нь гарч ирэнгүүтээ бүх салбараасаа 9 хувийг зүлэг тарьж байгаа юм шиг тайрч хаяна гээд. Ингэхлээр чинь бид нар яаж хөгжих юм бэ? Боловсролын салбар эрүүл мэндийн салбар 2 чинь хүн дутаж байгаа. Тэгтэл зарим салбаруудын дээр дарга нарын тоо ихэсчихсэн байгаа. Тэгээд энэ дээрээ анализ хийхгүй юм уу? Засгийн газар. Эндээс чинь маш их эх үүсвэр олдоно оо. Тэтгэвэр нэмэх эх үүсвэр олдоно. Хэрэггүй хүмүүсээ өндөр цалинтай дарга нараа хасаад, хэрэгтэй байгаа тэр нийгмийн асуудлыг нь шийдэх боломжууд эндээс гарч ирнэ. Модон шийдвэр гаргаж зүлэг тарьж байгаа юм шиг ингэж төрийн албан хаагч нарыг бүгдээрэнг нь бүх салбараас нь 9 хувиар хасаж болохгүй. Энэ дунд чинь ажил сайн хийж байгаа салбартаа үнэлэгдэж байгаа хүмүүс зөндөө байгаа.

Хоёрт нь манай Монгол Улс нэг гаднынхнаас жоохон ичмээр байна аа. Онгоцны буудал дээр буухаар иргэдийнхээ чемоданыг ухаад зогсчих юм. Үгүй тэр хүүхдүүддээ авсан 2, 3 нөт бүүкээс нь татвар авна гээд зогсчих юм. Тэгсэн мөртөө гаалиар гарч байгаа шланзыг ерөөсөө харахгүй байна гэнэ ээ. Хэдэн 100 шланз, нүүрс, ачаа гарч байхад гаалийн байцаагч нар нь харахгүй байгаа мөртөө хүний чемоданд байгаа хүүхдүүддээ авсан хэдэн юмнаас нь татвар авна гээд. Энэний тоог асуумаар байна. Яг чемоданаас ухсан татвар чинь хэд юм? Гаалиар нүдээ аньж гаргасан.

Х.Булгантуяа: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Ер нь их өргөн агуулгатай асуулт. Тэгээд Мөнхтулга гишүүн бол яг л бодит амьдрал л хэлж байна. Тийм төрийн үйлчилгээ бол 1200 гаруй цахимжсан нь үнэн. Тэгээд энэ ажлыг би салбарын сайд байхдаа хийсэн. Тэгээд тухайн үед та нар цаас нэхээд байна, та нар хүнд суртал үүсгээд байна гар утсаар үйлчилгээ авч болоод байхад биеэрээ очихоор яахаараа 3 удаа цонх дамждаг юм бэ гээд зөндөө хэлсэн. Тэгээд шаардсан шахсан. Ямар ч байсан эхний үр дүн хороодоор бүртгэлийн байцаагч байхаа больчихсон байгаа юутай ч. Нөгөө тэнд байхгүй байхад юу ч өөрчлөгдөхгүй байгаа. Яагаад гэвэл И Монголиа -аар үйлчилгээгээ аваад явж болж байгаа. “хур” гээд байгаа систем төрийн өөрт байгаа мэдээллээ иргэнээсээ нэхэхгүй болж чадсан. Тэгээд энийг хийхгүй эс үйлдэл гаргасан. Тэгээд би сая тэр Гашуун сухайт дээр очиж ажиллахдаа манай нөгөө экспортын ажлын хэсэг өнгөрсөн 3 сард цахимаар авч байгаа болж байгаа мэдээллийг иргэнээс нэхсэнээрээ гааль дээр машинтай очсон хүн 8 удаа бууж суудаг энэ аймшигтай хүнд суртлаа болиоч ээ.

Дээрээс нь гаалийн байцаагчид хууль давсан 55 эрх олгочихсон, өөрийн үзэмжээр шийднэ гээд ийм бараг шүүгч шиг ийм дотоод итгэл үнэмшлээрээ шийднэ гэдэг шиг үзэмжээрээ шийддэг ийм даварчихсан нөхдүүд байсан. Тэгээд энэ 55-ыг нь цуцалсан. Одоо тэр журам өөрчлөгдсөнөөрөө цахимаар мэдээлэл солилцож байгаа учраас тэнд ямар ч асуудал үүсэхгүй байгаа. Тэгээд анх та нар яагаад ингээд цаасаар нэхээд байдаг юм бэ гэхээр энийг чинь хүн заавал ажил хийлгэхгүй, энэ орон тоогоо багасгачих. Цахимжиж байвал хүн багасгах ёстой байхгүй юу. Агуулга нь гэтэл манайх эсрэгээр яаж явсан бэ гэхээр цахимжиж байх тусмаа хүнээ нэмээд байсан юм байна лээ. Яагаад вэ гэхээр нэг систем хийнгүүт энийг ажиллуулдаг 5 хүн авъя гэж ингэсээр байгаад бүр цахимжих тусмаа ингээд том болоод тэгж

болохгүй л дээ. Тэгээд үүнтэй нэлээд их тэмцэл өрнүүлээд тэгээд одоо бол нэг үеэ бодвол их аятайхан болж байгаа.

Тэгээд энэ нөгөө би хэдийгээр Цахимын сайд биш ч гэсэн Учралаа бараг чамаас боллоо гээд надад иргэд их хэлдэг хэлдэг учраас би ингээд байнга санаа тавьдаг. Тэгээд нөгөө Эдийн засаг сайдын хувиар наад нэг зөвшөөрөл иргэнээс аваад байгаа энэ олон бичиг баримтуудыг цэгцлэх гээд одоо нөгөө зөвшөөрөл мэдэгдлийн хуулийг өргөн барьчихсан байгаа. Түүний дараа бол зөвшөөрөл гэдэг нэрийг өөрөөр нэрлэсэн нөгөө олон бүртгэл, магадлан итгэмжлэл, сертификат бүртгэл энэ тэр гэдгийг бүгдийг нь байхгүй болгоод дан зөвшөөрлөөрөө явна. Зөвшөөрлийг цахимаар Лайсенс мн дээр бүгдийг нь хийчихсэн байгаа. Ер нь ингээд хүнд суртал бууруулах ажлыг ингээд л шат шатад үзээд л байгаа. Нэг үеэ бодвол ахиц гарч байгаа. НҮБ ч гэсэн цахим засаглалын индексээр манайхыг бол нөгөө ер нь хөгжил гэдэг зүйл чинь нөгөө өнөөдөртэй нь харьцуулж явдаг болохоос биш манайхыг Сингапуртай, Солонгостой ингээд харьцуулаад байвал явахгүй л дээ. Тэгээд муу сурдаг 60-аар “D” авдаг хүүхдийг 90-ээр “A” авдаг хүүхэдтэй харьцуулбал муу ч гэсэн өнгөрсөн жил 60 байсан хүүхэд энэ жил 70 авбал сайн байхгүй юу. Тэрийг нь үнэлээд явахгүй болохоор ингээд болохгүй л байна.

Тийм учраас ер нь энэ хүнд сурталтай тэмцэх ажил үргэлжилнэ ээ. Сая 9 хувийн хэмнэлт бол яг өөрийн чинь хэлж байгаа зөв. Ер нь төсвийн ерөнхийлөн захирагч өөрөө аль салбартаа 10 хувь хэмнээд аль салбартаа 20 хувь хэмнээд алин дээрээ огт хэмнэхгүй байгаагаа өөрөө шийдэх ёстой. Тэрнээс ингэж тайраад хаячихсан юм шиг бүгдийг нь. Зарим газар бүүр хүн нэмэх хэрэгтэй байгаа шүү дээ. Одоо зарим хил дээр бол 24 цаг энэ тэр болгох 10 цаг хүртэл ажиллуулах чинь хүн нэмэх хэрэгтэй байх, бүүр багасгах биш. Зарим газар бүүр татан буулгах хэрэгтэй байгаа.

Тэгэхээр энэ ажлуудыг нөгөө чиг үүргийн шинжилгээ хийж байж хийнэ ээ. Тэгэхдээ 9 хувийн хэмнэлт их сайн зүйл нь юу вэ гэхээр 2.2 их наядын хэмнэлт хийсэн. Тэгээд энэ их сайн богинохон хугацаанд.

Х.Булгантуяа: Сангийн яамнаас нэмж хариулъя. 4 номерын микрофон.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж гишүүний асуултад хариулъя аа.

9 хувийн цомхотголын гол агуулга нь бол юу вэ гэхээр төрийн албан хаагчдын энэ зохистой харьцааг бол тогтоох. Цаашлаад Төрийн албаны тухай хуулийнхаа энэ шинэчлэлийг хийх ийм зорилгоор бол хийсэн. Энэ жилийн бол улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөн дээр үүнээс гадна бол урсгал зардлыг 24 хувьд бууруулж барих ийм бодлого гарсан. Ер нь төсвийн бодлогын хувьд бол төсвийн бүтцээ бол бид нар зөв болгож авах сахилга батаа сайжруулах асуудал хамгийн чухал байгаа. Үүний тулд бол энэ урсгал зардлыг 24 хувьд барих асуудал бол бидний хувьд бол хамгийн чухал. Энийг бид нар 2-оос 3 жилийн хугацаанд хэрэгжүүлээд авчих юм бол ер нь энэ төрийн оролцоо буурах ийм хандлага байгаа.

9 хувийн цомхотголтой холбоотойгоор бол гомдол саналын асуудал бол харьцангуй бол одоогоор бол гайгүй байна. Засгийн газрын Хэрэг эрхлэхээс бол энийг бол зохион байгуулж бол чиглэл өгч ажиллаж байгаа.

Х.Булгантуяа: Мөнхтулга гишүүн нэмж тодруулна. Тодруулах асуулт маань гаалийн нүүрснээс орж байгаа татварыг бид нар мэдэж байгаа. Бүтэн шланзыг нүдээ аниад өнгөрөөчихдөг өө. Олон 100 машин дутсан гээд л энд улс төрждөг. Яг иргэдийнхээ халаасыг ухаад, чемоданыг нь ухаад онгоцны буудал боомтууд дээр хэдэн төгрөгийн орлого цуглуулаад байгаа юм бэ? Гадныхнаас ядаж ичил дээ. Энд ийш тийшээ гадагшаа явсан хүмүүс байж л байгаа шүү дээ.

Хаана, хэзээ, ямар онгоцны буудал дээр иргэдийнхээ чемоданыг ухаад зогсож байсан юм. Яг эндээс тэгж ухаад олсон орлого нь тэр нүүрсээр нүдээ аниад гаргаж байгаа шланзнуудаас чинь хэр зөрөөтэй юм бэ л гэж асууж байгаа юм. Яг тэр гаалийн татварын мэдээг надад өгөх хэрэгтэй. Бид нар ийм их мөнгө.

Х.Булгантуяа: Сангийн яаман дээр. Тэр тоон мэдээлэл нь та бүгдэд байна уу? 4 номерын микрофон.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж гишүүний асуултад хариулъя. Монгол Улсын гаалийн байгууллага бол хуулиар ноогдуулсан чиг үүргийнх нь дагуу бол зохих ажлуудыг хийж байгаа. Мэдээж хэрэг дутагдалтай талууд байгаа. Гэхдээ бол хийх хуулийн дагуу хийх ёстой ажлууд бүгдийг нь хийж байгаа. Бүх иргэдийн чемоданыг бол гаалийн байгууллага нисэх дээр бол шалгаж үздэггүй. Зөвхөн зөрчилтэй нэг төрлийн бараанаас бол олноор оруулж ирсэн худалдан борлуулах зорилготой ч байдаг юм уу ийм зүйлийг л шалгадаг. Тэрнээс биш бүх хүмүүсийнхийг шалгаагүй ээ. Энэ нь бол бүгд хууль журамд нийцсэн байгаа. Нүүрсний машины хувьд бол гааль бол өөрөө бол гүний гааль дээр шалгалтаа явуулчихдаг. Сканер бол байдаг аа. Тэрүүгээрээ бол уг машинд бол хориотой болон гаргаж болохгүй ийм бусад бараа бүтээгдэхүүн байгаа юу гэдгийг бол бас шалгаж байгаа. Үүн дээр бол мөн хил хамгаалах байгууллага бол оролцож ажиллаж байгаа.

Х.Булгантуяа: Мөнхтулга гишүүн нэмж тодруулна.

П.Мөнхтулга: Тэр журмыг өөрчилж болно оо. Журмыг өөрчилж болно. Бид нар тоо асуугаад байгаа юм. Үнэхээр тэгж иргэдийнхээ чемоданыг ухах шаардлагатай бол тэгээд ухъя. Тэгээд тэр нүүрснийхээ гаалийн асуудлыг зохицуулах ёстой бол зохицуул. Надад тоо нь хэрэгтэй байна шүү дээ. Тэр чемоданыг нь ухаад олж байгаа орлого нь бага больё л доо ичмээр шүү дээ. Иргэдээ дарамтлах татвар нэмсэн юм дутаагүй шүү дээ Монголд. Тэгээд ядаж нэг эх орондоо ирэхэд нь тэр чинь аюулгүй байдлыг нь олон улсын онгоцны буудлууд бүгдээрээ хангаад л ирсэн байгаа шүү дээ. Маш олон шалгуураар даваад л ирсэн байгаа шүү дээ. Тэгээд эх орондоо ирэхэд нь манай Монголчууд л гэж нэг бие биеийгээ дарамталсан. Монголд ирэхлээр л нэг тийм буюу мэдэрэгддэг шүү дээ. Тэгээд энийгээ больчхож болохгүй юм уу. Тэр тоо нь тийм их байдаг юм уу л гэж асуугаад байгаа юм. Тоо асуугаад байгаа юм.

Х.Булгантуяа: Сангийн яам тийм тоо нь байна уу?

М.Санжаадорж: Сангийн яам, Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя аа. Тэр тоо бол надад яг одоогоор бол бэлэн биш байна. ГЕГ руу бол бид нар дөнгөж сая мэдэгдчихлээ. Тэгээд гишүүнд шаардлагатай мэдээллийг нь ирж уулзаад тайлбарлаад түрүүний журам дээр мөн сайжруулах боломжтой зүйлүүд байна уу эсвэл хөнгөвчлөх боломжууд юу байна гэдэг талаас нь тантай зөвлөлдөөд энэ дээр бол дорвитой шийдлийг гаргаад тэгээд

эргээд мэдэгдэнэ үү гэдэг байдлаар мэдэгдсэн байгаа. Тэгээд удахгүй тантай холбогдох байх аа.

Х.Булгантуяа: Сангийн яам түрүүн Үндэсний аудитын газар Цогтбаатар гишүүний хэлсэн тэр мэдээллийг гаргаж өгөөрэй. Улсын Их Хурлын Тамгын газраас үүний араас нь та бүгд хяналт тавиадхаарай. Улсын Их Хурлын гишүүн Банзрагчийн Түвшин.

Б.Түвшин: Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая аа. Тэгээд 2026 оны Төсвийн хүрээний мэдэгдэл, 2026, 2027, 2028 оны энэ асуудлыг хэлэлцэж байна. Тэгэхээр өнгөрсөн 5 жилийн төсвийн хүрээний мэдэгдэл дээр Монгол Улсын нийт урсгал зардал 2020-2024 оны байдлаар бол жилийн дундаж өсөлт нь 26.2 хувь байсан байна. Харин эсрэгээрээ ДНБ-ий өсөлт нь бол 17 хувь байсан. Тэгээд яг энэ трендээр нь харах юм бол 2028 онд урсгал зардлыг нь ДНБ-д эзлэх хувь 30 хувиас хэтрэхээр буюу төсвийн тусгай шаардлагыг шаардлагыг бол зөрчихөөр өөр байгаад байгаа. Нөгөөтээгүүр энэ Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн асуудал дээр бол Сангийн яамны тооцоолсноор төсөвт 4 их наядын нөлөө үзүүлэхээр байгаа. Энэ нь бол ДНБ-ий 3-аас 4 хувь байгаа. Энэ өөрчлөлт нөлөөллийг төсвийн тусгай тэмцлийн тусгай шаардлагуудыг 2027 онд зөрчигдөхөөр ингэж харагдаж байгаа. Тэгэхээр энэ тооцооллуудыг яаж хийсэн бэ? Энэ талаар 1 дүгээрт хариулаач.

Хоёрдугаарт, ирэх онуудад БНХАУ-ын эдийн засгийн өсөлт бол саарах төлөвтэй. Бүх төрлийн гадаад дотоод мэдээллүүдээс авахад тийм байгаа. Манайх бол 2026 онд ДНБ-ий өсөлтийг 5.7 хувь хүрэхээр ингээд тооцоолсон. Хэрвээ энэ хүрэхгүй тохиолдолд ямар хөрөнгө оруулалт болон урсгал зардлуудыг яаж царцаах вэ? Ямрыг нь хэвээр хадгалах юм. Ер нь энэ дээр Засгийн газраас боловсруулж байгаа хувилбарууд байгаа юу?

Гуравдугаарт, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль 2010 онд анх эхлээд батлагдсанаасаа хойш 21 удаа өөрчлөгдсөн. Үүнийг хараад дагаад дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл бол төсвийн дагалдах бичиг болсон. Тэгээд энэ дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг мэргэжлийн бичиг баримт болгох үүднээс хамгийн багадаа 15-аас 20 шаардлагыг нэмж оруулаад мэргэжлийн харьцаа аналитуудыг оруулж байж энэ чинь цаашаагаа ийм хүчирхэг бичиг баримт болох юм байгаа юм.

Тэгэхээр одоо бид нар мөчлөг сөрнө өө л гэж ярьж байгаа юм. Мөчлөггүй үеийн ДНБ-ийг яаж тооцож байгаа вэ? Мөчлөг нь өөрөө эдийн засгийн үзүүлэлтээрээ хэд болж байгаа вэ? Мөчлөгийг аль урсгалаар нь бууруулаад ямар нөлөөлөл гарна гэж энэ тооцооллууд гарсан бэ гэдэг асуулт энэ өмнө нь цухас дурдаж байсан.

Дөрөвдүгээрт хэрэглээний индексийг 7 хувь байхаар төсөвлөсөн, тооцоолж байгаа. Үнэхээр хэрэглээний үнийн индексийн энэ нөлөө үзүүлэлт бол төсвийн зардал тэр, дотроо үр ашиггүй зардал бол хэрэглээний үнийн индекс буюу энэ инфляцад бол нөлөөлнө өө гэдэг ийм судалгаа гарсан байж байгаа. Тэгэхээр энэ 7 хувь дотор манай төсвийн урсгал зардал хэдэн хувийн нөлөө үзүүлж байгаа вэ? Ер нь хэдэн хувийн нөлөө үзүүлнэ гэж тооцоолсон, энэ инфляцыг барихын тулд төсвийн зардлыг ер нь яаж цэгцэлж барих ёстой вэ гэдэг тал дээр ямар бодлого орж байгаа вэ? Энэ тал дээр асуулт тавья.

Х.Булгантуяа: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: ДНБ-ий бодит өсөлтийн хэмжээг өмнө нь батлагдсанаар ббайсныг 5.7 хувь байна гэж тооцсон. Ер нь ДНБ өсөлт хүрэхгүй үед бол бид нар зогсолт хийх биш илүү тэлэх бодлого явуулах нь илүү зохимжтой. Тэгээд түүн дээрээ мэдээж нэг мөчлөг сөрсөн бодлого хэрэгжүүлбэ гэдэг зорилгоор бид нар нэг төрийн оролцоог бууруулах хувийн хэвшлээ дэмжих энэ бодлого бол энэ удаагийн төсвийн бодлого байна гэж зорьсон. ДНБ-ий нийт өсөлт 5.7 хувь гэж байгаа бол дотор нь жишээ нь салбар, салбараар нь, жишээ нь уул уурхайн салбар бол энэ өсөлтөд 11.9 хувь өсөх нь. Хөдөө аж ахуй бол 9.4 хувь, боловсруулах салбар 6.7 хувь, барилга 14.5, эрчим хүч 8.8 хувь өсөхөөр ингэж бол тооцсон. Тэгэхээр энэ 5.7 хувь дахь салбаруудын оролцоог бид нар нэгж хувиар нэмэгдүүлнэ гэж тооцож байгаа буюу уул уурхайн салбар бол 1.7 нэгж, ХАА 0.9, боловсруулах 0.5, барилга 0.5, эрчим хүч 0.2, бусад салбар бол 1.9 нэгж хувийг бол бүрдүүлнэ гэж үзэж байгаа. Ер нь энэ 5.7 -д хүргэхэд бол мэдээж нэг хэд хэдэн зүйл нөлөөлөлтэй. Оюу толгойн зэсийн баяжмал үйлдвэрлэл өснө гэж үзэж байгаа. Зэсийн агуулга нэмэгдэнэ гэж тооцож байна.

Алт зэсийн үнэ бол дэлхийн зах зээл дээр нэмэгдэж байна. Алт өчигдөр түүхэн дээд түвшиндээ үнэ нь хүрлээ. Тэгэхээр энэ бүтээгдэхүүнүүдийн үнэ өсөж байгаа бол үүн дээр Засгийн газар бодлогоо хэрэгжүүлэх ёстой. Тэгэхээр нөгөө байгаа лицензүүдээ эргэлтэд оруулах боловсруулах үйлдвэрүүдээ барьж байгуулах ажлууд руу мэдээж анхаарна. Энэ хүрээндээ Дархан, Эрдэнэт, Багануурын үйлдвэр, технологийн паркууд бол энэ өсөлтөд хувь нэмрээ оруулна. Хил холболтын төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор бол нүүрс олборлолт нэмэгдүүлэх учраас ирэх жил 90 сая тонн хэмжээнд хүрнэ гэж төлөвлөсөн. ХАА-н салбарт бол бид нар санхүүжилт дээр тодорхой өмнөх жилтэй харьцуулахад илүү дэмжлэг үзүүлж байгаа. Тэгэхээр тэр хүнсний хувьсгал, Атрын-4, Цагаан алт хөтөлбөрүүдийг бол бодлогоор дэмжинэ.

ХАА-н бол салбар энэ өсөлтөд тодорхой хувь нэмэр оруулна гэж үзэж байгаа. Хувийн хэвшлийг дэмжих орон зайг бол бий болгох зорилгоор түрүүн хэлсэн. Тэр нийт GDP тэр орлого 2-ын харьцааг 30 руу буулгаснаараа бид нар энэ хувийн хэвшлийг дэмжихэд бол илүү анхаарч байгаа. Тэр хүрээндээ Бөөрөлжүүт Тосон ДЦС болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтад тулгуурласан сэргээгдэх эрчим хүчний үйлдвэр салбарыг илүүтэй дэмжинэ гэдэг зорилгыг тавьсан. Тийм ч учраас төсөв дагуулаад өргөн мэдүүлсэн Төр хувийн хэвшлийн түншлэлийн хууль аймаг орон нутагт бие дааж төсөл хэрэгжүүлэх бололцоог бий болгож байгаа. Энэ бол өөрөө хувийн хэвшлийг бодлогоор дэмжинэ гэж бол ойлгож болно.

Хэрэглээний үнийн индекс бол Монголбанкны интервалд дотроо бол байгаа. Мэдээж бид нар энэ инфляцыг барихын тулд урсгалаа 24 хувьдаа барьж энэ удаагийн төсвийг оруулж ирсэн. Нэг талаасаа бол энэ урсгалыг 24 хувьдаа барих орлого зарлагаа бууруулах энэ тусгай шаардлагууд бол мэдээж энэ үнийн өсөлтөд хувь нэмрээ мэдээж оруулна. Тэгэхээр ер нь бол нэг Монголбанкнаас барьж байгаа.

Х.Булгантуяа: Учрал сайд нэмж хариулъя.

Н.Учрал: Тэгээд ер нь цаашид Монголбанк өөрөө инфляцаа 6 хувиас бууруулаад 5 хувь болгож байгаа. Тэгэхээр энэ бол маш зөв бодлого. Тэгэхээр энэ бид нар бодлогыг инфляцын энэ бодлоготой уялдуулахын тулд бол урсгалаа

дахиад бууруулах ер нь бодлого барина. Тэгэхээр энэ Татварын хууль ч тэр, энэ реформууд ч тэр явна. Ирэх жил тэр урсгал зардлын 24 дахиад буух ёстой. Тэгж төсөөлж байгаа. Ингэснээрээ бид нар урсгал зардлыг өндөр байлгахгүй байснаараа инфляц нэмэгдүүлэх эрсдэлийг багасгана. Мэдээж жишээ нь төсөв тодорхой алдагдалтай байгаа хэдий ч энэ чинь төлбөрийн тэнцэлд шууд нөлөөлөхгүй. Энэ чинь нөгөө гадаад зээлийн эх үүсвэр учраас. Тийм учраас бол яах вэ зүгээр ер нь Засгийн газраас зарим нэг ийм зохиомол үнийн хөөргөдөл үүсгээд байгаа бүтээгдэхүүн дээр хэд хэдэн судалгаа хийлгэж байгаа юм. Зарим салбарт нэг.

Х.Булгантуяа: Ажлын хэсгээс нэмж хариулах уу? 4 номерын микрофон.

Л.Энх-Амгалан: Түвшин гишүүний асуултаас үлдсэн хэсэгт нь нэмж хариулъя. Төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчлөх тал дээр байгаа 9 макро эдийн засгийн тоогоо задлах тал дээр бол таны ярьж байгаа санал дээр зарлагыг салбар салбараар нь ангилаад зорилтот түвшнүүдээ ирэх жилүүдэд ямар түвшинд авч явах вэ гэдэг талаар нь илүү хөгжүүлбэл бас боломжтой байх гэж харж байгаа. Мөчлөг сөрсөн бодлогын хувьд бол яг өнөөгийн нөхцөл байдлаар эдийн засгийн идэвхжил сулраад потенциал түвшин үйлдвэрлэлийн бодит хэмжээ 2 маань ирэх жилд сөрөг тал руугаа явах магадлалтай эрсдэлтэй гэж бид нар үзэж байгаа. Энэ утгаараа саяын төсвийн тодорхой хэмжээний алдагдалтай бодлого барьж орж ирж байгаа. Алдагдлын хэмжээг тэгэхдээ тууштай байнгын ужгируулаад явах юм бол мэдээж мөнгө санхүү мөнгөний тал дээрээ тогтворгүй байдалд аваачна.

Тэгэхээр бид нар алдагдлыг 2026 онд 1.3 хувь, 2027 онд 0.7 хувь, тэгээд 0.4 хувь гээд үе дамжуулаад үе шаттайгаар бууруулах чиглэлээр бодлого барьж байгаа.

Түвшин гишүүн нэмж тодруулна.

Б.Түвшин: Яах вэ ер нь бол энэ мөчлөг сөрсөн бодлого гээд ярьдаг. Тэгээд ямар нэгэн юм сөрөх гээд үүнийхээ эсрэг төсвийн зардлаа нэмдэг, эс үгүй бол төрийн оролцоог нэмэгдүүлдэг. Тэгэхээр ер нь цаашдаа энэ төсвийн хүрээний мэдэгдэл дээр мөчлөггүй үеийн төсвийн хүрээний мэдэгдэл мөчлөгөө эдийн засгийн тооцооллоор харуулдаг болох ёстой. Тэгээд ийм мөчлөгийг ийм байдлаар сөрж байж бид нар ийм болгоно оо гэдгээ мэргэжлийн түвшинд харуулахгүй бол бүх л засгийн газрууд бүх цаг үеүдэд мөчлөг сөрж байна л гэж ярьдаг. Мөчлөгтэй ч байдаг ч юм уу мөчлөггүй ч байдаг юм уу ийм мэргэжлийн бус харилцаа хандлагууд байна аа.

Тийм учраас саяын хэлсэн тэр төсвийн хүрээний мэдэгдлийг олон үзүүлэлтээр аналитууддаа гаргах ёстой.

Хоёрдугаарт ерөөсөө энэ төсвийн хүрээний мэдэгдэл чинь өөрөө чиг баримжаа шүү дээ. Яг нарийвчилсан ширхэгчилсэн тоо биш. Сая Учрал сайдын хэлж байгаа бол хүрэх гэж байгаа зорилтууд талаасаа ярьж байна. Яах вэ нэг талаасаа зөв. Нөгөө талаасаа энийг бид.

Х.Булгантуяа: Түвшин гишүүн нэмж нэг минут.

Б.Түвшин: Энийг бид нар нэг бүрчлэн гаргаж байж энэ нийгэм эдийн засагт нөлөөлөөд байгаа үзүүлэлтүүдийг тооцно л доо. Жишээлбэл одоо энэ урсгал

зардлыг хасъя гээд ярьж байгаа. Маш зөв. Ерөөсөө энэ урсгал зардал чинь хамгийн чухал нь биш. Үр ашиггүйдээ байгаад байгаа. Сая Говь-Алтай аймагт явж байхад жирийн нэгэн багш босож ирээд хэлж байна лээ шүү дээ. Энэ жил болгон устгаж байгаа энэ хөтөлбөрийн номуудыг хэдэн төгрөг болдог гэж бодож байна вэ? Цахимаар явуулж байгаа хөтөлбөрүүд нь чанаргүй үр ашиггүй байгаад байна. Гэтэл жил болгон хэдэн 10 мянган хөтөлбөр, номуудыг авдаг, эцэг эхчүүд нь худалдан авах шаардлагатай болдог тэр устгалууд нь явж байна гэж байгаа юм. Иймэрхүү үр ашиггүй зардлууд чинь нэг талаасаа төсвийг алдагдалтай болгоод байгаа, нөгөө талаасаа инфляцыг нэмэгдүүлээд байгаа.

Гурав дахь талаасаа төрийн оролцоог нэмэгдүүлээд байгаа шүү дээ. Урсгал зардлыг хасна гэдэг бол ямар үйл ажиллагааг цэгцэлж энэ үйл ажиллагаа оновчтой зардалтай болгох вэ гэдэг асуудал болохоос биш шууд механикаар хасах асуудал биш байгаад байгаа юм. Ийм учраас энэ тал дээр инфляцтай холбож ярих нь зүйтэй байх шүү.

Х.Булгантуяа: Түвшин гишүүн санал хэллээ.

Улсын Их Хурлын гишүүн Өлзийхүүгийн Шижир.

Ө.Шижир: Өдрийн мэнд. Уг нь төсвийн хүрээний мэдэгдэлтэй нийцүүлээд төсөв оруулж ирэх ёстой юм. Тэгээд одоо бол ер нь төсөвтөө тохируулаад төсвийн хүрээний мэдэгдлээ өөрчлөхөөр ингээд орж ирж байгаа юм. Нөгөө Төсвийн тогтворт тогтвортой байдлын зөвлөлийн хууль нь 22 удаа өөрчлөгдчихсөн хамгийн тогтворгүй хууль болоод нэг ийм болчихсон. Алдагдалгүй төсөв батална гэдэг бодлогын зарчмаасаа ухарчихсан энэ удаагийн Засгийн газар 1 ийм л төсөв орж ирж байна. Үндсэн хуульдаа Монгол Улсад засгийн эрх бүх ард түмний мэдэлд байна гэж заасан байдаг ч яг үнэн бодит байдал дээрээ засгийн эрх Засгийн газрын хэдэн сайд нарт л байна. Бүх ард түмэнд ямар ч эрх мэдэл алга. Засгийн газарт байгаа сайд нар Монголын бүх юмны эрх мэдлийг эдэлж байна. Эрүүл мэндийн салбар нь эрүүл бус болчихсон, өвдөх л юм бол үх гэдэг зарчим энэ салбарт үйлчилдэг болсон.

Өмнөх 2 сайд нь хоорондоо хөлөө жийлцээд суудаг болчихсон. Гэтэл хөдөө сумд багийн эмчийн сар тутам өгдөг 30 литр бензинийхээ хангамжийг өгч чадахаа больчихсон. Багийн эмч нар нь багийн иргэдээ үзэж чадахаа больчихсон. Ингээд нэг ийм өвдөх л юм үх гэдэг ийм л зарчим руу шилжчихлээ л дээ. Хэвтэн эмчлүүлэх заавартай өвчтөнүүдийг чинь сумын эмнэлгүүд өдрийн эмчилгээ хийлгээд явуулж байна. Гол нь мөнгө мөнгө байхгүй. ЭМД-ын санд мөнгө байхгүй гэдэг. Тэгээд бид нар чинь мөнгөгүй биш мөнгөтэй улс л даа. Жавхлан гэдэг хүн Сангийн сайд байх үеэс 162 их наяд 800 тэрбум төгрөг ингээд зарцуулчхаж байна шүү дээ. Тэгээд ийм их мөнгөтэй байж өнөөдөр нэг ч салбар нэг ч асуудлыг шийдэж чадаагүй нэг ийм Засгийн газар. Тэгээд манай энэ Засгийн газрын сайд нар чинь бүгдээрээ л өмнөх, хойдох тэрний өмнөх Засгийн газарт байсан хүмүүс шүү дээ. тэгээд хүүхэд ер нь хуульд заасных нь дагуу эрүүл аюулгүй орчинд амьдарч чадаж байна уу гэдэг нэг асуулт. Ахмадууд хуульд заасных нь төлөө 36 сарынх нь тэтгэмжийг нь 2 жилд хуваагаад өгчхөж байгаа юм. Үхсэний хохь, амьдын зол гэж байгаа юм уу. Одоо энэ Жавхлан сайд байхгүй байна л даа. Гэхдээ Жавхлан сайд тэтгэвэрт гарахгүй юу. Нэг их удахгүй тэтгэвэрт гарах нас нь болж байгаа биз дээ. Үгүй ийм хүний эрхийн зөрчилтэй, иргэдээ боддоггүй төсвөө хүн төвтэй төсөв гээд нэрлэххэж байгаа юм энэ чинь. Хүн төвгүй мега төсөв байна шүү.

Төсвийн хүрээний мэдэгдэл чинь уг нь бодлого. Тэгээд төсөв чинь уг нь зардлын л жагсаалт л юм байгаа юм шүү дээ. Тэгээд зардлынх нь жагсаалтыг хараад манайхан ингээд яваад байдаг байж болохгүй. Тэгээд ингээд Засгийн газар нь ингээд Улсын Их Хурал хугацаандаа хуулиа батлахгүй бол болохгүй гээд ингээд хугацааг нь тулгаад нэг ийм хэлчихсэн болгоод нэг ийм хууль хуулийн төсөл оруулаад ирдэг. Тэгээд Их Хурал шүүмжлэхээр нэг косметик хагалгаа хийдэг юм уу багахан багахан засвар хийгээд ингээд хугацаандаа тулахгүй батлахгүй бол Их Хурал чинь өөрөө хууль зөрчин гээд байдаг. Хэрвээ хугацаандаа батлуулж чадахгүй бол Засгийн газар огцордог болмоор байгаа юм эсрэгээрээ. Тэгэхгүй ингээд хугацаанд нь тулгаад маш муу төсөв оруулаад ирдэг л тийм жишиг тогтчихлоо л доо. Сүүлийн 10 жил.

Х.Булгантуяа: Шижир гишүүн үг хэллээ. Үндэсний аудитын газраас 3 номерын микрофон дээр түрүүн Цогтбаатар гишүүний асуултад хариулт өгмөөр байна. 3 номер.

С.Магнайсүрэн: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя.

Төсвийн хүрээний мэдэгдэл дээр манайх ажлын хэсэгт байхгүй байсан учраас хоцорч ирж хариултыг тодруулж хэлж байна аа. Энэ аудитын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хэрэгжилтийг хангах асуудлыг бид нар онцгой анхаарч ажиллаж байгаа. Томилгооны сонсголын үеэр ч тэр, томилгооны үеэр гишүүдийн гаргасан санал шүүмжлэл энэ дээр төвлөрч байсан учраас бид нар онцгойлон анхаарч байгаа. Төсвийн гүйцэтгэл санхүүгийн нэгдсэн тайлангийн үеэр бол нэлээн том дүнтэй ийм зөрчлүүд гарч ирсэн байж байгаа. Тэгээд энэ дээр бид нар жишээлбэл 252 албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар ийм сахилгын болоод хариуцлага тооцуулах ийм албан шийдвэрүүд гаргаж, холбогдох газруудад хүргүүлсэн.

Аудитын хуулийн дагуу бол тайлан хүргүүлснээс хойш 30 хоногийн дотор энэ шийдвэрүүдийг хэрхэн биелүүлэх вэ гэдэг төлөвлөгөөгөө ирүүлдэг. Энэ төлөвлөгөө нь Үндэсний аудитын газар нэгтгэгдээд тэгээд бид нар завсрын аудит болон бусад аудитынхаа явцад биелэлтийг нь шалгаад хэрвээ биелүүлэхгүй бол аудитын хуульд заасны дагуу дараагийн шатын арга хэмжээнд шилждэг ийм хуультай.

Тэгээд өнөөдрийн байдлаар завсрын аудит 9 сард эхэлсэн 12 сарын 1 гэхэд дуусна. Энэ үеэр бол бүх энэ бид нарын гаргасан акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлт бол нэгтгэгдэж дүн харагдах учраас өнөөдрийн байдлаар тэр ийм энэ ийм гэж хэлэх хугацаа арай болоогүй байгаа. Дархан төмөрлөг дээр ярьсан тусгайлан ярьсан тэр асуудлаар болохоор зэрэг акт албан шаардлагын биелэлт бол 12 сарын 15-ны дотор бүрэн биелэгдэхээр төлөвлөгөө нь манайд авагдсан байж байгаа. Зөвлөмжийн биелэлт бол 11 сарын 25-нд авагдахаар байгаа учраас энэ хугацаанд нь бид нар бол нэгтгээд Их Хурлын гишүүнд бүрэн танилцуулчих бололцоотой.

Цаашдаа бид нар энэ албан шийдвэрүүдийнхээ биелэлтүүдийг Төсвийн байнгын хороо болон Зарлагын хяналтын дэд хороон дээр сар болгон өгөөд мэдээлэл өгөөд явж байх бүрэн бололцоотой.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Зарчмын зөрүүтэй нэг саналын томъёоллоор санал хураахаар байгаа. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу санал хураалтыг түр хойшлуулаад дараагийн асуудал руугаа оръё.

12.28 цаг

Улсын Их Хурлын өнөөдрийн хэлэлцэх асуудал.

Гуравдугаар асуудал руу оръё. **Төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах Үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.**

Мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн тайланг Монголбанкны Ерөнхийлөгч Бядрангийн Лхагвасүрэн танилцуулна аа. Лхагвасүрэн Ерөнхийлөгчийг индэрт урьж байна.

Б.Лхагвасүрэн: Эрхэм хүндэт Монгол Улсын Их Хурлын дэд дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Та бүхний энэ өдрийн амар амгаланг эрж мэндчилье. Монголбанк Төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах Үндсэн чиглэлийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн барилаа. Эдийн засгийн сэргэлт өсөлтийг дунд хугацаанд тогтвортой үргэлжлүүлэх нь энэ жилийн мөнгөний бодлогыг боловсруулахад чухал зарчим зорилт байсан. Энэ удаад ч гэсэн бодлого үйл ажиллагааг төлөвлөхөд энэхүү зорилт улам бүүр ач холбогдолтой болж байна аа.

Дэлхий нийтэд цахим шилжилт олон улсын худалдаа харилцаанд гарч буй өөрчлөлт түүний нөлөөгөөр олон улсын мөнгө санхүүгийн тогтолцоо хурдтай хувьсан өөрчлөгдөж байгаа нөхцөлд ийм нөхцөл байдалтай уялдуулан эдийн засгийн тогтвортой байдлыг дунд хугацаанд хадгалах бэхжүүлэхэд чиглэсэн. Мөнгөний бодлогын үндсэн чиглэлийг боловсруулсан болно оо. Монгол Улсын эдийн засаг харьцангуй тогтворжиж, тогтворжиж энэ оны эхний хагаст 5.6 хувиар өслөө. Үүнд өнгөрсөн жил өнгөрсөн өвөл тохиосон зудын нөлөө арилж ХАА-н салбар оны эхний хагаст 35.6 хувиар өссөн нь нийт өсөлтийн талаас илүү хувийг бүрдүүлээ.

Төмөр зам орон сууцын барилгын ажил идэвхжиж барилгын салбар 25.2 хувиар, үйлчилгээний салбар 4.5 хувиар өссөн нь эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө мөн үзүүлээ. Монголбанкны төсөөллөөр энэ оны сүүлийн хагаст зэсийн олборлолт нэмэгдэх шинэ төслүүдийн бүтээн байгуулалт эрчимжих зэрэг нь эдийн засгийн өсөлтийг дэмжих хүлээлттэй байна аа. Улмаар эдийн засгийн өсөлт 2025-аас 2026 онд 5-аас 6 хувьд тогтвортой өсөх хүлээлттэй гэсэн ийм төсөөллийг мөн бид гаргалаа. Инфляцыг бууруулж эдийн засгийг тогтворжуулах зорилгоор авч хэрэгжүүлсэн мөнгөний бодлогын арга хэмжээ үр дүнгээ өгч инфляц энэ оны 2-оос 7 сарын хооронд буурсан ч 8 дугаар сард дотоодын үнийн нөлөөгөөр бага хэмжээгээр нэмэгдлээ.

Ирэх саруудад хүнсний үнийн нөлөөгөөр инфляц эрчимжиж болзошгүй байгаа ч цаашид алгуур буурч 2026 онд зорилтот интервалд орох хүлээлттэй байна аа. Түүнчлэн төлөвлөсөн бүтээн байгуулалтуудыг гадаад эх үүсвэрээр санхүүжүүлэх шаардлага хэвээр байна. Дотоод эх үүсвэрээр санхүүжүүлэх нь эдийн

засгийн гадаад, дотоод тэнцвэр алдагдах, төлбөрийн тэнцэл, төгрөгийн ханш, инфляцад дарамт нэмэгдэх эрсдэлтэйг мөн дурдах нь зүйтэй байх аа. Иймд инфляцын зорилтыг хангахад мөчлөг сөрсөн төсвийн бодлого хэрэгжүүлж, хүнсний бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн доголдлыг технологийн шийдлүүдийг ашиглан шуурхай шийдвэрлэхэд ахиц дэвшил гаргахад анхаарч ажиллах нь чухал байна аа. Мөн гол нэрийн барааны нийлүүлэлтийг тогтворжуулах нь үнийн савлагааг бууруулж, иргэд, үйлдвэрлэгч, хөрөнгө оруулагчдын бодит орлогыг хамгаалсан нам тогтвортой түвшний инфляцын орчныг бүрдүүлэхэд суурь болохыг онцлох нь зүйтэй байх аа.

Дэлхий дахинд худалдааны бодлого улс орнуудын харилцаа хурдацтай өөрчлөгдөж байна аа. Энэ нь глобал эдийн засгийн төлөв манай улсын гадаад эрэлт түүхий эдийн үнэд сөргөөр нөлөөллөө. Үүний илрэл нь нүүрсний экспортын орлого эх оны эхний 8 сард өмнөх жилийн мөн үеэс 2.7 тэрбум доллароор багассанаас харагдана аа. Гадаад худалдааны эрэл эргэлт саарч, урсгал тэнцэл, дансны алдагдал тэлж буй энэ үед Засгийн газар банкнууд болон хувийн секторын гадаад зээл бондын эх үүсвэр нь гадаад валютын дотогшлох урсгалыг тэтгэж байгаа билээ. Төлбөрийн тэнцлийн цаашдын төлөв нь эрдэс бүтээгдэхүүний үнэ улс орнуудын тарифын бодлого худалдааны түнш орнуудын эдийн засгийн байдлаас ихээхэн хамаарна. Манай улсын худалдааны гол түнш БНХАУ-ын эдийн засгийн өсөлт цаашид саарах хүлээлттэй байна. Иймээс нүүрс төмрийн хүдэр зэрэг эрдэс бүтээгдэхүүний үнийн төлөв өөдрөг биш гарахаар байна аа.

Экспортын орлого буурч буй энэ үед макро бодлогын оновчтой хослолыг хэрэгжүүлж урсгал тэнцлийн алдагдлыг бууруулах нь нэн чухал гэдгийг энд онцлон дурдъя аа. Түүнчлэн аливаа томоохон бүтээн байгуулалтын төслүүдийг гадаад валютын нөөцөд нэмэлт ачаалал үүсгэхгүйгээр хэрэгжүүлэх нь чухал байна.

Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах үндсэн чиглэл нь нам тогтвортой инфляцын орчныг бүрдүүлэх банкны системийн эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх, зээлийн нөхцөлийг эрэлт, нийлүүлэлт талаас нь судалж бизнесийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай арга хэмжээг тодорхойлох, бүтээгдэхүүний нэр төрөл, хүрээг өргөжүүлэх, шаардлагатай бодлого, зохицуулалтын арга хэмжээг тодорхойлох зэрэгт онцгойлон анхаарч боловсруулагдсан.

Сүүлийн жилүүдэд нэмэгдээд буй геополитикийн хүндрэлүүдээс үүдэн гадаад эрэлт зарах экспортын гол түүхий эдийн үнэ хүлээлтээс хурдтай буурах зэрэг нь манай улсын экспортын орлого валютын дотогшлох урсгалд сөргөөр нөлөөлж болзошгүй ээ. Түүнчлэн нефтийн нийлүүлэлт саатах цаг агаарын нөхцөл муудан, өвөлжилт хүндрэх, өвлийн улиралд эрчим хүчний нийлүүлэлтийн тасалдалт бий болох зэрэг нь инфляцыг нэмэгдүүлж эдийн засгийн идэвхжилийг сааруулах эрсдэлтэй. Ийнхүү гадаад дотоод эрсдэл тодорхой бус байдал өндөр байгаа ч Монголбанк ирэх жил инфляцыг 6+ -2 нэгжийн интервалд тогтворжуулж, 2027 оноос зорилтын голчийг 5 хувь болгож бууруулахаар мөнгөний бодлогын үндсэн чиглэлдээ тусгалаа. Үүнийг амжилттай хэрэгжүүлэхэд Засгийн газрын дэмжлэг төсвийн мөчлөг сөрсөн бодлого голлох үүрэгтэй байх болно оо.

Банкны эрсдэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх хүрээнд өөрийн хөрөнгийн болон хөрвөх чадварын хүрэлцээг банкны эрсдэлийн түвшинтэй уялдуулан тодорхойлох зорилт бүхий базелистун, стандартын бүлэг 2-ын үнэлгээний аргачлалуудыг туршилтын байдлаар нэвтрүүлж холбогдох журмыг боловсруулан ажилласан.

Цаашид банкны өөрийн хөрөнгийн бүтэц бүрэлдэхүүнийг үр ашигтай байдлаар төрөлжүүлэн банкны системийн эрсдэл даах чадварыг нэмэгдүүлж үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хяналт шалгалтын олон улсын стандартад бүрэн нийцүүлэхийг зорьж байна аа.

Мөн банк, санхүүгийн тогтвортой байдал, дэмжлэг үзүүлэх хүрээнд иргэдийн санхүү эдийн засгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. ААН-үүдийн бизнесийн үйл ажиллагаанд хээл хахууль, ядуурал, улс төрийн байдал, ажилгүйдэл зэрэг нийгэм улс төрийн хүчин зүйлс хамгийн ихээр сөрөг нөлөө үзүүлдэг ч санхүүжилтийн орчны хүчин зүйлс мөн багагүй сөрөг нөлөө үзүүлж байна аа.

Судалгаагаар бизнесийн байгууллагуудад барьцаа хөрөнгийн үнэлгээ доогуур байгаа нь санхүүжилт авахад тулгамдаж буй гол асуудал гэж гарсан. Иймд бизнесийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд банкны зээл олголтын нөхцөл шаардлагыг судалж зээлдэгчийн хэрэгцээ салбарын онцлогт нийцсэн зээлийн бүтээгдэхүүний нэр төрөл хүрээг өргөжүүлэхэд чиглэн ажиллахаар мөн төлөвлөлөө.

Технологийн шинэчлэл цахим шилжилтийн энэ үед санхүүгийн бүтээгдэхүүний үйлчилгээ, төлбөр тооцооны дэвшилтэт арга хэрэгслүүд хурдтай нэвтэрч төв банкны үйл ажиллагаа ч дижитал шилжилтэд хөл нийлүүлэх шаардлагатай болж байна аа.

Иймээс үндэсний төлбөрийн системийн зохицуулалтыг боловсронгуй болгох, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжин ажиллахаар зорьж мөн үндсэн чиглэлээ боловсрууллаа. Түүнчлэн санхүүгийн системийн болзошгүй эрсдэлийг үнэлж удирдахад чиглэсэн макро зохистой бодлогыг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлэх төгрөгийн ханшийн уян хатан тогтох зарчим олон нийттэй харьцах үйл ажиллагаа болон банкны салбарын эрх зүйн шинэтгэлийг үргэлжлүүлэх мөнгө угаах терроризмыг санхүүжилтэд тэмцэх үндэсний бодлогыг шинэчлэхээр тусгалаа.

Монголбанкны бодлого үйл ажиллагаа нь дотоодын эдийн засагт ирэх аливаа сөрөг шокийн нөлөөг бууруулах үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд анхаарч инфляцыг дунд хугацаанд зорилтот түвшинд хүргэж тогтворжуулах замаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгоход дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах үндсэн чиглэлийг баталж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.

Х.Булгантуяа: Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Бадамдоржийн Пунсалмаа танилцуулна. Пунсалмаа гишүүнийг индэрт урьж байна.

Б.Пунсалмаа: Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монголбанкнаас Төв банкны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу 2025 оны 9 сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд ирүүлсэн Төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийг Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөлд эдийн засгийн өсөлтийн тогтвортой байдлыг дэмжих иргэдийн бодит орлогыг хамгаалах хүрээнд инфляцыг дунд хугацаанд 3-аас 7 хувь орчимд тогтворжуулах, инфляцыг одоогийн голч болох 6 хувийг 2027 оноос 5 хувь болгон бууруулах. Цахим шилжилтийн хүрээнд үндэсний төлбөрийн системийн эрх зүйн орчныг сайжруулах замаар төлбөрийн системийн зохицуулалтыг боловсронгуй болгох, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжих олон улсын зарчмын дагуу төлбөрийн систем дэх хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх, банкны салбарын эрх зүйн шинэчлэлийг үргэлжлүүлж, хөгжлийн түгээмэл хандлага, олон улсын сайн туршлагад тулгуурлан хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх үнэлгээний үр дүнд тулгуурлан шаардлагатай хууль тогтоомжийн төсөл боловсруулах, чанаргүй зээлийг бууруулах, актив, удирдлагын мэргэшсэн институцийн эрх зүйн орчныг бүрдүүлэх зэрэг асуудлыг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийг Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үеэр Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр инфляц хэдэн хувьд хүрэх талаар тэтгэврийн зээлийн талаар Монголбанкнаас гаргасан шийдвэр, цаашид хэрэгжүүлэх бодлого шийдвэрийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа Засгийн газрын хүүгийн хөнгөлөлтийн зээлийн талаар, Төв банкны үнэт цаасны хэлбэрээр төвлөрсөн мөнгөн дүн болон үүнээс арилжааны банкнуудад жилд олгох хүүгийн талаар, төрөөс төрийн өмчит ААН-үүдийг задлах эдийн засаг дахь оролцоонд хяналт тавих талаар, Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар Зээлийн мэдээллийн тухай хуульд оруулсан өөрчлөлт хэрэгжилттэй холбоотой иргэдээс гаргаж байгаа санал гомдлын талаар, онооны системийн талаар олон улсын жишигт нийцүүлэх талаар асуулт асууж санал хэлсэн болно оо.

Монгол банкнаас ирүүлсэн санал болон Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.1 дэх хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос боловсруулсан Төрөөс мөнгөний бодлогын талаарх 2026 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг та бүхэнд хүргүүллээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрөөс мөнгөний бодлогын талаарх 2026 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт болон Улсын Их Хурлын шийдвэрийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж.

Х.Булгантуяа: Улсын Их Хурал дахь АН-ын бүлгийн санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Лодойсамбуу уншиж танилцуулна аа.

Ч.Лодойсамбуу: Монгол Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монголбанк 2026 онд мөнгөний бодлогын хамгийн гол зорилго болох төгрөгийн тогтвортой байдлыг хангахын тулд инфляцыг 5+-2 хувьд онилох, валютын ханшийг уян хатан суурь нөхцөлд нийцсэн түвшинд хадгалах гэсэн зорилтуудыг дэвшүүлжээ. Энэ нь онолын хувьд зөв боловч жил бүр давтагддаг хамгийн гол нь бодит эдийн засгийн нөхцөл төсвийн тэлэлтийн орчинд хэрэгжих магадлал багатай зорилтууд болжээ.

Өнгөрсөн хугацаанд Монголбанк дунд хугацаанд инфляцыг 5-аас 6 хувьд тогтворжуулах зорилт тавьсан боловч 2025 онд хагас жилийн байдлаар 9 орчим хувьтай хэвээр байна. 2024-өөс 2025 онд төрөөс хэрэгжүүлсэн өргөн цар хүрээтэй зарлагын өсөлт болон дотоод хэрэглээний зээлийн огцом өсөлт эрэлтийн шалтгаантай инфляцыг өдөөж төгрөгийн ханшийг сулруулсан. Сонгууль угтан эрх баригчдын хэрэгжүүлсэн элдэв хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрүүд, түүнийг идэхгүйгээр аялдан дагасан төв банкны үйл ажиллагаа, мөнгөний бодлогын хоцорсон хариу үйлдэл зэрэг нь үнийн өсөлтийг өдөөж, ард иргэд, бизнес эрхлэгчдийн нуруун дээр далд татвар болон бууж байна аа.

Төгрөгийн ханш гадаад худалдааны голлох валютын эсрэг энэ оны эхний хагас жилд 5-аас 6 хувиар буурч экспортын орлогын бууралт болон импортын эрэлттэй нийлж, төлбөрийн тэнцлийг алдагдлыг нэмэгдүүлж байна аа. Төв банк уян хатан ханшийн бодлогоо олон жил маань мэгзэм мэт давтаж байгаа ч зах зээлийн хүлээлтийг удирдаж валютын нөөцөө бэхжүүлж чадахгүй байсаар байгааг бид харсан.

Мөн Монголбанк валютын зах зээлд ихээхэн хэмжээний интервенц хийсээр байгаа боловч энэ үйл ажиллагааны ил тод байдал, үр дүн хангалтгүй байна аа. Банкны санхүүгийн салбарын нийт зээлийн багцад хэрэглээний болон тэтгэврийн зээл хэт өндөр байгаа нь өрхийн орлогын дарамтыг нэмэгдүүлж байна аа.

Нэг талаас үнийн өсөлтөөс үүдэлтэй өдөр тутмын амьжиргаагаа залгуулах хэрэгцээ шаардлага нөгөө талаас инфляцын нөлөөгөөр мөнгө хүүлэлтийн түвшинд тогтсон өндөр хүүтэй зээл 2-т шахагдсан ард түмний чөтгөрийн тойрог дотор эргэлдсээр удлаа. Энэ бол олон жилийн турш бахь байдгаараа явсаар ирсэн харилцан уялдаагүй, эсрэгээрээ харилцан нөхөлцсөн хариуцлагагүй төсөв мөнгөний бодлогын үр дүн юм аа. Төв банк мөнгөний бодлогын танилцуулгадаа олон нийттэй харилцах харилцаагаа сайжруулна гэж тусгасан боловч энэ нь зах зээл дэх иргэд итгэлцлийг сэргээх хүлээлтийг удирдахад хангалтгүй байна.

Бодлогын шийдвэрийн протокол, санал хураалтын дүн, инфляцын төсөөллийн нарийвчлал зэрэг тодорхой мэдээллийг нийтэд ил тод болгодог олон улсын сайн жишгийг нэвтрүүлэх шаардлагатай байсаар байна аа. Нэгтгэн дүгнэхэд

АН-ын бүлэг төрөөс мөнгөний талаар баримтлах үндсэн чиглэлийг бодит үр дүнд чиглэсэн болгож сайжруулах нь зүйтэй гэж үзэж байна аа.

Дараах 3 чиглэлээр юун түрүүнд шинэчлэл шинэчлэл хийх шаардлагатай. Үүнд инфляц бууруулах бодит арга замыг тодорхойлох.

Монголбанк 5-аас 6 хувийн инфляцын зорилт дэвшүүлсэн ч түүнд хүрэх хугацаа, бодлогын хэрэгслийн сонголт, дараалал тодорхойгүй байна аа. Инфляцыг бууруулах арга хэмжээг эрэлтийг удирдах болон нийлүүлэлтийг дэмжих 2 чиглэлд ялгаж хэрэгжүүлэх шаардлагатай.

2.Төв банкны хараат бус байдлыг баталгаажуулах мөнгөний бодлого улс төрийн нөлөөнөөс ангид судалгаа тооцоонд суурилсан байх ёстой. Монголбанк төсвийн гадуур төсвийн шинжтэй хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх эсвэл сонгуульд чиглэсэн халамжийн хөтөлбөрүүдийг системээрээ мөнгөжүүлж өгөх үүрэг гүйцэтгэх бус инфляц болон ханшийн тогтвортой байдлыг хамгаалж түүндээ хариуцлага хүлээдэг институт байх ёстой.

3.Өрхийн санхүүгийн эрсдэлийг бууруулах, хэрэглээний болон тэтгэврийн зээлийн хэт тэлэлтийг хязгаарлаж, зээлдэгчийн үлдэх орлого, амьжиргаа нь амьжиргааны доод түвшнээс доошгүй байх зохицуулалтыг бодит болгох шаардлагатай байна аа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Х.Булгантуяа: Ажлын хэсгийн гишүүдийг та бүгдэд танилцуулъя.

Бядрангийн Лхагвасүрэн Монголбанкны Ерөнхийлөгч, Баярсайханы Баярдаваа Мөнгөний бодлогын газрын захирал, Дунхүүгийн Аюуш Хууль, эрх зүйн газрын захирал, Дамдинжавын Даваасүх Судалгаа статистикийн газрын захирал, Атарбаатарын Энхжин Санхүүгийн зах зээлийн газрын захирал, Энхболдын Анар төлбөр тооцооны газрын захирал гэсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэй байна.

Мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн тайлан, шийдвэрийн төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү? Асуулт, үг тусдаа.

Улсын Их Хурлын 8 гишүүн үг хэлэхээр нэрээ өгсөн байна. 8 гишүүн асуулт асуухаар. Улсын Их Хурлын гишүүн Цагаанхүүгийн Идэрбат.

Ц.Идэрбат: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе ээ.

Ер нь төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл жил болгон батлагддаг. Тэгээд энэ дээр инфляцын түвшнийг бас тодорхой хэмжээнд зургаа дээр нэмж хасах нь 2 хувь гээд ингээд л ер нь сүүлийн жилүүдэд ер нь олдвол ингэж яваа тэгээд яг бодит амьдрал дээр бас яг энэ хүрээндээ бид хадгалж чадаж байна уу, үгүй юу гэдэг дээр нэлээн эргэлзээтэй хандах бодит нөхцөл байдал үүссэн байна. Иргэд дээр очоод бид нар 6 хувийн инфляцтай байна. Ингээд 7 хүрээд байна гээд ингээд хэлэхэд бол өөдөөс худлаа яриад бай л гээд байгаа шүү дээ. Тэгээд энэ нь ч яг амьдрал дээр ийм байгаа юм.

Тэгэхээр ер нь Монголбанкны энэ мөнгөний бодлого дээр энэ инфляцын түвшнийг барих энэ зорилгоо ер нь сүүлийн хэдэн жилүүдэд яаж биелүүлэв гэж та бүхэн харж байна. Яг дайнтай, ковидтой үед би тодорхой хэмжээнд барьж чадаж байна гэдгийг хэлж байсан. Өнөөдөр бол яг үндсэн энэ үүргээ хэр биелүүлж байгаа гэж та бүхэн үзэж байгаа. Ямар хүчин зүйлүүд нөлөөлж байгаа вэ гэдгийг.

Дараагийн нэг асуулт бол Монголбанктай холбоотой нэг томоохон хууль гарсан нь энэ манай Батшугар гишүүний өргөн барьж батлуулсан тэр нөгөө Зээлийн мэдээллийн сангийн хууль л даа. Тэгээд энэ хуулийн хэрэгжилт уул нь 9 сарын 1-ээс билүү хэрэгжээд эхэлсэн гэж байгаа юм. Бас тэгээд л нэг тийм тодорхой үр дүнд хүрээгүй эргээд л нэг баахан чирэгдэл учруулсан ийм гомдлууд маш ихээр ирээд байгаа юм.

Тэгэхээр энэ хууль ер нь хэрэгжих яг ямар саад тотгор учраад байгаа юм бэ? Тэгээд энэ бол нэлээн тийм бодитой хууль гэж би хардаг. Бодитой хууль, хэрэгжих боломжтой хууль гэж хардаг. Тэгээд уул нь ингээд хэрэгжих боломжтой хуулийг Их Хурал батлаад өгдөг, хэрэгжүүлэх процесс нь ингээд яваад байх юм бол бас л нэг хэрэгждэггүй нэг хуулийн л нэг жишээ болчих вий гэж би бас энэ дээр санаа зовоод байгаа юм, санаа зовоод байгаа юм.

Дараагийн нэг асуулт бол энэ тэтгэврийн зээлийн хүүтэй холбоотой асуудлууд. Тэгээд Монголбанк энэ дээр яах вэ зээлийн олголтыг арилжааны банкнуудад хариуцуулчихсан. Та хэд уснаас гялс бултсан л даа. Гэхдээ арилжааны банкнууд энэ чинь янз янзын үзэмжээрээ ингэж хандаад байгаа юм байна лээ. Зарим нь ч 6 сар, зарим нь ч 18 сар гээд ингээд явж байгаа юм байна лээ.

Тэгэхээр энэ дээр ер нь бодлого энэ чинь өөрөө инфляцад нөлөөлдөг гэж гэж та бүхэн үздэг. Тэгэхээр энийгээ ер нь нөгөө тэтгэвэр авагч нарт бүүр нэг тодорхой болгоод хэн хэндээ ойлгомжтой байдал руугаа явуулах талын юм байж болдог юм уу үгүй юм уу? Нөгөө талдаа хэдийгээр энэ тэтгэврийн зээл бол хамгийн өндөр бизнесийн хүүтэй адилхан жилийн 20 хувь болчихоод байгаа юм байна лээ шүү дээ. Гэтэл зээлийн хүү тооцох тэр аргачлал дотор нэлээдгүй хувь нь зээлийн эрсдэлийг тооцсон хүү байдаг аа.

Гэтэл энэ тэтгэврийн зээл нь өөрөө эрсдэлгүй учраас энэ зээлийн хүү бодож байгаа тэр аргачлал дотроос ядаж тэр эрсдэлийг тооцсон хүүг нь буулгачих бололцоо байдаг гэдгийг банкныхан өөрсдөө ч та нар ярьдаг шүү дээ. Өнгөрсөн 6 сард яг энийг асуухад ер нь бол маш боломжтой зүйл шүү, зөв юм ярьж байна шүү л гэсэн. Тэгээд энэ дээр яг тийм тодорхой авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ юу байна вэ гэсэн ийм 3 зүйлийг би асууя гэж ингэж бодож байна.

Х.Булгантуяа: Монголбанкны ерөнхийлөгч 4 номерын микрофон дээрээс хариулъя.

Б.Лхагвасүрэн: Идэрбат гишүүний асуултад хариулъя. Тийм инфляц бол Монголбанкны ингээд үндсэн зорилго байгаа. Тэгээд инфляцыг энэ 8 хувь 6 + -2 гээд энэ хүрээнд тогтворжуулна гэдэг бол эдийн засгийн нөхцөл байдлыг ийм тогтвортой байдалд оруулна гэсэн л ийм зорилго байгаа юм. Тэгэхээр ер нь сүүлийн зүгээр би танд 2 жил хагасын тоог 2023 оны хагасаас эхлээд инфляц нэг оронтой тоо руу шилжсэн байгаа. Тэгээд хамгийн сүүлийн энэ 8 сарын инфляцын тоо бол 8.8. Тэгээд энэ хооронд бол хамгийн багадаа 4.6, хамгийн дээд талдаа бол 9.6 гэсэн

ийм хүрээнд ингээд инфляц явсан. Тэгээд дунджаар нь авч үзэх юм бол 7.4 хувь гэж гарч ирж байгаа юм.

Тэгэхээр ер нь Монголбанк сүүлийн 2 жил энэ зорилтот түвшнийхээ хүрээнд инфляц хадгалагдсан. Ямар ч байсан Монголбанкны мөнгөний хатуу бодлого үр дүнгээ өгч байна гэж байгаа. 2027 оноос бид инфляцыг 5 дунджийг нь 6-аа 5 болгоод ерөнхийдөө энэ маань өөрөө 3-аас 7 хувийн ийм хүрээнд оруулж ирнэ гэсэн зорилго тавьж байгаа.

Энэ нь өөрөө бас яг мөнгөний хатуу бодлогын үр дүнгээр энэ гарч ирэхээр байгаа юм. Тэгэхлээр өнөөдөр ингээд бодлогын хүү 12 хувьтай ингэж явж байгаа нь инфляц 8 хувьтай байхад 4 хувийн бодит хүүтэй явж байгаа нь өөрөө энэ хатуу бодлого өөрөө үр дүнгээ аль болохоор богино хугацаанд авчруулах л ийм зорилгоор л ингэж хэрэгжээд явж байгаа бодлого байгаа.

Тэгэхээр ер нь бол Монголбанкны энэ бодлого бол ямар ч байсан яг үр дүнгээ өгөөд инфляцыг тогтворжуулахад үр дүнгээ өгч байгаа гэж бидний зүгээс харж байгаа.

2 дахь асуултын хувьд бол Зээлийн мэдээллийн сангийн тухай хууль бол 2011 онд анх батлагдсан хууль. Энэ хуулиар бол зээлийн мэдээллийн сан нь өөрөө Монголбанканд дээр байна. Тэгээд зээлийн мэдээллийн сантай холбогдуулан ийм иргэдэд оноо өгдөг энэ хувийн зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж оноо өгч явна гэдэг энэ хуулийн заалт бол 11 оноос хойш ингээд хуулиар зохицуулагдаж байгаа хэдий ч одоо энэ оноо өгдөг компани нь өөрөө ерөөсөө 2, 3 жилийн өмнө зөвшөөрлөө аваад тэгээд онооны системд шилжсэн.

Тэгээд эхний онооны оноо гаргасан компанид тэр файко гэдэг Америкийн аргачлалаар ингээд оноогоо өгөөд явж байгаа юм. Тэгээд 2011 онд гарсан хууль дээр сая Батшугар гишүүн энэ хуулийн 4 заалтыг өөрчилж гэдгээрээ өргөн бариад хуулийн заалт өөрчлөгдсөн. Тэрэн дээр бол гол хуульд орсон өөрчлөлт дээр бол тэр Монголбанканд дээр байдаг зээлийн ангилалтай гээд олон нийт бол хар жагсаалт гэсэн маягаар энийг нэрлээд явдаг байсан. Энэ жагсаалт гарч ирэхээ больж байгаа юм.

Тэгэхээр ямар нэг тэр зээлдэгчийн талаар тэр мэдээлэл нь өөрөө ангилалтай гэсэн мэдээлэл гарахгүй. Банканд дээр бол зээлийн өртэй бол өртэй хаа нэг ААН-ийн төлбөр тооцоонд өртэй бол өртэй гэсэн мэдээллүүд нь гараад явна. Энэ өр нь өөрөө төлөгдөж байсан байна уу, санхүүгийн сахилга бат нь ямар байсан гэдгээс хамаараад тэр оноо өгөгдөөд явж байгаа юм. Тэгээд 9 сарын 1-ээс эхлээд энэ.

Х.Булгантуяа: 4 номерын микрофон гүйцэд хариулъя.

Б.Лхагвасүрэн: 9 сарын 1-ээс эхлээд Батшугар гишүүний оруулсан өөрчлөлтөөр энэ мөрдөгдөж явж байгаа. Тэгэхээр бол өнөөдөр жоохон төвөгтэй байдал үүсэж байгаа нь юу байна вэ гэхлээр 2 компани байгаа. Хоёулаа тус тусдаа өөрийнхөө аргачлалаар оноогоо өгч байгаа. Тэр өгсөн онооны аргачлал дээр нь банк бас нэмэлт судалгаа хийгээд байгаа юм. Дахиад нөгөө зээлийн мэдээлэлтэй холбогдуулаад тэр оноо нь өөрөө зээлийн түүхтэй нь хэр уялдаатай байна гээд. Бидний анх бодож байснаар бол шууд оноо өгөөд л оноо нь өөрөө тэр хүнийг шууд тодорхойлж байна гэж байсан бол банк энэ дээр давхар ажил хийж байгаа учраас

энэ хуулийн хэрэгжилт дээр жоохон төвөгтэй зүйл. Тэгэхээр дөнгөж эхэлж байгаа учраас тодорхой хэмжээний энэ шилжилтийн ийм юм явах болов уу гэж Төв банкны зүгээс харж байгаа. Тэгээд сая Байнгын хорооны хурал дээр Батшугар гишүүн санал тавьсан. Тэр оноо нь яг зөв оноо өгч байна уу, мэдээлэл нь зөв байна уу? Банк нь тэрэн дээр нь яаж харьцах дээр нь Монголбанк нэг шалгалт явуулаач гэсэн. Тэгээд бидний зүгээс удахгүй нэг тийм шалгалт хийнэ гэж бодож байгаа.

Х.Булгантуяа: Тэтгэврийн зээлийг нэмж хариулъя.

Б.Лхагвасүрэн: Тэтгэврийн зээлтэй холбоотойгоор тэр Монголбанкны зохицуулалтаас гаргасны дараа нийт тэтгэврийн зээлийн өрийн үлдэгдэл 1.6 их наяд байсан бол тэрнээс хойш бол одоо ингээд өнөөдрийн байдлаар 2.3 их наяд ингээд болоод бүүр ингээд бараг 700 тэрбум төгрөгөөр ингээд өсчихсөн явж байгаа. Тэгэхээр тэтгэврийн зээл ер нь хэвийн олгогдож байгаа гэж харж байгаа. Манай статистикаас харах юм бо өнөөдөр 290 мянган тэтгэвэр авагч тэтгэврийн зээлд хамрагдсан байна. Нийт тэтгэвэрт хамрагдсан 500 гаруй мянган иргэн байдаг гэж бодох юм бол хүүгийн хувьд яг манай өөрийн хууль, Банкны тухай хуулиар бол Монголбанк зохицуулагч байгууллага, бодлогын газрын хувьд бол хүүн дээр нь үнэд нь нөлөөлж байгаа гэдэг маягаар ийм байх ёстой, тийм байх ёстой гэдэг тийм оролцоо байдаггүй. Тэр утгаараа бол банк болгон өөр өөрийн дотоод бодлогоор бол энэ.

Х.Булгантуяа: Идэрбат гишүүн нэмж тодруулна.

Ц.Идэрбат: Яагаад би энэ нөгөө инфляцын түвшнийг асуугаад байсан гэхээр одоо энэнтэй чинь уялдаад цалин тэтгэвэр, тэтгэмж нэмэгдэх ёстой байхгүй юу. Ялангуяа тэтгэвэр. Өргөн барьсан төсөв дээр бол 6 хувь гэж байгаа. Инфляц бол бүтэн жилийн хугацаанд 8.8 -9.6 максимумдаа байсан байна. Дундажлаад үзэх юм бол 7.4 өө гэж ингэж үзэж байна шүү дээ Монголбанк тийм ээ.

Тийм учраас төсөв дээр тэгээд Сангийн яамныхан ч байхгүй байна. Төсөв дээр тэтгэвэр 6 биш 7.4 хувиар ингээд нэмэгдээд явах. Би нөгөө хуулийн хэрэгжилт л яриад байгаа юм л даа. Тэгэхээр энэ дээр 7.4 хувиар нэмэх нь зүйтэй юм байна гэдэг зүйлийг бид төсвийн дараа дараагийн хэлэлцүүлгүүд дээр хэлээд явах нь ёстой юм байна гэж. Ингэж би ойлгож байна. Баярлалаа.

Х.Булгантуяа: Идэрбат гишүүн үг хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Ренчинбямбын Сэддорж.

Р.Сэддорж: Өдрийн мэнд дэвшүүлье. Банкны салбарт нэвтрүүлж байгаа шинэ цахим үйлчилгээнүүд юу юу байна? Ямар бодлого барьж байна вэ? Шинээр үйлчилгээнд нэвтрүүлж байгаа энэ үйлчилгээнүүд иргэдэд хэр өгөөжтэй байна вэ? Тэгээд тэтгэврийн зээлээр битгий оролдоорой гэж захъя. Шинэ цахим үйлчилгээнүүдээ ирэх оныхоо зүйлүүдийг сайхан танилцуулаад өгөөч ээ.

Х.Булгантуяа: 4 номерын микрофон.

Б.Лхагвасүрэн: Гишүүний асуултад хариулъя.

Ер нь бол энэ цаг үе нь өөрөө тийм дижитал шилжилт гээд нэлээн тийм цахимжиж байгаа ийм цаг үе байгаа. Тэгэхээр банкны бүтээгдэхүүн үйлчилгээ илүү

их цахимжиж байгаа. Сүүлийн үед бол банкнууд хэрэглээний зээл буюу жижиг зээлүүдийг дандаа цахимаар ингээд олгоод явж байгаа. Аппликэйшний зээл гэж шинээр гарч ирж байгаа. Мэдээж Монголбанкны зүгээс аль болохоор энэ төлбөр тооцоог хэвийн найдвартай явуулах, харилцан санхүүгийн харилцагчийн эрх ашгийг хамгаалах тал руу нь бодлогын өөрчлөлтүүдийг хийж байгаа. Хамгийн сүүлд гарсан бүтээгдэхүүн бол гар утсаар төлбөр тооцоо хийж байгаа. Гар утсан дээр ялангуяа apple pay гэж компанийн программ хангамжийг энэ төлбөр тооцооны системийг оруулж ирснээр apple гар утастай улсууд шууд утаснаасаа төлбөр тооцоогоо хийж болж байгаа. Мөн apple биш андройд үйлдлийн гар утаснууд дээр дараагийнх нь шатын арга хэмжээг хийхээр ажиллаж байгаа.

Тэгэхээр хэрвээ энэ арга хэмжээг Монголд нэвтрүүлчих юм бол аль ч төрлийн гар утсаар төлбөр тооцоо хийх боломжтой болж байгаа. Энэ 2026 оноос эхлээд ерөнхийдөө боловсруулах салбарын аж үйлдвэрүүдийг Монгол Улсад өртөг шингэх талаас нь нэлээн арга хэмжээ хийе гэж энэ төлөвлөж байгаа. Тэр утгаараа ялангуяа энэ ХАА-н гаралтай түүхий эдийг боловсруулах энэ үйлдвэрүүд дээр илүү хүчин чадалд суурилуулах эргэлтийн хөрөнгийнх нь зээлтэй холбоотой байхаар тэр сүлжээн дунд нь малчнаасаа үйлдвэрийн эцсийн бүтээгдэхүүн болтолх ямар шат дамжлагууд дээр, ямар процесс боловсруулалт хийгдэж байгаа тэр тус бүр дээр нь санхүүжилтийн схемийг гаргахаар ингээд ажиллаж байгаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүд ээ чуулганы үдээс өмнөх хуралдаан түр завсарлаад 14 цагаас үдээс хойш хуралдана. Улсын Их Хурлын ахиад 6 гишүүн асуулт асуухаар мөнгөний бодлогын талаар нэрсээ өгсөн байна. Тэгээд асуулт хариултаар үргэлжилнэ. Түүний дараагаар мөнгөний бодлогын талаар гишүүд үг хэлэхээр байгаа.

ЗАВСАРЛАГА

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын чуулганы хуралдааны үдээс хойших хуралдаан эхэллээ. Мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн тайлан шийдвэрийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж байгаа. 6 гишүүн үлдсэн байна. Тамгын газраас ажлын хэсгийг оруулаарай. Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа.

А.Ариунзаяа: Төрөөс мөнгөний талаар баримтлах бодлого Улсын Их Хурлын чуулганаар ер нь энэ мөнгөний бодлогоо хэлэлцдэг баталдаг хэдэн улс орон байдаг юм болоо? Бараг манай улс цорын ганц л болов уу даа. Тэгээд үүнийг Монголбанк өөрөө бас юу гэж боддог вэ? Энийг одоо зорилт байх нь зөв. Гэхдээ үүнийг одоо яг ингэж баталдаг өөрсдөө энэ инфляцыг өдөөдөг жоохон буруу л дэлхийд байхгүй л нэг ийм жишиг яваад байна даа гэж хардаг. Тэгэхээр энэн дээр ер нь цаашид энийгээ больж болохгүй юу? Үндсэн бусад бүх дэлхийн энэ мөнгөний бодлого хэрхэн яаж явдаг энэ зарчимдаа нийцүүлж болохгүй юу? Энэ ер нь жоохон эерэг гэхээсээ илүү сөрөг тэгээд ч ер нь батлагдсан энэ чиглэлийнхээ дагуу инфляцын түвшнээ бол яг барьж чаддаггүй. Тэгээд манай Улсын Их Хурлын гишүүд Улсын Их Хурал өөрөө Улсын Их Хурлын харьяа байгууллагууд дотроосоо Монголбанк тэгээд СЗХ-г 2 өөр нүдээр хараад байдгийг би хувьдаа буруу гэж боддог юм.

СЗХ-ны асуудал яг Монголбанктайгаа ижил эн тэнцүү машид чухал. Яг иргэдийн амьдралд нь хамгийн их нөлөөлдөг асуудал Монголбанкны асуудал гэхээсээ илүүтэй банкны асуудал гэхээсээ илүүтэй энэ банк бус ломбард,

Хадгаламж зээлийн хоршоо 1 өдрийн энэ жижиг зээлүүд байдаг учраас уг нь бол СЗХ-ны ажлыг бид нар маш өндөрт авч хэлэлцэж хуулийг нь сайн харж банкны салбараасаа илүүтэй даатгалын зах зээл, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх тал дээр ярьж анхаарч явахгүй л бол бид нар ердөөсөө энэ чөтгөрийн тойргоосоо гарч чадахгүй байгаад байна аа.

Тэгэхээр энэн дээр яг Монголбанкны бодлогыг дэлхийн бусад улс орнуудад хэрхэн яаж авч хэлэлцдэг юм? Ер нь энийг болих тал дээр нь санаачилга гаргах хэрэгтэй байна гэдгийг асууя.

Хоёр дахь нь болохлоор энэ валютын нөөцтэй холбоотой бас л нэг тийм үл ойлголцол гэдэг юм уу ердөөсөө нэг тийм буруу мэдээлэл яваад байх шиг санагдаад байна. Яг улсын нөөц гэж юу юм, төрийн нөөц гэж тусдаа юу юм. Ер нь энэ валютын нөөц юу юунаас бүрддэг юм. Яг одоо нөхцөл байдал ямар байгаа юм бэ гэдэг талаар мэдээлэл өгөөч? Монголбанкны өөрийн өрийн асуудал бас нэлээд санаа зовохуйц хэмжээнд байгаад байна. Тэгэхээр үүн дээр бас анхаарах хэрэгцээ шаардлага байна аа.

Цаашлаад энэ төрийн хэмнэлтийн бодлогын дотор Монголбанк өөрөө дотооддоо үүссэн байгаа нөхцөл байдал дээрээ үнэлгээ дүгнэлт өгч байгаа юу, хүний нөөцийн бодлого, газар, хэлтсийн тоо зэрэг асуудлууд олон нийтийн анхааралд орж байгаа учраас үүн дээрээ танайхаас ямар бодлого баримталж байгаа вэ гэсэн ийм цөөхөн асуултыг асууя аа.

Х.Булгантуяа: 4 номерын микрофоноос Монголбанкны Ерөнхийлөгч.

Б.Лхагвасүрэн: Ариунзаяа гишүүний асуултад хариулъя.

Ер нь бол энэ төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэлийг гэж Их Хурал парламент дээрээ батлуулдаг улс орон бол бараг байхгүй. Яагаад гэвэл нөгөө Төв банк өөрөө бие даасан хараат бусаар бодлогоо явуулна гэдэг тэр зарчмынхаа дагуу бол Төв банк яг өөрийнхөө бодлогыг өөрөө тодорхойлоод өөрөө хариуцаад ингээд явдаг. Манайд болохоор Үндсэн хууль дотор Улсын Их Хурлын бүрэн эрх гэдэг дотор бол мөнгөний бодлогыг жилдээ нэг удаа хэлэлцэж батална гэсэн ийм Үндсэн хуулийн заалт байдаг учраас энэ заалтын дагуу ингээд Монголбанк мөнгөнийхөө бодлогыг жил болгон өргөн барьж батлуулдаг байгаа. Үндсэн хуульд өөрчлөлт орох ингээд ажлын хэсэг гараад ажиллаж байхад олон улсын туршлага сайн туршлагыг судлаад ер нь бол Монголбанк харин өөрөө Үндсэн хуулийн институц байгаад мөнгөний бодлогыг хэрэгжүүлнэ гээд харин өөрчлөгдөх юм бол зөв голдиролдоо орох юм байна гэж харж байгаа. Тэгээд өнөөдрийн явж ирсэн туршлагаас харах юм бол Монголбанк Их хуралд ингээд төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэлээ батлуулах гэж орж ирж тайлангаа тавьж мэдээллээ өгч явж байгаа. Мөн өөрийнхөө тайланг жилийн эцсийн тайлан гарсны дараа оны 5 сар орчим тайлангаа тавиад мэдээллийг өгөөд явдаг. Мөн бусад хууль тогтоомж ч гэдэг юм уу, Засгийн газрын бас танилцуулгатай холбогдуулаад Монголбанк цуг орж ирээд ингээд тайлан тавиад явж байгаа юм.

Тэгэхээр тайлан тавих талаасаа байнгын Монголбанк Их Хуралдаа мэдээлэл өгөөд явж байгаа учраас зүгээр энэ Үндсэн хуулийн тэр заалт өөрчлөгдвөл бусад олон улсын жишигт нийцтэй болох байх гэж харж байгаа юм.

Дараагийнх нь асуулт нь энэ Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо Монгол Улсын санхүүгийн зах зээл бол ингээд банк ББСБ үнэт цаасны зах, хөрөнгийн бирж, даатгалын байгууллагууд, Хадгаламж зээлийн хоршоо барьцаалан зээлдүүлэх үйлчилгээний байгууллагууд гээд олон ийм санхүүгийн байгууллага гадас бүрддэг. Тэрний банкны хэсгийг нь Монголбанк хянаж шалгаад банкнаас бусад хэсгийг нь Санхүүгийн зохицуулах хороо хянаж шалгаад явж байгаа юм. Тэгэхдээ санхүүгийнхээ Монгол Улсынхаа санхүүгийн системийн тогтвортой байдлаа гэж үзэх юм бол энэ 2 байгууллагын хийж байгаа ажил бараг адилхан.

Тийм учраас хоёулаа ач холбогдолтой. Бас гаргаж байгаа шийдвэрүүд нь хоорондоо уялдаатай байх ёстой гэж тантай энэ дээр яг санал адилхан байгаа. Тэр утгаараа ер нь банкны салбар нь өөрөө энэ зах зээлийнхээ бараг 80-аас 90 хувийг нь ингээд дааж байгаа гэдэг утгаараа өнөөдөр хамгийн том нь болж харагдаад байгаа. Гэтэл бол яг иргэдэд үйлчилж байгаа талаасаа харах юм бол тэр институц Үнэт цаасны компаниуд, даатгалын компаниуд, ББСБ гэдгийг тоогоороо авч үзэх юм бол тоон хэмжээгээр бол СЗХ-ны зохицуулалтад байдаг байгууллагууд илүү олон болж илүү их иргэдэд үйлчилдэг тал нь тэнд байгаа.

Х.Булгантуяа: Ариунзаяа гишүүн нэмж тодруулна.

А.Ариунзаяа: Тодруулгын хугацаа нэг л минут байгаа учраас та хариулахдаа надаа яг валютын нөөц болон Монголбанкны өөрийн дотоод өр болон зохион байгуулалт бүтцийнхээ талаар хариулаад өгөхгүй юу?

Х.Булгантуяа: 4 номерын микрофоноос нэмж хариулъя.

Б.Лхагвасүрэн: Ариунзаяа гишүүнд тодруулж хариулъя. Тэгээд өнөөдрийн яг өнөөдрийн байдлаар Монгол Улсын валютын нөөц 5 тэрбум 870 сая байна. Тэрний Засгийн газрын Ирээдүйн өв сан, Төрийн сан дээр байж байгаа гадаад валютын хадгаламж банкны Монголбанканд дээр харилцах дансандаа байршуулсан мөнгөний нийт дүн нь 2 тэрбум доллар нийлээд. Тэгэхээр энэ нь бол Засгийн газар болон банкны мөнгө. Үлдсэн нь бол Монголбанкны өөрийн цэвэр хадгаламж. Валютын нөөц гэж хэлж болно. Монголбанкны хувьд бол богино хугацаанд урт хугацааны өр гэдэг юм уу тэр нь 1 тэрбум доллараар хэмжигдэж байгаа. Хятадын ардын банкт байгуулсан своп хэлцлийн өр ч гэдэг юм уу. Хэмнэлтийн хувьд бол мэдээж улсын төсвийн байгууллагууд хэмнэлт хийж байгаа учраас Монголбанкны зүгээс ч гэсэн өөрийнхөө бүтэц үйл ажиллагаандаа зохион байгуулалтын арга хэмжээ оновчтой зохион байгуулж байгаа.

Монголбанканд урьд нь орон тоо 670 гэдэг орон тоо байсан бол бүтэц зохион байгуулалтаа өөрчлөөд.

Х.Булгантуяа: 4 номерын микрофон гүйцэд хариулъя.

Б.Лхагвасүрэн: Газруудынхаа тоог хэмнэсэн алба төвүүдийнхээ тоог хооронд нь нэгтгэж зохион байгуулаад нийтдээ нэг 70 орчим орон тоо бол хэмнэлтийн горим руу шилжүүлж байгаа. Тэгээд ер нь ойролцоогоор нэг 600 хүнтэй үйл ажиллагаагаа цаашаа авч явна гэсэн ийм төлөвлөгөөтэй байна.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Салдангийн Одонтуяа. Одонтуяа гишүүн байхгүй байна. Улсын Их Хурлын гишүүн Лхагвасүрэнгийн Соронзонболд.

Л.Соронзонболд: Энэ Монголбанкны 2026 оны мөнгөний бодлогыг харахаар шинэлэг шинэлэг бодлогын арга хэмжээнүүд авахаар тусгасан байна аа. Стэйбл койн, Актив удирдлагын компанийн асуудал байна. Дээрээс нь яг бизнесийн тодорхой салбаруудад чиглэсэн зээлийн бүтээгдэхүүнийг гаргах тал дээр нь яаж дэмжих тал дээр нь анхаарах энэ тэр гээд шинэлэг зүйлс орсон байна. Тэгэхээр энэ 2026 онд эдгээр ингээд мөнгөний бодлогын арга хэмжээг хэрэгжүүлснээр ер нь Монголбанкны маань баланс орлого үр дүнгийн тайлан ер нь ямархуу дүр зурагтай байна гэдэг ийм тооцоолол та бүхэн хийж байгаа байх гэж би найдаж байна.

Тэгэхээр хэрвээ байдаг бол тэрийгээ надад нэг явуулчихвал их зүгээр байна. Зүгээр яах вэ урьдчилсан байдлаар асуухад бол ер нь 2026 онд мөнгөний бодлого хэрэгжүүлээд ашигтай ажиллана гэж харж байгаа юм уу, алдагдалтай ажиллана гэж харж байгаа юм уу гээд 1 дүгээр асуулт байгаад байна.

Дараагаар нь болохоор тайлан уншихаар энэ санхүүгийн тайлангийн олон улсын бүртгэлийн 9 дүгээр стандартыг хэрэгжүүлнэ гээд. Тэгэхээр арилжааны банкнуудын энэ санхүүгийн тайлангийн олон улсын стандарт төслийг хэрэгжүүлснээрээ эрсдэлийн сангаа зардлаа нэмэгдүүлэх иймэрхүү хэрэгцээ шаардлага үүсэхээр байгаа юм уу? Энэ нь хэр их хэмжээний зардлын асуудал яригдаж байгаа вэ гээд нэг ийм асуулт байгаад байна. Би бас өөрөө сая юуны Германы энэ зорилтот бүлэгт орон сууцын зээлийг олгодог энэ Баушпарк гээд энэ системийн үйл ажиллагаатай танилцаад ирлээ. Тэгээд ингээд харж байхад бол ер нь яг орон сууцын зээлийн яг санхүүжилт дээр Төв банк нь оролцохоос илүү Засгийн газар нь их оролцож явна. Тэгээд Засгийн газрын Сэргээн босголтын банк эд нар нь оролцоод явдаг. Арилжааны банкнууд нэг оролцдог. Тэгэхээр манай Монголын одоогийн нөгөө ипотекийн 6 хувийн хөтөлбөр маань илүү Монголбанк маань оролцоод яваад байгаа. Тэгэхээр энэ мөнгөө ер нь цаашдаа яаж Засгийн газраас авахаар төлөвлөж байгаа вэ гээд ялангуяа одоо Монгол Улсын Засгийн газар 2026-2030 оны хөгжлийн 5 жилийн төлөвлөгөөгөө ингээд боловсруулж байгаа.

Тэгэхээр энэ төлөвлөгөөн дээр Монголбанкны зүгээс өөрсдийнхөө саналыг оруулж энэ дээр төлөвлөгөөнд нь оруулах дээр тусгах шаардлагатай байх гэж харж байгаа.

Дараагийн асуулт юу байна гэхээр энэ 2025 оны 2 дугаар улирлын байдлаар ойролцоогоор 1.8 тэрбум ам.доллар-ыг интервенцэд зарцуулсан гээд 81 дүгээр хуудсан дээр байна. Тэгэхээр хэрвээ одоо жишээлбэл энэ интервенцийг хийгдээгүй байсан бол ханш ойролцоогоор 3600 байна шүү дээ. Тэгэхээр ойролцоогоор хийгээгүй байсан бол хэд байхаар байсан юм бэ гээд. Тэгэхээр уншаад үзэхээр яах вэ макро эдийн засгийн нөхцөл байдлаа тааруулаад 2026 онд бол валютын ханшийн уян хатан бодлого баримтална тууштай баримтална гээд. Тэгэхээр ер нь энэ дараа жил экспортын нөхцөл байдал, эдийн засгийн нөхцөл байдал ийм байгаа учраас интервенц бага хийнэ гэж ойлгох уу ямаршуу байдлаар ойлгогдож байгаа вэ гээд нэг ийм асуулт байна аа.

Х.Булгантуяа: 4 номерын микрофон дээрээс ажлын хэсэг.

Б.Лхагвасүрэн: Соронзонболд гишүүний асуултад хариулъя.

Тэгээд 2026 онд нэлээн төсөв өөрөө орлого нь буурч байгаа, зардал нь өөрөө бас тодорхой хязгаартай болж ирж байгаа учраас томоохон тэлэлт гарахгүй юм байна. Тэгэхээр эдийн засаг руу очиж байгаа мөнгөн дээр төсвөөр дамжих нь багасах юм байна гэдэг утгаараа Монголбанк төрийн мөнгөний бодлогын чиглэл дээр банкны салбараар энэ хувийн сектор болон ялангуяа тухайлсан ийм Монгол Улсад дахин боловсруулалт хийж байгаа нэмүү өртөг шингэж байгаа тал руу нь банкны зээлийг, бизнесийн зээлийг түлхүү гаргах ийм бодлого хэрэгжүүлбэ гэж нэлээн тийм зорьж орж ирж байгаа. Тэр утгаараа бол ирэх жилийн мөнгөний бодлого дээр нэлээн том томоохон тийм арга хэмжээнүүд гарах байх. Үр дүн нь ч гэсэн тодорхой хэмжээгээр гарах байх гэж харж байгаа.

Монголбанкны санхүүгийн тайлан өнгөрсөн жил 320 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан. Хэдийгээр Монголбанкны ашиг гэж байгаа боловч энэ нь өөрөө алдагдлаа энэ хэмжээгээр бууруулаад явж байна гэж ойлгож болно. Мөн энэ оны 8 сарын байдлаар нэг 338 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны ашиг бүртгэгдсэн байж байгаа. Энэ маань өөрөө оны төгсгөл рүү бол нэмэгдэх байх гэж харж байгаа. Тэгээд нэмэгдээд гараад ирэхлээр бас төв банкны бодлогын зардлын алдагдлыг бууруулах тал руу нь энэ ингээд зарцуулагдаад явна аа.

Тэгэхээр энэ утгаараа ер нь Монголбанкны үйл ажиллагаа өмнө нь бий болсон алдагдлаа бууруулах чиглэлээр ингээд зохион байгуулаад явж байгаа. Банкны салбарт байж байгаа тэр эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг нэвтрүүлж байгаа зорилго нь бол тодорхой хэмжээний энэ олон улсын нөхцөл байдал, геополитикийн нөхцөл байдал, уур амьсгалын өөрчлөлт ч гэдэг юм уу энэ бүхнээс болоод банкн дээр тодорхой хэмжээний эрсдэлүүд нэмэгдэж байгаа. Энийг харин яаж багасгах вэ эрсдэлийг даван туулахад нь ямар хэмжээний хөрөнгүүд хэрэгтэй вэ гэдгээрээ энэ эрсдэлд суурилсан хяналт шалгалтын бодлогыг нэвтрүүлж байгаа. Одоо бол туршилтын байдлаар явж байна. Туршилтын байдлаар явж байхад мэдээж тодорхой хэмжээнд сан хэрэгтэй болж байгаа. Энэ сан өөрөө эрсдэлийн сан гэхээсээ илүү өөрийн хөрөнгөө нэмэгдэх ийм шаардлагыг бий болгож байгаа. Энэ нь өнөөдрийн Монголбанкны явуулж байгаа банкны секторыг шинэчлэх хөтөлбөртэй нийцтэй байгаа.

Ялангуяа банк тодорхой хэмжээнийхээ хувьцааг гаднын хөрөнгө оруулалт тодорхой хэмжээнд ингээд гараад гаднаас хөрөнгө оруулалт татаад ирэх юм бол энэ өөрийн хөрөнгийн шаардлага нь тэрэнтэйгээ цуг биелэгдээд явах боломжтой гэж харж байгаа. Ипотекийн хөтөлбөрийг 2013 оноос хойш Монголбанк хэрэгжүүлж байгаа. Мэдээж олон улсын байгууллагууд ч тэр Засгийн газартаа энийгээ хэзээ шилжүүлэх вэ гэж байгаа юм. Тэгээд яг Монголбанкнаас өнөөдөр ингээд гаргачихсан байгаа мөнгө бол 3.5 их наяд. Одоо бол ер нь сүүлийн ковидоос хойш ерөөсөө шинэ мөнгө нэг төгрөг ч нэмж гаргаагүй.

Өмнө нь эргэлдэж байгаа санхүүжилт гарсан мөнгө маань эргэж төлөгдөөд эргээд шинэ ипотекийн зээл гаргах маягаар ийм эргэлтийн сан маягаар ингээд явж байгаа. Тэгээд 3.5 их наяд гэдэг бол мэдээж улсын төсөв дээр бол томоохон дарамт болохоор зүйл байгаа учраас мэдээж Засгийн газар өөр дээр авахад төвөгтэй байгаа. Тэгээд Дэлхийн банк олон улсын байгууллагуудтай яриад.

Х.Булгантуяа: 4 номерын микрофоныг нэмж өгье.

Б.Лхагвасүрэн: ОУБ-тай зөвлөлдсөний эцэст энэ ипотекийн ийм бөөний маягийн банк байгуулаад тэр нь өөрөө банкнуудад санхүүжилт өгөөд явна. Эргээд төлөгдсөн дүнгээсээ манай энэ эх үүсвэрийг буцааж төлөх замаар заавал богино хугацаанд байх албагүй. Тодорхой дунд болон урт хугацаандаа төлөгдөж дуусахаар ийм схемийг зурчхаад байж байна аа. Ер нь бол Монголбанк энэ экспортын орлого ялангуяа тэр Оюу толгой, Эрдэнэт, Эрдэнэс Тавантолгой ч гэдэг юм уу томоохон манай ААН-үүд валютынхаа орлогыг Монголбанканд худалддаг байгаа.

Мэдээж нөгөө талд нь импортоор оруулж ирж байгаа ААН-үүд энэ дотоодын зах зээлд валютын эрэлт хэрэгцээ байдаг учраас энд орсон орлогоосоо бид нар зөрүүлээд интервенц маягаар энэ долларыг бол ААН-үүд банкнуудад өгдөг. Ялангуяа ингээд нефтийн импорт дээр ч гэсэндээ тодорхой хэмжээний ийм дэмжлэг үзүүлээд явж байгаа. Тэгээд тэр утгаараа бол ханш өнгөрсөн оноос 5 хувь сулраад байж байна. Хэрвээ энэ 1.8 тэрбум доллар.

Х.Булгантуяа: 4 номерын микрофон дээрээс гүйцэд хариулчихъя.

Б.Лхагвасүрэн: Интервенцээр олгоогүй байсан ханш илүү цаашид чангарна. Тэгэхээр Монголбанкны хувьд бол өнөөдөр нөөцөө ч нэмэгдүүлье, ханшаа ч тогтвортой байлгая гэдэг яг л энэ бараг хязгаарын 2 зорилтын дунд нэлээн оновчтой маягаар явуулж байгаа учраас ханш ингээд 5 хувиар сулраад нэг их инфляцаасаа ч илүү суларч сулрахааргүйгээр ийм тогтвортой байна гэж харж байгаа. Мэдээж нөөц дээр дарамттай. Тэгэхдээ ерөнхийдөө Монгол Улсын экспорт нүүрсний экспорт сэргээд ингээд экспорт сэргээд эхлэх юм бол нөөц цаашаа нэмэгдэх боломжтой гэж харж байгаа.

Х.Булгантуяа: Соронзонболд гишүүн нэмж асууна.

Л.Соронзонболд: Тэгэхээр санхүүгийн тайлангийн олон улсын стандарт 9-ийг нэвтрүүлэхээр өөрийн хөрөнгийг нэмэх шаардлага үүсэх нь байна шүү дээ. Одоо тэгтэл нөгөө нэг Банкны хуулийн 36.1-ээр 20 хувийн шаардлагаас болоод арилжааны банкнууд бол шинээр хөрөнгө оруулагч татахад ялангуяа гадаадаас болон дотоодоос татахад нэлээн хүндрэлтэй байгаа.

Яг энэ нөхцөл байдал дээр нь ингээд олон улсын стандарт мөрдөнө өө. Энэ хүрээнд та нар дүрмийн сангаа нэмэхээр одоо байгаа хувь нийлүүлэгчдийг илүү шахсан болчхоод нэмж хөрөнгө оруулах хөрөнгө оруулагчдыг татах дээрээ жоохон сөргөөр нөлөөлөхгүй юу гэдэг нэг ийм зүгээр надад эргэлзээ төрж байна л даа. Тэгэхээр энийг анхаарна биз дээ.

Х.Булгантуяа: Соронзонболд гишүүн үг хэллээ.

Улсын Их Хурлын гишүүн Саруулсайханы Цэнгүүн.

С.Цэнгүүн: Бид нар Монгол Улсын мөнгөний бодлогын талаар ярилцаж байна. Тэгэхээр Монголбанкны хувьд бол зайлшгүй үндсэн хариуцаж явж байгаа зүйл маань инфляцын тухай бодлого байгаа юм. Тэр инфляцад хамгийн ихээр нөлөөлдөг зүйл маань Засгийн газрын урсгал зардлаар дамжаад бэлэн мөнгө өгөх зах зээл рүү их хэмжээгээр нийлүүлэгдэх энэ асуудал байгаа юм. Тэгээд маш гоё нэртэй төслүүдийг Засгийн газар санаачлаад тэгээд бэлэн мөнгө хэлбэрээр зах зээл

рүү шууд нийлүүлдэг. Тэгээд энийг яагаад хийдэг вэ гэхээр ердөөсөө жил болгоны сонгуультай холбоотойгоор элдэв шинэ төслүүдийг санаачилчихдаг.

Жишээ нь 2024 оны 2 сард Эрдэнэс Тавантолгойгоос 1072 хувьцааг нэг хүнд 350 мянган төгрөгөөр өгнө гэж тооцоод тухайн жилдээ 4.5 их наяд цэвэр ашигтай ажиллаж байсан ЭТТ-оос 3.9 их наядыг нь тараачихсан байгаа юм. Тэгээд 1 тэрбум ам.долларын дүнгээр бид нар одоо жишээ нь 600 мвт цахилгаан станцыг ч барьчих бүрэн боломжтой байсан мөнгө маань бол зөвхөн бэлэн мөнгө хэлбэрээр иргэдэд тараагдаад инфляцаа өсгөөд дууссан байгаа юм. Энэ нь тоонуудаараа харагдана. Тэгээд энэний дараагаас шинэ хоршоо хөтөлбөр ч гэдэг юм уу ингээд элдэв бусын бэлэн мөнгийг л зах зээл рүү иргэд рүү амлалт хэлбэрээр оруулсан нэг ийм гажуудсан тогтолцоо байгаа юм л даа. Тэгээд иргэдийн дунд хамгийн удаан хугацаанд хэрэгжээд бас иргэдэд хамгийн хүрсэн хөдөлмөр маань хүүхдийн мөнгө байгаа юм. Тэгээд хүүхдийн мөнгө маань бол хүн амын бодлоготой уялддаг учраас энэ бодлого маань өөрөө үргэлжлэх ёстой байгаад байгаа юм. Тэгээд айл гэрүүд бид бүхэн яаж хүн амынхаа бодлогыг зүгээр төлөвлөх вэ гэдэг дээр харахаар уг нь бид нар хөдөлмөр эрхлэлттэй холбож өгөх ёстой энэ асуудлыг. Хүүхдийн мөнгийг зүгээр бэлэн мөнгөөр дансанд нь хийх гэхээсээ илүүтэйгээр айл гэр ам бүлээ нэмэх юм бол бид хөдөлмөр эрхэлж байгаа тэр ээж ааваас нь орлогын албан татвараас чөлөөлөх, бусад албан татваруудаас чөлөөлөх байдлаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ёстой. Мэдээжийн хэрэг нэн ядуу айл өрхүүд байгаа. хүнсний хомсдолд орчихсон.

Тэгэхээр тэр хүмүүстээ бид нар тусгай бодлого хэрэгжүүлдэг улс орнуудын жишиг байдаг. Тэр маань болохоороо дотоодын үйлдвэрлэгч нараасаа сүү, хүнс, хүнсний бүтээгдэхүүнүүд, живх зэрэг тухайлсан хүүхдэд зориулсан бүтээгдэхүүнүүдийг худалдаж авах зорилгоор гаргадаг. Тэгэхгүй бол бид бүхэн бэлэн мөнгийг нийлүүлчихдэг. Энэ маань өөрөө манай Монголын дотоодын зах зээлд Монгол үйлдвэрлэгч нараараа дамжиж үлдэхгүй байгаа учраас буцаагаад энэ чинь маш их хэмжээний ханшийн зөрүүг бид нар дээр гарч ирдэг. Энэ бодлого маань өөрөө буруу байгаад байгаа юм л даа.

Тэгэхээр ер нь бол энэ хүүхдийн мөнгийг хасах, өгөхгүй гэдэг тал дээр огт асуудал байхгүй байгаа юм. Хамгийн гол асуудал нь бид нар энэ бодлогыг хэрхэн яаж зөв болгох юм бэ? Хөдөлмөр эрхлэлттэй яаж уях юм. Нөгөө талдаа дотоодын үйлдвэрлэлийг дэмжих талд нь бид нар энийг болгоод үндсэндээ мөнгөний бодлого талаасаа энийгээ сайжруулах боломж байна уу? Тэгэхээр Монголбанкнаас асуумаар байна. Хүүхдийн бодлого, хүүхдийн мөнгө маань өөрөө энэ мөнгөний бодлого дээр ер нь яаж нөлөөлдөг вэ? Бид бүхний энэ гаргасан байгаа бодлогоо бид эргэж харах шаардлагатай юу?

Х.Булгантуяа: 4 номерын микрофон.

Б.Лхагвасүрэн: Цэнгүүн гишүүний асуултад хариулъя.

Ер нь хүүхдийн мөнгө бол энэ олон улсад байдаг энэ бодлогын арга хэрэгсэл байгаа. Тэгээд ер нь хүн амаа өсгөх юм уу, хүн амдаа чиглэсэн ялангуяа тэр зорилтот бүлгийг хамгаалах ийм чиглэлтэйгээр энэ бодлого хэрэгждэг юм байна лээ. Тэгэхээр манайд бол ерөнхийдөө ингээд хавтгай явж байгаа гэж хэлж болно ялангуяа ОУВС-ийн нөгөө дүгнэлт дотор бол ерөнхийдөө энийг зорилтот бүлэг рүү нь чиглүүлээч гэдэг талаас нь ярьж байгаа юм. Яах вэ Монголбанкна дээр бол ганц

нэг жижиг судалгаа, их сургууль, олон улсын байгууллагуудаас гарсан судалгааны дүнг бол бид үзэж танилцдаг байгаа. Тэрэн дээр яг өнөөдрийн манай энэ хүүхдийн мөнгө хуваарилагдаад юу болж байна гэдэг талаас нь судалгаа байгаа. Тэрэн дээр бол яг сар болгон очиж байгаа 100 мянган төгрөгийн хүүхдийн мөнгөний 30 хувь нь хуримтлал маягаар тухайн өрхдөө хүүхдийн нэр дээр юм уу хуримтлал болоод явж байна. 70 хувь нь хэрэглээ рүү явж байна гэж байгаа юм.

Тэгэхлээр яах вэ ер нь бол ингээд сошиал мэдээлэл харж байхад бол ялангуяа тэр хүүхдийн мөнгө хуваарилсны дараа бол энэ хотын захын тойргууд дээр хүнсний борлуулалт нь нэмэгддэг, тэр дэлгүүрүүд нь маш идэвхждэг. Бүүр тэр битгий хэл архины борлуулалт ч нэмэгддэг гэдэг утгаараа ингээд жишээнүүд яваад байгаа учраас шууд бэлэн мөнгө тараах нь мэдээж эерэг болон сөрөг үр дагаврууд байна л гэж л Төв банкны зүгээс харж байгаа юм. Тэгээд ер нь бол тантай л яг л санал ойролцоо л байна л даа. Ямар ч байсан зорилтот бүлэг рүү чиглэсэн ийм бодлого байх ёстой.

Тэгэхээр бол тэр өрхийн хэрэглээнд нь өрхийн орлогод нь маш том байр суурь эзэлж байгаа. Тэрүүгээрээ өөрийнхөө амьдралыг залгуулаад явж байгаа улсуудад энэ хүүхдийн мөнгө зайлшгүй байх шаардлагатай. Зарим хэсэгт угаасаа хүүхдийн мөнгө хэрэгцээгүй бол тэрийг тэгж хуваарилах хэрэгцээ байхгүй ээ. Энэ нь өөрөө татвар дээрээ өөр зүйлд зориулалтаар улсын төсөв дээрээ өөр зүйлд зориулагдаад явах юм бол мэдээж үр дүн гарна гэж харж байгаа юм. Өшөө яг тантай нэг санал нэг зүйл байгаа нь жишээлбэл Японд бид нар судалгаа хийсэн.

Японд хүүхдийн мөнгийг буцааж олгохдоо шууд яг өвлөлгүйгээр аав ээжийнх нь татвар төлсөн мөнгийг нь эргэж өгөх маягаар татвар төлсөн мөнгө гэдэг маань мэдээж хөдөлмөр эрхлээд цалин аваад цалингийн орлого болсон мөнгө нь жилийн эцэст буцаад тэр дүнгээрээ хүүхдэдээ өгөөрэй гэж өгөөд дээр нь дотоодын үйлдвэрлэлийнхээ хүүхдэд зориулсан тэр живх байдаг юм уу бусад зүйлийг тараадаг ийм туршлагууд байгаа юм. Тэгэхээр аль болохоор ийм хэлбэр рүүгээ шилжих нь зөв л гэж харж байгаа юм.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Мэндбаярын Мандхай.

М.Мандхай: Энэ өдрийн мэнд хүргэе.

Мөнгөний бодлого бол яг төсөвтэйгөө ч гэсэн ижилхэн одоо энэ ХАА-н салбарын хөрөнгө оруулалт, зээлийн хүртээмж, үнийн тогтвортой байдалд бол маш нарийн уялдаатай гэж харж байгаа. Тэгэхээр 3 асуулт асууя. 2026 онд зээлийн өсөлтийг 5-аас 6 хувийн орчимд барина гээд заачихсан байсан. Тэгээд энэ нь өөрөө инфляц бууруулахад чиглэсэн ч гэсэн ХАА-н салбарт энэ ХАА-н зээлийн хүртээмж буурах эрсдэлтэй юм байна гэж харагдаад байгаа юм. Тэгэхээр миний асуух гээд байгаа асуулт бол энэ мөнгөний бодлогоор энэ зээлийн өсөлтийг хязгаарлаж байгаа нөхцөлд ХАА-н салбарын улирлын болон энэ хөрөнгө оруулалтын зээлийг хэрхэн хамгаалах вэ? Энэ бодлого ХАА-н үйлдвэрлэлд сөргөөр нөлөөлөхгүй гэдэгт Монголбанкны зүгээс ямар баталгаа гаргаж өгөх вэ гэж асуумаар байгаа юм.

Хоёрдугаарт бодлогын хүүг 12 хувь түвшинд хадгалж байгаа. Гэтэл одоогийн байдлаар арилжааны банкны хүү 18-аас 20 хувьтай байгаа. Тэгэхээр манай МАА-н салбар тариалангийн энэ зээлд зохимжгүй илүү нөгөө өндөр өртөгтэй өндөр өртөг

үүсгэхээр байгаа. Тэгэхлээр энэ бодлогын хүү өндөр байх нь ХАА-н салбарын үйлдвэрлэлийн зээлийг илүү хязгаарлах юм биш үү?

Тэгээд төв банк энэ ХАА-д зориулсан хөнгөлөлттэй санхүүжилтийн сувгийг яаж хадгалах вэ эсвэл тусгай зээлийн багцыг үргэлжлүүлэх үү гэдэг асуулт байна.

Гуравт нь болохоор 2026 оны энэ төсөвт ХАА-д чиглэсэн хөрөнгө оруулалт 2025 оноос 2.3 хувиар буурсан. Урсгал зардал харин эсрэгээрээ өссөн байгаа. Тэгэхээр энэ үндсэн чиглэлд зээл хатуу хүү өндөр байхаар байгаа учраас төрийн хөрөнгө оруулалт буурч хувийн хөрөнгө татах ийм боломж хязгаарлагдмал харагдаж байгаа. Тэгэхээр энэ 2026 оны төсөв дээр ХАА-н хөрөнгө оруулалтыг бууруулж байгаа үед мөнгөний бодлого зээлийг энэ хязгаарлаж байна гэж харж байгаа. Тэгээд ийм учраас салбарын нийт хөрөнгө оруулалтын хэмжээ агших ийм эрсдэлтэй юм байна.

Тэгэхээр энэ бодлогын уялдаа хэрхэн хангагдаж байгаа вэ гэсэн асуулт асууя.

Дээрээс нь нэг ногоон зээлтэй холбоотой Ногоон санхүүжилт дэд зорилт хэлбэрээр дурдагдсан байна. Тэгэхдээ энэ ХАА-н салбарт чиглэсэн ногоон зээлийн бодлого тодорхой байхгүй байгаад байгаа. Тэгэхээр энэ уур амьсгалын эрсдэл энэ ХАА-н тогтвортой үйлдвэрлэлд зориулсан санхүүжилт ямар байдлаар тусгадаг юм бэ гэсэн 4 асуулт асуучихъя.

Х.Булгантуяа: 4 номерын микрофон ажлын хэсэг.

Б.Лхагвасүрэн: Мандхай гишүүний асуултад хариулъя.

Тийм нөгөө таны саяын 5, 6 хувь гэдэг бол тийм тоо байхгүй. Зүгээр өнөөдрийн байдлаар зээлийн өсөлт 26 хувьтай байгаа. Яг энэ 23 хувьтай байгаа. Энэ 8 сарын эцсийн байдлаар. Ирэх жил 2026 онд бид нар зээлийн өсөлт 15-аас 20 хувь байх болов уу гэсэн ийм төсөөлөл таамаглал хийсэн. Өнгөрсөн жилүүдэд бол бүр 30 гаруй 35 хувьтай байсан. Одоо нэлээн нөгөө хэрэглээний зээлийг танаад явж байгаа учраас нийт зээлийн тэр өсөлтийн хувь хүү нь ингээд буураад явж байгаа. Тэгээд 26 хувьтай. Ирэх жил бол 15-аас 20 гэдэг бол ер нь их тогтвортой. Бас энэ эдийн засгийнхаа тэнцвэртэй байдалд зөв болох болов уу гэж харж байгаа. Хэрэглээний зээлийг нэлээн танаж ирсэн учраас одоо бол нийт банкны гаргасан зээлд 42.2 их наяд байна. Тэрний 39 их наяд нь юунд зориулсан бизнест зориулсан зээл.

Тэгэхээр үлдсэн нь бол хэрэглээний зээл. Тэгэхээр бизнесийн зээл бол нэлээн ингээд томроод явж байгаа. Өмнө нь бараг тэнцүү шахуу болж ирж нэлээн хэрэглээний зээлүүд тэлж байсан учраас бодлогын арга хэмжээний үр дүнд илүү бизнес рүүгээ чиглэсэн зээл гарч эхэлж байгаа гэж харж байгаа. Тэгээд Монголбанкны хувьд бол ирэх жилүүдэд ялангуяа таны хэлж байгаа тэр ХАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих тал руу нь тэр нийлүүлэлтийн сүлжээний ийм зээлүүдийг банкнуудтайгаа нийлж бүтээгдэхүүн маягаар гаргахаар ажиллана гэдгээрээ тусгайлан энэ 2026 оны Мөнгөний бодлого дотроо дурдчихсан.

Тэгэхээр ингээд жишээлбэл ноолуураа жишээ авахад бол 10 мянган тонн түүхий ноолуур угаагдаад 7 мянга, тэгээд самнагдаад 5 мянга болж байгаа энэ

процесс болгон нь өөрөө тус тусдаа үйлдвэр юм уу нэг үйлдвэр ч байж болно. Ер нь дийлэнхдээ тусдаа үйлдвэрүүд байгаа юм. Тэгэхээр энэ шат дамжлага болгон дээр ямар хэмжээний санхүүжилт хэрэгтэй байна, ямар дэмжлэг байвал илүү их үйлдвэрлэл нэмүү өртөг бүтээгдэх вэ гэдэг рүү нь ингээд чиглүүлээд явж байгаа гэж ойлгож болно оо. Ногоон зээл бол ер нь манай арилжааны банкнууд ногоон бондыг босгоод ногоон эх үүсвэр их авчирч байгаа. Эргээд ингээд ногоон зээл ногоон бизнес чиглүүлээд гаргах гэхээр нөгөө зээл авах гэж байгаа ААН-үүд нь өөрөө бизнесийнх нь зорилго нь ногоон биш байгаад байдаг учраас энэ хооронд ингээд нэлээн төвөгтэй байдал үүсээд байгаа юм.

Тэгэхээр аль болохоор ногоон зээлийн нөгөө таксономи гэж байгаа. Ямар бизнесийг ногоон гэж тодорхойлж шалгуур үзүүлэлтээр үзэж байгаа вэ гэдгийгээ гаргаад өгчихсөн байгаа учраас яваандаа илүү ногоон зээл гарна гэж харж байгаа. Тэгээд манай банкны сектор нийлээд ерөнхийдөө 2030 он гэхэд нийт зээлийнхээ багцыг 10 хувийг нь ногоон зээл болгоно гэсэн зорилт тавиад явж байгаа. Өнгөрсөн онд бол 3 хувь нь ногоон зээл байсан бол энэ жил 5 хувь нь ногоон зээл болоод явж байгаа. Тэгэхээр бол энэ 10 хувь болгох зорилт тийм төвөгтэй зорилт биш байна л гэж харж байгаа юм.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Энхбаяр.

Ж.Энхбаяр: Монголбанкны хамт олонд энэ 2025 оны Мөнгөний бодлого үндсэндээ тавьсан зорилтынхоо хүрээнд амжилттай хэрэгжиж байна. Ийм хэрэгжих тоон үзүүлэлтүүд гарч ирж байна. Манай салбар арилжааны 10 банк Монголбанктай хамтраад Атрын-4, Цагаан алт гэсэн 2 том үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүллээ. Тэгээд эдийн засгийн өсөлт салбарын өсөлт 35.6 хувь, ДНБ-д эзлэх хувь хэмжээ 3.6 хувь буюу томоохон ийм өсөлтийг гаргалаа. Тэгэхээр мөнгөний бодлого дээр энэ бизнесийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлд ингээд бодлогын арга хэмжээ боловсруулна гээд ороод ирсэн байгаа.

Энэ жил бий болсон энэ 48 мянган ажлын байр яг энэ Атрын-4, Цагаан алтыг дагаж боловсруулах үйлдвэрүүд дээр ХАА-н салбар дээр бий боллоо. Тэгэхээр энэ ололт амжилтыг одоо 2026 онд бүгдээрээ хэрхэн хадгалах вэ. Нөгөө талаас мөнгөний бодлогын хүрээнд орон зай хэр байна. Бид хэд хэдэн дараагийн чиглэлийг босгож ирэх боломж шаардлага байна. Жишээлбэл сүүний кластер, сүүний хангамж их сул байгаа. Импортын хамаарал өндөр байна. 4 улирлын хүлэмжийн шаардлагатай нийлүүлэлтийг дотроо бий болгох шаардлага байна. 4 улирлын хүлэмжийн аж ахуйнуудыг яагаад гэвэл импортын тоо их байна. Сүүний бараг жараад хувь нь импорт. Хүлэмжийн ногооны бараг наяд хувь нь импортоор орж ирээд байгаа. Нэлээн олон 100 сая долларын хэмжээ яваад. Тэгэхээр аль болох л импортоо багасгах, дотоодын үйлдвэрлэлийг нэмэх ийм бодлогуудыг цаашид үргэлжлүүлэх хэрэгтэй байна. Ийм орон зай хэр байна вэ гэдгийг танаас нэг сонсмоор байгаа юм.

Тэгээд эцэст нь та бүхэнтэй хамтарч ажилласандаа их талархал илэрхийлэхийг хүсэж байна. Салбар их урам зоригтой байгаа. Ажил их өрнөж байна. Олон олон өгүүлбэрүүд шинээр орлоо, өргөтгөлөө сайн хийлээ, хөрөнгө оруулалтыг зоригтой ч шийдлээ. Зарим нэг ийм эрх зүйн саадыг эс тооцвол ер нь салбар нэлээн үр дүн гарс гарсан нь энд тодорхой байна. Тэгэхээрээ энэ салбарын тэр дотор нь задалчихсан ийм нарийн эдийн засаг талаасаа судалгаа дүгнэлтүүдээ жаахан тайлбарлаж өгөөч. Жишээ нь ноолуур дээр жишээлбэл яаж гарав, арьс ширний

салбар дээр яаж байна. Газар тариалан, МАА бусад салбар дээр яаж гарч байна яг юунд анхаарах ёстой байна гэж? Сая бол энэ жил өнгөрсөн жилийн хамтын ажиллагаа тун эвтэйхэн тун боломжийн явчихлаа ААН-үүд, салбар бодлогын яам Монголбанкнуудтайгаа нийлээд. Энэ дээр саналаа бодлоо хуваалцаач за.

Х.Булгантуяа: 4 номерын микрофоноос ажлын хэсэг.

Б.Лхагвасүрэн: Энхбаяр гишүүний асуултад хариулъя.

Тэгээд ХАА-н салбар манай ДНБ-ий 7.3 хувийг эзэлдэг нэлээн том салбар. Ажиллах хүчин талаасаа бол бүүр 22 хувь буюу 5 хүний нэг нь ХАА-н салбарт ажиллаж байгаа ийм маш чухал ийм салбар байгаа. Тэр утгаараа нэгэнт Засгийн газар хөнгөлөлттэй хүүгийн хөтөлбөр хэрэгжүүлбэ. Хүүгийн татаас хэлбэрээр хүүгийн хөнгөлөлт үзүүлбэ гэдгээрээ орж ирж байгаа. Учраас Монголбанк мэдээж энэ үйл ажиллагааг дэмжиж оролцож явсан. Тэгэхдээ Монголбанкнаас бол өөрөөс нь бол нэг төгрөг ч гараагүй. Арилжааны банкны илүүдэл нөөц маягаар төв банкны үнэт цаасанд байршиж байсан тэр эх үүсвэрийг эргээд эдийн засгийн эргэлтэд оруулах маягаар тэр хүнсний хувьсгал, шинэ хоршоо, Цагаан алт, Атрын-4 ч гэдэг юм уу энэ аянуудын хөтөлбөрүүд хэрэгжээд явсан. Энэ дээр бол тодорхой үр дүнгүүд гараад байж байгаа. Зүгээр та сая жишээ байвал гэж хэлсэн учир би зүгээр ноолууран дээр юу болсон бэ гээд.

Ер нь бол 2021 онд яг ковидын үед хил хаалттай байхад бол Монголбанк нэг нийлүүлэлтийн сүлжээний судалгаа хийсэн юм байгаа юм. Тэр судалгаа болохлоор нийтдээ хавар болгон хэчнээн мянган тонн ноолуур, түүхий ноолуур худалдаж аваад, бэлтгэж аваад тэгээд яаж боловсруулаад, эцсийн бүтээгдэхүүн болтлоо хэдэн шат дамжлага явдаг вэ, дамжлага болгон дээр нь ямар үйлдвэрлэлийн потенциал байна гэдгээрээ гаргасан. Тэгээд Монгол Улсад бол угаах хүчин чадал 100 хувь суурилагдсан. Самнах хүчин чадал өнгөрсөн онд 100 хувь суурилагдсан юм байна лээ. Тэгээд тэрний дараагийн шат ээрэх байдаг юм уу тэр шатнууд дээрээ ингээд багасаад явдаг юм байна лээ. 15-аас 20 хувьтай болоод ингээд ингээд багасаад тэгэхээр илүү цаашаагаа нэмүү өртөг шингээе гэвэл энэ хүчин чадлыг л суурилуулах шаардлагатай юм байна лээ. Тэгээд энэ оны үр дүн яаж гарч байна гэхлээр өнгөрсөн онд бол ноолуурыг 4400 мянган тонн ноолуурыг бэлтгээд нэг дунджаар 41 ам.доллар-оор шууд угаагаад экспортод гаргаж байсан юм байна лээ. Энэ жил бол ерөнхийдөө яах вэ ноолуураар орж ирж байгаа орлого нь буурчихсан байгаа хэдий ч чанарын маш том өөрчлөлт гарсан нь одоогийн байдлаар 1.5 мянган тонн ноолуурыг самнаад нэг нь нэг бүрийнх нь 1 кг нь нэг хүнд 130 доллар буюу бараг 3 дахин өндөр үнээр экспортод ингээд гаргаад явж байгаа. Тэрний дараагийн шат дамжлага болсон тэр ноолууран топс гээд ингээд самнасан ноолуураа ингээд жоохон утас маягаар ингээд ээрэхээс наад талын шатлалаар явж байгаа. Энэн дээрээ анх удаагаа ингээд 7 сая долларын экспорт хийгдчихсэн байгаа ч гэдэг юм уу. Ингээд ер нь цаашаагаа боловсруулах шат нь явж байгаа юм байна лээ.

Тэгэхээр энэ дөнгөж эхэлж байгаа үйл ажиллагаа маань маань ирэх жилээс илүү жигдрээд эхлэх юм бол Монгол Улс ноолуураараа их хэмжээний орлого олох боломж потенциал нь байна гэж харж байгаа. Тэгээд бидний хувьд ч гэсэн судалгаагаа ноосон дээр чиглүүлсэн. Жилдээ Монгол Улс 30 мянган тонн түүхий ноосыг бэлтгэдэг юм байна лээ. Тэгэхээр одоо ер нь бараг 50 хувь нь ч үйлдвэрлэлийн шат дамжлага, дараагийн шат руугаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж дууслаа. Мөнгөний бодлоготой холбоотойгоор үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. 4 гишүүнээр тасаллаа. Улсын Их Хурлын гишүүн Доржсүрэнгийн Үүрийнтуяа. Баярлалаа.

Д.Үүрийнтуяа: Өнөөдөр инфляцын түвшнийг аваад үзэхээр ингээд 2 янзын мэдээлэл яваад байгаа юм. Би Байнгын хороод дээр Лхагвасүрэн ерөнхийлөгчөөс асууж байсан. Сангийн яамны мэдээлэл бол 2 янз тайлбарлагдаад байгаа юм. Төсвийн хэлэлцүүлгийн үеэр. Дараа нь танаас тодруулсны дараа Төсвийн байнгын хороон дээр бас дахиад зөрүүтэй мэдээлэл явж байгаа юм. 2025 оны инфляцын түвшнийг эхний удаа Засгийн газар 9.5 гэж Сангийн яам Ганбат дарга тайлбарлаад та бол 8 хувьд итгэл төгс байна гэж байгаа юм. Өчигдөрхөн манай Сангийн яам бол 8.6 байна гэж байна лээ. Тэгээд энэ хүлээгдэж байгаа гүйцэтгэлийг та хэд ярьж байгаад нэг болгочхож болдоггүй юм уу? Энэ дээрээ анхаараач ээ.

Яагаад гэхээр бид нар 2026 оны төсөв дээр 2025 оны инфляцын хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэвэр тэтгэмжийг тэр хувиар нэмэх хуулийн үүрэгтэй. Тийм учраас энэ хуулиар тогтоосон үүргээ хэрэгжүүлэхийн тулд гүйцэтгэлээ ядаж гаргаж сурмаар байна. Энийгээ 1 дүгээрт тодорхой болгочхооч 2 дугаарт энэ инфляц тооцож байгаа арга аргачлалаа эргэж харах талаар та бүхний бодлого танилцуулга дотор ерөөсөө алга байна. Цаасан дээр байгаа инфляцын түвшин өнөөдөр амьдрал дээр байгаа инфляцын түвшин 2 асар их зөрөөтэй байна. Ард иргэдийн амьдрал энэ юмны үнийн өсөлт яаж нөлөөлж байгаа вэ гэдгийг механик аргачлалаар сагсны хэдэн бүтээгдэхүүнийхээ үнийн өсөлтөд тооцоолоод суухаас илүүтэй бидний энэ тооцож байгаа арга өнөөдөр нөлөөлж чадаж байна уу үгүй юү гэдгээ эргэж хармаар байна. Ингэж байж бид нар мөнгөний бодлого ярихгүй бол сайхан статистик тоо ярьж суусаар байтал бодит амьдрал маш зөрүү үүсэж байна шүү. Ард иргэдийн амьдрал ахуй, цалин хөлс, энэ төгрөгийн ханш, валютын ханшийн зөрөө гэдэг юм чинь бол бидний мэдлээс гараад явчихлаа. Тийм болохоор энэ бол одоо Монголбанк бол үндсэндээ энэ мөнгөний бодлого дээр маш хатуу байр суурьтай хэнээс ч үл хамаарах улс төрийн нөлөөнд автахгүйгээр мэргэжлийн цэвэр эдийн засаг эх орны улс төр энэ макро улс төрөөс хамаарахгүйгээр эх орны энэ макро эдийн засгийн бодлогыг зангидаж барьж байх ёстой газрын хувьд амьдралдаа нийцэж бодлого шийдвэрээ гаргадаг баймаар байна аа.

Тэтгэврийн зээлийн асуудлыг би байнгын хороон дээр ярьсан. Тэгээд яах вэ цаг бага учраас бидэнд энийг ярилцах цаг олдохгүй байгаа юм. Хэлэлцэх цаг хугацаа их богинодоод байгаа юм. Тэгээд олон улсын жишиг ийм байдаг ядуу буурай хэдэн орнууд тэтгэврийн зээлтэй байна гэдэг зүйл ярьж байгаа юм. Бид өнөөдөр тэгвэл тэр орнуудын жишигт л байна л даа.

Тийм учраас өнөөдөр бид нарт тэтгэврийн зээл байхаас өөр арга байхгүй. Энэ бол зээлийн бүтээгдэхүүн юм биш юм гэж хэлээд сууж байх эрх байхгүй. Энэ хэдэн тэтгэврийн зээлтэй, тэтгэврээрээ амьдарч байгаа энэ 400 мянган ахмадыг ер нь цаашдаа бид нар яаж амьдар гэж хэлэх юм. Тэгэхээр энэ банк санхүүгийн бодлого дээрээ энэ банкныхаа асуудлуудыг ярихдаа энэ асуудлыг битгий хаяач ээ. Магадгүй онолын хувьд зарчмын хувьд таны зөв. Би мэргэжлийн хүний хувьд таны байр суурийг хүндэтгэж байна. Гэхдээ өнөөдрийн хөрсөн дээрээ буусан бодит нөхцөл байдалтай таарсан төрийн бодлого Монгол Улсад хэрэгтэй байна шүү дээ. Олон улсын онол практикаар биш, амьдралд нийцсэн, Монгол Улсын хөрсөн дээр

тохирсон төрийн бодлого бидэнд хэрэгтэй байна шүү дээ. Бусдыг дагаж явах биш өнөөдөр өөрсдийнхөө боломж нөөцөд тулгуурлан асуудлаа шийдэж засъя л даа.

Тэгээд энэ тал дээр Монголбанк маань мөнгөний бодлогоо ирэх оныхоо том бодлогыг батлуулж байгаа үед та бүхэн анхаараач.

Бидний эцсийн зорилго ард түмний эрх ашгийн төлөө л байх ёстой. Тэрний төлөө та бид энд сууж байгаа гэдгээ ухамсарлаасай гэж хүсэж байна.

Х.Булгантуяа: Үүрийнтуяа гишүүн үг хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Энхбаярын Батшугар.

Э.Батшугар: Баярлалаа. Би нөгөө хар жагсаалтын талаар л ярих гээд байна л даа. Хууль нь 9 сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэн. Гэхдээ бол ард иргэдийн хүлээлтэд хүрэхгүй байна. 4.8 сая өгөгдөл байгаа. 1.2 сая иргэний. Тэгэхээр энийг боловсруулалтад ямар нэгэн алдаа гараад байна, олон улсын жишигт хүрэхгүй байна. Тэгэхээр би Байнгын хороон дээр хэлсэн. Монголбанк тусгай зөвшөөрөл олгодог байгууллага. 2 байгууллагад олгочихсон байгаа. Тэгэхээр яаралтай шалгалт оруулаад хаана нь алдаа байна. Алгоритм нь ажиллахгүй байна уу, яагаад олон улсын жишгээр явахгүй байна гээд ингээд шалгалт оруулаарай гэж ахиж хэлмээр байна.

Хоёрт нь энэ тэтгэврийн зээлийн талаар бол маш олон ахмадууд бол бухимдалтай байгааг бол нууц биш бүгдээрээ мэдэж байгаа юм. Тэгэхээр үүнтэй холбоотой байр суурь янз янз л байна л даа. Тэгэхдээ сая Үүрийнтуяа гишүүн хэлж байна. Бид нар чинь олон улсын жишгээсээ илүү Монгол Улсын Монголын хөрсөн дээр буусан амьдралд нийцсэн зүйл хэрэгтэй гээд. Тэгэхээр магадгүй Монголбанк, банкнууд, Банкны холбоо ч юм уу тэгээд нийгмийн даатгалын нэг гэрээ хийгээд тодорхой хэмжээний дээд заагийг нь гаргадаг ч юм уу? Тэгээд банкнууд нь тодорхой хэмжээний зардлаа нөхөөд 1, 2 хувийн ашиг хийгээд ипотекийн зээлтэй адилхан л тийм бүтээгдэхүүн гаргах бололцоо байдаг уу гэвэл сайн судлах ёстой байх аа. Яагаад гэвэл амьдрал баян. Монгол чинь баян улс биш өөрсдөө. Тэгэхээр бол энийг тэтгэврийн зээл дээр тодорхой хэмжээний шийдэл байгаа л гэж хараад байна л даа. Гуравласан гэрээ хийгээд яах вэ банкнууд нь бол зардлаа нөхөөд тодорхой хэмжээний хэдэн хувийн ашиг хийгээд 1, 2 хувь ч юм уу. Энэ логик бол олон гишүүд яриад байгаа юм. Би ч гэсэн санаа нэг байгаа юм. Энэ тэтгэврийн зээл чинь өөрөө маш тусдаа бүтээгдэхүүн. Сарын эхээр автоматаар орж ирэхээр нь шимтгэлийг нь авчихдаг. Шимтгэл нь зээлийнх нь төлбөрийг нь авчихдаг хүүтэй нь.

Тэгэхээр заавал 24 сар, 12 сар, 36 сар гэж байснаас ер нь яг тодорхой хэмжээний максимум болон дээд хязгаарыг нь тавьж өгөөд нөгөө иргэн нь өөрөө хэрэгцээндээ тааруулж авах тийм бололцоо гээд л нэг их юм яригдаж байгаа юм л даа. Баярлалаа.

Х.Булгантуяа: Батшугар гишүүн үг хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Лхагвасүрэнгийн Соронзонболд.

Л.Соронзонболд: Би түрүүн хэлсэн. Ер нь Монголбанкны энэ 2026 оны мөнгөний бодлогын чиглэл, 2025 оны хэрэгжилт бол агуулгын хувьд чанарын хувьд аягүй сайн болсон байна гэж хэлмээр байна. Тэгэхээр энэ дээр ажилласан хүмүүс сайн ажилласан байна. Цаашдаа анхаарах асуудал дээр нэг юм хэлэхэд бол энэ

зээл иргэд маань энэ зээлийн өрийн дарамтад их орж байна гээд судалгаагаар ч гарсан байна аа. Гэхдээ нөгөө талдаа бол энэ чинь өөрөө нөгөө зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагаа чинь бодит цагийн горимоор ажиллахгүй байгаатай холбоотой.

Тэгэхээр энэ чиглэл рүүгээ хөрөнгө оруулалтаа хийж энэ үйл ажиллагааг сайжруулах талаар анхаарах ёстой гээд бид өнгөрсөн жилээс хойш бол яриад байгаа юм. Тэгэхээр энэ дээр нэлээн сайн ажил хийх ёстой байх гэж харж байгаа юм.

Хоёрдугаарт энэ 2025 онд гаднын хөрөнгө оруулалттай гаднын хөрөнгө оруулагчдыг банкны сектор татах талаар нэлээн ажлууд уул нь төлөвлөсөн. Гэтэл манай улсын иргэд юу гэж бодоод байна гэхээр гаднаас гадаадын банк орж ирвэл зээлийн хүү буурах гээд байдаг. Энийг нь ингээд хориод байдаг гэдэг ийм ойлголт байгаад байдаг. Тэгэхээр энэ тал дээр Монголбанк яг энэ гадаадын хөрөнгө оруулалттай банкнаас сонирхож Монголбанк руу хүсэлт өгсөн юм байдаг юм уу байдаггүй юм уу? Энэ талаараа иргэдэд ойлголт өгч байхгүй бол бас иргэдийн зүгээс ер нь бол гаднын банкнууд орохыг нь хориглоод байна гэсэн ийм ойлголт байдаг. Тэгэхээр энэ тал дээрээ ажлууд зохион байгуулах хэрэгтэй байх гэж харж байна.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Энхбаяр.

Ж.Энхбаяр: Монголбанкны мөнгөний бодлого бол эдийн засгийг тогтвортой байлгах, ялангуяа өсөлтийг дэмжих, иргэдийнхээ орлогыг хамгаалах, инфляцад идүүлчихгүй байх, инфляц руу гол зорилт болгож ажиллах ёстой. Тэгээд энэ тавьж байгаа зорилтын хүрээнд ирэх жил их өөдрөг харагдаж байгаа. Инфляц бол 5 хувь дээр гэсэн ийм бодлогын зорилт байгаа. Инфляц дотор ХАА-н салбарын нөлөөлөл өндөр байгаа. Мах, сүү, гурил гээд энэ үнийн өсөлт нь инфляцад томоохон байр суурь эзэлчихдэг. Иймд бид нар энэ ХАА-н салбарт гараад байгаа энэ эдийн засгийн өсөлтийг их тогтвортой байдлаар дэмжих, улам өсөлтийг цааш нь явуулах маш том орон зай боломж байна. Энэ дээр л бодлогын арга хэмжээгээ бодлогын дэмжлэгүүдийг үзүүлэх нь онцгой чухал шүү гэдгийг хэлэхийг хүсэж байна. Сая өнгөрсөн энэ 2025 онд хэрэгжүүлж байгаа энэ Цагаан алт, Атрын 4 дүгээр аян амжилттай хэрэгжиж энэ эдийн засгийн ийм эерэг тоо гарахад бол Монголбанкны бодлогын дэмжлэг үүрэг их өндөр байсан. Би дахин Монголбанкны хамт олондоо талархал илэрхийлэхийг хүсэж байгаа.

Тэгээд 2026 ондоо бас хамтран ажиллана гэдэгтээ итгэлтэй байна. Баярлалаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Ганбатын Очирбат.

Г.Очирбат: Монголбанкныхандаа энэ өдрийн мэндийг хүргэе.

Энд сууж байгаа Их Хурлын гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Тэгээд манай Монголбанкныхантай би өчигдөр ч уулзсан урьд нь ч хэлж байсан. Улс төрч нарын сонгуулиас сонгуулийн хооронд оноо авах гэж байгаа янз бүрийн төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх тэнд бодлогоор дэмжиж хүүгийн татаас өгдөг. Энийгээ ер нь таслан зогсоох хэрэгтэй шүү. Монголбанк шийдвэр гаргахдаа улс төрийн нөхцөл байдал, нийгмийн нөхцөл байдал, эдийн засгийн нөхцөл байдал гээд

олон талаас нь харж шийдвэрээ зарчмын шийдвэрүүдээ гаргаж байх ёстой. Үндсэндээ Монголбанкны үндсэн зорилго бол төгрөгийн ханшаа л барих ёстой, инфляцыг буулгах ёстой. Бид нар төгрөгийн ханш валютын эсрэг тэдэн хувиар суларч байна гэхээсээ илүүтэйгээр тэдэн хувь чангарчихлаа гэдэг ирээдүйг хүсэж байгаа шүү. Инфляц бид нар 2 оронтой тоо руугаа арай алдчихаагүй байна гэхээсээ илүүтэйгээр бид нар инфляц 2, 3 хувь руу орж байна гэдэг ийм ирээдүйг хүсэж байгаа юм шүү.

Дотооддоо хийж болох аж үйлдвэрийн салбар ялангуяа инфляцад нөлөөлдөг өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийг дотооддоо хийх төсөл хөтөлбөрүүдийг бодитойгоор дэмжиж үр дүнг нь хармаар байгаад байгаа юм. Уриа лоозонгоор биш би урьд нь асууж байсан. Шинэ хоршоо гээд л хэдэн 100 сая төгрөг гаргаад явуулсан. Үр дүн байхгүй өнөөдөр намар болж байна. Одоо ингээд намар 10 сар гарчихсан. Махны ханш, хонь, үхрийн махны үнэ хэдтэй байна вэ? Тэр төсөл хөтөлбөрийн үр дүн нь уул нь ингээд ард иргэд дээр махны ханш буучихсан, малын тоо сүрэг өсчихсөн ийм байдлаар гарах ёстой байсан байхгүй. Хүнсний хувьсгал гээд явсан олон компаниудыг дэмжиж асар их хэмжээний татаас өгч явсан. Өнөөдөр манай тариаланч нар ямар байдалтай байна? Гол үйлдвэрлэдэг нарийн ногоо, төмс байцай, ханш ямар байна? Төсөл хөтөлбөрүүдийн үр дүн гарсан уу, гараагүй юу? Би бол гараагүй гэж үзэж байгаа. Одоо цагаан алт гээд явж байгаа үр дүн нь удахгүй ямар байдлаар тайлагнаж гарах юм байгаа юм хүлээж байгаа шүү. Хэрвээ энэ төсөл хөтөлбөрүүдийн үр дүн олигтой гарахгүй байх юм бол Монголбанкныхны маань ажил муу байна л гэсэн үг.

Нэг гоё тоо яриад бие биеийгээ гоё үг өгүүлбэрээр магтаж, нэг бол муулж суухаас илүүтэйгээр бид нар тоон дээр юмаа хараад яг бодитой үзүүлэлтүүдээ л ярьдаг ийм ирээдүйн, ийм цаг хугацааг хүсэж байгаа шүү. Тэгээд Лхагвасүрэн захирал сайн муу янз бүрээр хэлүүлж энэ хамт олонтойгоо энэ улс эх орны эдийн засаг мөнгөний бодлого инфляцыг барьж явж байгаа юм. Тэгээд илүү ажлаа нягтаршуулаад танд олон улс төрч нар нөлөөлж байгаа гэдгийг ч бид нар хөндлөнгөөс чинь харж байгаа юм. Шийдвэр гаргах ч аягүй хүнд байдаг гэдгийг чинь ч ойлгож байна. Тэгэхдээ л та Монголбанкны Ерөнхийлөгч, Монголбанкны хамт олон та хэд Монгол Улсын хар хайрцгийн эзэд шүү. Одоо нэг улс төрөөс ангид олон талыг харсан шийдвэрүүдийг гаргаарай. Урьд нь хэцүү байсан байх.

Хоёр удаагийн сонгуулиар Ардын намынхан олонхоороо болчихсон. Юм хийхгүй бол ажлыг чинь явуулдаггүй, гацаадаг, дарамталдаг юм байсан байх. Одоо тийм юм байхгүй шүү. 126 Их Хурлын гишүүнтэй болсон.

Бид үнэний талд, шударга ёсны талд Монголбанкны үндсэн зорилгын талд зогсоно шүү. Тэгээд асуудал байвал хамтдаа шийдээд явъя. Амжилт хүсье.

Х.Булгантуяа: Мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн тайлан, шийдвэрийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Эдийн засгийн байнгын хорооны саналаар санал хураалт явуулах ёстой байгаа.

Улсын Их Хурал дахь намын бүлгүүд, Улсын Их Хурлын гишүүд санал хураалтад орж ирцээ бэлдэж танхимдаа орж ирмээр байна.

Улсын Их Хурлын гишүүд Монголбанкнаас өргөн барьж Улсын Их Хурлаар хэлэлцүүлж байгаа мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн тайлан шийдвэрийн төсөл өнөөдөр Улсын Их Хурлын чуулганаар батлагдаж энэ 7 хоногт Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэх эсэх нь дэмжигдэж, ирэх 7 хоногт холбогдох Байнгын хороодоор орохоор байгаа.

Мөн үүний өмнө хэлэлцсэн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027, 2028 оны төсвийн төсөөлөл дээр нэг зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулахаар байгаа. Тийм батлагдах ёстой. Тэгэхээр гишүүн өнөөдөр үдээс хойш ирц их тааруухан байна. Тэгэхээр Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу санал хураалт явуулах цагийг маргааш нэгдсэн чуулган эхлэхэд нэгдсэн байдлаар явуулъя. Ингээд өнөөдөр Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцэх асуудлаа хэлэлцэж дууслаа. Маргааш Улсын Их Хурлын чуулганы хуралдаан 10 цагаас эхэлнэ ээ.

14.52 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА